

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, Пүрэв гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 7
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 - 111
1.	<i>Агаарын бохирдлын асуудлаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын мэдээллийг сонсох.</i>	21 - 94
2.	<i>“Тавантолгой түли” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох.</i>	94 - 107
3.	<i>Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх.</i>	107 - 111

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
12 дугаар сарын 19-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 18 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: П.Батчимэг, Г.Ганбаатар, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Н.Наранбаатар, У.Отгонбаяр;
Чөлөөтэй: Т.Аубакир.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Л.Мөнхбаясгалан нар Агаарын бохирдлын асуудлаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын мэдээллийг сонсох гэсэн хэлэлцэх асуудлын дараалалд орсон нэгдүгээр асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Л.Мөнхбаясгалан нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Бейсен: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Б.Баярбаатар, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Б.Найдалаа нар үг хэлэв.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн гаргасан, Агаарын бохирдлын асуудлаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын

даргын мэдээллийг сонсох асуудлыг хойшлуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ж.Чинбүрэн, С.Лүндэг, С.Замира, С.Ганбаатар нар үг хэлэв.

Хойшлуулах санал дэмжигдээгүй тул Агаарын бохирдлын асуудлаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын мэдээллийг сонсохоор тогтов.

Нэг.Агаарын бохирдлын асуудлаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Агаарын орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Цаг уур, орчин шинжилгээний газрын дарга Л.Оюунжаргал, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ч.Батзориг, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүү, удирдлагын газрын дарга Н.Отгонбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Марс-Од, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн дарга Ч.Буянжаргал, “Тавантолгой түлш” ХХК-ийн Санхүү, эдийн засгийн газрын дарга А.Батзориг, “Тавантолгой түлш” ХХК-ийн Ерөнхий технологич Д.Өлзийбат, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Д.Эрхэмбулган, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга О.Ганбат, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн цагдаагийн албаны дарга Б.Батсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, дэд дарга Ү.Амарбат, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах нар байлцав.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын мэдээллийг Агаарын орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Б.Бат-Эрдэнэ, Ж.Чинбүрэн, Ж.Батжаргал, С.Замира, Б.Найдалаа, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Б.Уянга, С.Ганбаатар, Ж.Золжаргал, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Агаарын орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Цаг уур, орчин шинжилгээний газрын дарга Л.Оюунжаргал, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ч.Батзориг, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн дарга Ч.Буянжаргал, “Тавантолгой түлш” ХХК-ийн Ерөнхий технологич Д.Өлзийбат, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Д.Эрхэмбулган, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга О.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг, Л.Мөнхбаясгалан, С.Замира нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Агаарын бохирдлын асуудлаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Агаарын орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Онцгой комиссын нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Цаг уур, орчин шинжилгээний газрын дарга Л.Оюунжаргал, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ч.Батзориг, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүү, удирдлагын газрын дарга Н.Отгонбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Марс-Од, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн дарга Ч.Буянжаргал, “Тавантолгой түлш” ХХК-ийн Санхүү, эдийн засгийн газрын дарга А.Батзориг, “Тавантолгой түлш” ХХК-ийн Ерөнхий технологич Д.Өлзийбат, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Д.Эрхэмбулган, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга О.Ганбат, Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн цагдаагийн албаны дарга Б.Батсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, дэд дарга Ү.Амарбат, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны

ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах нар байлцав.

“Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ч.Батзориг, “Тавантолгой түлш” ХХК-ийн Санхүү, эдийн засгийн газрын дарга А.Батзориг, “Тавантолгой түлш” ХХК-ийн Ерөнхий технологич Д.Өлзийбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, дэд дарга Ү.Амарбат, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен иргэдээс ирсэн өргөдлийн дагуу Утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах тухай асуудлыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: Утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголыг явуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, М.Ганхүлэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 88.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-т “Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж болно”, 122 дугаар зүйлийн 122.1-д “холбогдох Байнгын хорооны хуралдаанаар сонсгол даргалагчийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.” гэж тус тус заасны дагуу сонсгол даргалагч бөгөөд ажлын хэсгийн ахлагчийг сонгов.

Байнгын хорооны дарга Б.Бейсен Байнгын хорооны сонсгол зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулав.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан санал хэлэв.

Сонсгол даргалагч бөгөөд ажлын хэсгийн ахлагчид Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Л.Мөнхбаясгалан, С.Эрдэнэболд нар нэрээ дэвшүүлэв.

Б.Бейсен: Нэр өгсөн дарааллаар сонсгол даргалагч бөгөөд ажлын хэсгийн ахлагчид Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнг сонгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Б.Бейсен: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Найдалаа, С.Ганбаатар, Р.Сэддорж нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 94.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Ерөнхий хяналтын сонсголын даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Б.Бейсен: “Ерөнхий хяналтын сонсголын даргалагчийг сонгох тухай”
Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 2

Бүгд: 17

88.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 4 цаг 37 минут үргэлжилж, 24 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн
ирж, 70.8 хувийн ирцтэйгээр 18 цаг 55 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 18 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонхыг хүрэлцэн ирж ирц 58.3 хувьд хүрсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог нэрээр нь танилцуулъя.

Буланы Бейсен 3 дугаар тойрог ирсэн. Очирбатын Амгаланбаатар ирсэн, Тилеуханы Аубакир өвчтэй, Жигжидийн Ж.Батжаргал ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ ирсэн, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн, Сонгобайн Замира гишүүн ирсэн, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн, Загджавын Мэндсайхан гишүүн ирсэн, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн, Болдын Уянга гишүүн ирсэн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар гурван асуудал хэлэлцэх ёстой.

Нэгдүгээрт, Агаарын бохирдлын асуудлаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын мэдээллийг сонсох.

Хоёрт нь, “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хувьцаат компанийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаар Нийслэлийн Засаг дарга буюу Улаанбаатарын захирагч мэдээллийг сонсох.

Гуравдугаарт, Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гарсан иргэдийн өргөдлийг хэлэлцэх.

Энэ дагуу ажлын хэсэг байгуулах ийм гурван асуудал хэлэлцэх ёстой.

Гэтэл Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга маань Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр гээд явчихсан учраас өчигдөр бид албан ёсны чөлөө авсан.

“Тавантолгой түлш” хувьцаат компанийн талаар, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаар Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч мэдээлэл хийх ёстой байсан чинь газ, хийн асуудлаар түрүүн Бээжинд уулзалт хийгээд. Тэр Орос, Солонгос, Хятадын гурван улсын ажлын хэсгийнхэн сая 12.00 цагт буусан.

Тэгээд тэр улсууд, нөгөө томчууд нь өнөөдөр яг газар дээр нь очоод танилцаад орой шөнийн цагаар буцаад явах юм байна. Нөгөө шинжээч нар нь энд үлдэх юм байна.

Тийм учраас энэ хоёр асуудлыг хойшлуулъя гэж байна.

Гурав дахь асуудлыг. Гишүүд хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Байхгүй. З.Мэндсайхан гишүүн, С.Одонтуяа гишүүн хоёр.

Эхлээд З.Мэндсайхан гишүүн асууя.

З.Мэндсайхан: Байнгын хорооны дарга аа, Шадар сайд мэдээлэл өгөх боломжгүй байгаа юм байна. Тэгээд үүнийгээ орлож байгаа хүн байдаггүй юм уу? Энэ асуудал чинь асуудал болоод байхад хэзээ гэж хойшлуулж байгаа юм? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр хотын дарга энэ дээр мэдээлэл өгөх ёстой биш үү. Утааны асуудлыг чинь. Тэгээд яагаад хойшлуулаад байгаа юм?

Б.Бейсен: Шадар сайд өчигдөр орой албан ёсоор Их Хурлын даргад хэлээд чөлөө авсан.

Яагаад гэвэл Оросын Холбооны Улс, Засгийн газар хоорондын хэлэлцээрээр явсан.

Х.Нямбаатар дарга бол нөгөө газ, хийн асуудлаар Солонгос, Орос, Хятадын гурван улсын захирлууд нь ирж байгаа юм байна. Хөрөнгө оруулагчид нь. Хөрөнгө оруулагчид нь юуны асуудлыг ер нь бид шийдье гэдэг асуудал тавьсан юм байна. Тэр дагуу сая 12.00 цагт тэр улсууд нь буусан. Томчууд нь орой шөнийн цагаар буцаад явах юм байна.

Шинжээч нар нь үлдээд газар дээр нь танилцах юм байна. Тэр асуудлаар өнөөдөр хойшлуулж өг гээд хойшлуулсан. Орлогч нь бас ирчихсэн байгаа.

З.Мэндсайхан гишүүн тодруулъя.

З.Мэндсайхан: Б.Бейсен дарга аа, ингэж асуудалд хандмааргүй байна.

Томчууд ирсэн учраас хурал хойшлуулна гэж юу байдаг юм. Томчууд гэж хэн юм. Энэ ард түмэн чинь хамгийн том нь биш юм уу. Улаанбаатар хотын иргэд агаарын бохирдлоос болоод амьдрах эрх нь зөрчигдөөд байна. Үр хүүхэд ханиад томуу дийлдэхээ байлаа гээд яриад байхад том дарга нар ирсэн учраас асуудлыг хойшлуулна гэж юу яриад байгаа юм. Том дарга гэж хэн юм? Ямар үндэслэлээр ярьж байгаа юм? Энэ дарга нарыг чинь орлодог хүмүүс байдаггүй юм уу? Ингэж Байнгын хороо наад асуудалд ийм хөнгөн хуумгай хандмааргүй байна шүү.

Б.Бейсен: 3.Мэндсайхан гишүүн тантай санал нэг байна.

Жинхэнэ хөрөнгө оруулах компанийнх нь захирлууд нь, асуудлыг шийдсэн компанийн захирлууд нь ирсэн байна. Уучлаарай. Би томчууд гээд ярьснаа.

Энэ асуудал дээр тэр улсууд нь газар дээр нь танилцаад орой шөнийн цагаар буцах юм байна.

Шинжээч нар нь дараа үлдээд газар дээр нь танилцах ажлаар ингээд явчихсан учраас хойшлуулж өгөөч ээ. Бид албан ёсоор дараагийн ирэх долоо хоногт Байнгын хороо хуралдвал тэр дээр танилцуулъя гэсэн.

Хурал зарлаж байгаа асуудал маань өчигдөр л бид нарт мэдээлсэн л дээ. Урьд нь энэ утааны асуудлаар ажлын хэсэг байгуулъя гээд өнгөрсөн долоо хоногт даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцээд шийдсэн.

Тийм учраас ажлын хэсэг нь томилоод ажиллуулж байх хооронд шинжээчээ бас томилж болно. Тэр хооронд нөгөө дарга нар маань ирсэн хойно нь албан ёсны сонсголыг нь сонсоод.

3.Мэндсайхан дарга асууя.

3.Мэндсайхан: Б.Бейсен гишүүн ээ, ингэж Байнгын хорооны дарга хариуцлагагүй ажилламааргүй байна.

Хоёрдугаарт, тэр утааны онцгой байдлын хурал дээр нэг нөхөр, нийслэлийн тэр бохирдол хариуцсан нөхөр юм уу, ямар албан тушаалтай юм. Нэг нөхөр бүр тавлаад зогсож байна лээ шүү дээ. Ард түмнийг доромжлоод.

Утаа мэдрэгчээ ажиллуулахгүй байгаа учраас утаа дийлдэхээ байчихлаа. Төрөөс өгсөн буян хишгийг хадагт ороогоод хураачихсан учраас утаа нэмэгдээд байгаа юм гэж.

Ийм байдлаар асуудалд хандаж байгаа даргатай. Тийм ээ. Тэгээд нийслэлийн дарга. Энэ ард иргэдийн асуудлыг.

Том дарга нар ирсэн учраас энэ хуралдааныг хойшлуулъя гээд сууж байдаг Байнгын хорооны дарга. Ийм хүмүүстэй энэ утаа явахгүй байх аа. Ингэж асуудалд хандаж болохгүй байх аа. Та энэ хуралдаанаа үргэлжлүүл.

Хуралдаан зарлах гэж. Энэ утааны асуудал гэдэг нийгмийн бухимдал болсон асуудлыг шийдвэрлэе. Ямар асуудалтай байгааг ард нийтэд нээлттэй мэдээлэл өгье гэж энэ Байнгын хорооны хуралдааныг зарлаж байгаа болохоос биш хэн нэгэн том дарга ирчихлээ, том даргад таацуулаад хуралдааныг хойшлуулъя гэдэг байдлаар явж байгаа бол та наад ажил өг.

Б.Бейсен: 3.Мэндсайхан дарга аа, би ч бас танд адилхан гишүүний хувьд энэ ажлыг зохион байгуулаад энэ долоо хоногтоо албан ёсоор хийгээд, өнгөрсөн долоо хоногийн гишүүдийн ихэнх нь байхгүй байсан шүү дээ.

Тийм учраас орлогч нь ирсэн байгаа. Албан ёсны мэдээлэл хийг. Орлогчоо оруулаач. Х.Нямбаатар даргын.

Тэгвэл энэ хоёр асуудал дээр санал хураая. Яагаад гэвэл Онцгой комиссын дарга, Шадар сайд маань Засгийн газар хоорондын.

Л.Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Утаа, агаарын бохирдол дээд цэгтээ хүрчхээд нийгмийн уур амьсгал маш хүнд байна шүү дээ. Энд маш олон хохирогч байна. Хүмүүс эмнэлэгт маш их хэвтэж байна, өвчлөл их байна, асуудал их байхад бид хойшлуулж болохгүй.

Х.Нямбаатар даргыг байхгүй байна гээд түрүүчийн удаа манай Байнгын хороод дахиад асуудлыг хойшлуулсан шүү дээ. Одоо тэгээд дахиад хойшлуулж болохгүй гэж бодож байна.

Одоо энд байгаа төрийн албан хаагчид, ажил хариуцаж байгаа хүмүүсийг оруулж ирж бид асуудлыг ярилцаж танилцах хэрэгтэй.

Шадар сайдыг орлож байгаа хүн байгаа биз дээ? Дахиад долоо хоногоор хойшлох юм уу? Бид нар тэгээд. Ингэж болохгүй байх аа.

Б.Бейсен: Гишүүдээс ийм санал гарч байгаа учраас санал хурааж байгаад шийдээд. Ажлын хэсэг нь бүрэн байна уу? Дарга нар.

Дарга нар нь байхгүй бол хариулж чадахгүй болов уу гээд. Албан ёсоор С.Амарсайхан сайд өчигдөр орой чөлөө хүссэн. Сая Их Хурлын дарга ч тэгж байна.

С.Одонтуяа сайд, дараа нь Б.Баярбаатар гишүүн.

С.Одонтуяа: Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Би бас нэг товч мэдээлэл өгье.

Өчигдөр Засгийн газар хуралдаад 2023 онд татан буугдсан байсан Орчны бохирдлын Үндэсний хороог одоо дахин сэргээн байгуулах ийм шийдвэр гарсан.

Үндэсний хорооны даргаар нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, гишүүдээр нь Засгийн газрын гишүүд, нэмээд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Онцгой байдал, Цагдаа гээд нэлээн хэдэн байгууллагууд орсон байгаа.

Тэгэхээр дөнгөж энэ тогтоол сая албажиж гарлаа. Энэ дагуу Үндэсний хорооны ажиллах журам, төлөвлөгөөнийхөө ажилд орсон.

Тэгэхээр Үндэсний хорооны хийх гол ажлууд юу вэ гэхээр нэгдүгээрт яаралтай хийх ажлууд болон дунд урт хугацаанд бид ямар ажлуудыг хийх юм бэ гэдэг төлөвлөгөөгөө гаргаж, үүнийгээ Улсын Их Хурал, бусад салбар яамд, нийслэл, аймаг, дүүрэгтэй уялдаатай ажиллах энэ уялдааг хэрхэн хангах талаар ажиллах байгаа юм.

Яагаад гэхээр өмнө нь энэ хороог татан буулгаад нийслэлд бүх асуудлыг шилжүүлсэн хэдий ч уялдаа холбоогүй байна. Яамдын Засгийн газрын дэмжлэг байхгүй байна гэдэг үүднээс энэ бүх уялдааг хангаж ажиллах үүрэг өгсөн байгаа.

Мөн ард иргэдэд үнэн зөв мэдээллийг тогтмол ойлгомжтой хүргэх асуудлыг хийгээд эхэлж байна. Хүмүүс хэмжилтүүд нь олон янз байна гэдэг ийм гомдлууд ирж байгаа.

Тэгэхээр ямар стандартаар хэмжээд байгаа юм, үнэн хэмжээд байна уу буруу гэдэг энэ бүх эргэлзээг тайлах асуудлуудыг хийнэ.

Гуравдугаарт, энэ түлшний талаар чухал мэдээллүүдийг өгнө.

Үнэхээр энэ хүний биед хоргүй байгаа юм уу, орц нь ямар байгаа юм, технологийн дараалал, хатаалга гээд энэ бүх зүйл дээр ажиллана.

Цаашдаа ер нь дулаалгын асуудлыг яаж шийдэх юм, цахилгаан руу яаж шилжих юм, хийн асуудал яаж шилжих юм. Өмнө нь түүхий нүүрснээс сайжруулсан түлш рүү шилжиж байсан үе байсан. Одоо сайжруулсан түлшнээс дараагийн шилжилт рүү хэрхэн шилжих вэ гэдэг асуудлуудыг шийднэ.

Мөн түүхий нүүрсний асуудлууд байгаа. Зөвшөөрөлтэй бөгөөд зөвшөөрөлгүй түлж байгаа ийм хэсэг байгаа. Зөвшөөрөлтэй хэсгүүдийг хэрхэн технологийн шинэчлэлийг хурдан хийж утаагүй болгох юм бэ гэдэг асуудлууд байна.

Мөн зөвшөөрөлгүй түлж байгаа асуудал дээр ямар захиргааны арга хэмжээнүүд авах вэ, үүнийг хэрхэн зогсоох вэ гэдэг зүйл. Нөгөөх нь нэлээд хэсгийг эзэлж байгаа автомашины утааны асуудал байгаа.

Тэгэхээр ийм зүйлүүдийг. Мөн хэрхэн ногоон шилжилт рүү шилжих вэ, цахилгаан автомашиныг хэрхэн дэмжих вэ. Улсын Их Хурлаар энэ хуулийг оруулж шийд.../минут дуусав/

Б.Бейсен: Б.Баярбаатар гишүүн асууя.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын гишүүддээ, Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ.

Өнөөдрийн хурал Байнгын хорооны бүрэлдэхүүнд байхгүй миний бие, Хүний эрхийн дэд хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, манай хүний эрхийн хуульч Х.Баасанжаргал бид гурав оролцож байгаа юм.

Нийгмийн бухимдлыг ганцхан энэ жил ч төрүүлээд байгаа зүйл биш л дээ. Энэ утааны асуудал. Олон жил ярьж байгаа. Олон жил олон тэрбум, хэдэн 100 тэрбумаар тоологдох, их наядар тоологдох хэмжээний төсөв мөнгө зарцуулчихсан.

Тэгээд өнөөдөр ингээд утааны асуудал нь жилээс жилд нэмэгдээд ингээд яваад байж байгаа. Тэгээд хамгийн гол нь үүний цаана монгол хүний эрүүл мэндийн асуудал байгаа.

Тэгээд энэ дээр бид ингэж ийм хариуцлагагүй хандаж болохгүй. Бид гурав өнөөдөр энэ Байнгын хорооноос байгуулагдах ажлын хэсэгт, сонсгол зохион байгуулах ажлын хэсэгт орохоор орж ирсэн гурван гишүүн байж байгаа.

Тэгээд одоо нэгэнт ингээд Б.Бейсен дарга аа, энэ Шадар сайд чинь байхгүй юм байна хотын дарга нь байхгүй юм байна. Одоо тэгээд байхгүй байхад бид цаг үрээд яах вэ дээ.

Дараагийнхаа асуудлууд руугаа ороод. Тэгээд бид хүч нэмье. Харин. Дараа дараа дээр чинь хүч нэмээд шаардлагаа өндөр тавья. Тэгээд ажлын хэсгээ харин яаралтай байгуулаад ажилдаа ороод явах нь зөв болов уу гэсэн ийм саналтай байна.

Тэгээд тэр ажлын хэсэг дээр одоо саяын С.Одонтуяа сайдын хийж байгаа мэдээлэл ажлын хэсэг дээр дахиад явах болов уу гэж бодож байна. Үүнээс цаашаа нарийвчилсан мэдээллүүд орж ирэх болов уу. Тэр дээр өшөө нарийн нарийн зүйлүүдээ ярих ийм боломж байгаа. Одоо гол нь бид яаравчлах л зайлшгүй шаардлага байна.

Б.Бейсен: Гишүүдийн саналын дагуу санал хураагаад явчихъя.

Нэгдүгээр асуудлыг хойшлуулъя гэсэн дээр санал хураая. /алх цохив/

Ж.Батжаргал гишүүнд тэгээд санал гаргах уу?

Ж.Батжаргал: Саяын санал хураалт дээр би дэмжиж санал өгсөн юм. Хурууны хээ уншигдсангүй.

Тийм учраас эсрэг гарч байна. Санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна.

Б.Бейсен: Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. /алх цохив/

Минийх бас эсрэг гараад байна. Б.Бат-Эрдэнэ гишүүн санал гаргая. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг.

Б.Бат-Эрдэнэ: Үгүй тэгээд хоёр удаа санал хураалаа шүү дээ. Сонсчихмоор байгаа юм аа, Ж.Чинбүрэн гишүүн ээ.

Би үгээ хэлчих үү. Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд би үгээ хэлчихье. Одоо дандаа таны үгэнд орно гэж юу байх вэ дээ. Сайд байхдаа хүртэл таны үгэнд ороод л явлаа.

Энэ үүдээр дүүрэн албан тушаалтнууд чинь байгаа байхгүй юу даа. Технологийн асуудлуудтай холбоотой юмнуудаа бас яримаар байна шүү дээ. Технологийн горим зөрчигдчихөөд байгаа юм уу. Яагаад ийм их хэмжээний утаа гараад байгаа юм. Тэр инверс нь юм уу, үгүй юм уу.

2022 онд би сайдаар томилогдоод бид нэг арга хэмжээ авч ажиллаж байсан. Олон арга хэмжээг Ерөнхий сайдын үүрэг даалгавраар ажиллаж байсан л даа.

Бид өнөөдөр хатаалттай холбоотой асуудлууд хүртэл яриад байгаа шүү дээ. Ерөнхийлөгч бас хэлээд л байна лээ. Тэгээд энэ технологийн горимын алдаа гараад байгаа юм биш үү. Эсвэл тэр “Энержи Ресурс”-ээс авч байгаа нөгөө мидлинг нь өнөөдөр яг ямар түвшиндээ очоод тэр мидлинг нь аваад байгаа юм, авахгүй байгаа юм. Өөр газраас авч байгаа юм уу, үгүй юм уу. “Эрдэнэс Тавантолгой” компани өгнө гээд байсан. Тэндээсээ авдаг болсон юм уу, үгүй юу.

2018 оноос эхлээд тэр “Энержи Ресурс”-ээс тэр мидлингийг нь авч эхэлсэн шүү дээ. Тэгээд үүний одоо бараг үлдсэн хэсэг үлдэгдлийг нь аваад байгаа юм уу, үгүй юм уу гээд ингээд ярих юмнууд аягүй их байгаа байхгүй юу.

Тэр заавал даргатай даргагүй өгөх ёстой мэдээллүүдээ албан тушаалтнууд нь үүдээр дүүрэн байж байна. Өгөг л дээ. Энэ чинь өнгөрсөн удаа Байнгын хорооны хурал дээр бас л үүнийг хэлээд л. Би одоо яг тэнд сууж байгаад л үгүй

энэ дарга нар нь байхгүй байна. Нэг удаа хойшлуулчихвал яах юм гээд л би санал гаргаж байсан гишүүдийн нэг.

Тэгээд өнөөдөр энд сонсох ёстой юмнуудаа сонсоод, яаралтай энэ Улсын Их Хурлын даргын захирамжаар юм шиг байна лээ. Тэр нэг ажлын хэсэг бас байгуулагдах гэж байгаа юм шиг байна лээ шүү дээ. Тэр лүүгээ хурдан шуурхай орохгүй бол. Одоо дахиад дараагийн салхи нь хэзээ гарах вэ гээд бид хүлээгээд суугаад баймааргүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ технологийн горимтой холбоотой бусад маш олон асуудлууд байгаа. Одоо Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас жишээлбэл хяналт шалгалтын ажил хийсэн. Тэнд нь тос түлж байна ч гэх шиг ингээд юмнууд илэрсэн энэ тэр гээд юм яриад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ нийгэмд чинь үнэн худлаа нь мэдэгдэхгүй мэдээллүүд яваад байгаа энэ цаг хугацаа. Тэгээд энэ дээр бас тодорхой хэмжээнд эндээсээ албан ёсны мэдээлэл мэдэгдлүүдээ гаргаад явж байвал бас зүгээр юм болов уу л гэж бодож байна.

Тэгээд сая 9, 7-гоор уначихлаа. Хүчингүй болгоё гэсэн. Ахиад хүчингүй болсонгүй. Одоо тэгээд дахиад хойшлуулах гээд гар өргөнө гэдгийг бол зөвшөөрмөөргүй байна. Эсвэл нэгмөсөн угаасаа хойшлуулах зорилготой байгаа юм аа. Та нар дуугүй байж бай гээд ингээд учраа олчихмоор байна.

Санал хурааснаараа явъя.

Б.Бейсен: Л.Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Манай хурал долоо хоногийн өмнө зарлагдсан. Тийм ээ. Тав дахь өдөр зарлагдсан шүү дээ. Тийм ээ. Өнөөдрийг хүртэл энэ ажил хийж байгаа хүмүүс мэдээллээ бэлтгээд өнөөдөр энд ажлаасаа гарч энд ирээд хүлээж байгаа. Энэ хүмүүс ажил хийж байгаа. Бид энэ хүмүүсийн үгийг сонсох ёстой.

Яагаад ганцхан даргын үгийг сонсох ёстой юм. Бид нар. Хэрвээ дарга шийддэг байсан юм бол бид утаанаас өнөөдөр салчихсан байх ёстой биз дээ. Гишүүд ээ, үүнийг ойлгох хэрэгтэй. Энэ хүмүүс бэлдээд ирж байгаа байхгүй юу. Цаг заваа гаргаад.

Тэгэхээр бид үүнийг сонсоод тэртээ тэргүй мэднэ гэж бид ерөөсөө тэгж болохгүй. Нэг даргын царай хараад яадаг юм. Тэр дарга байсаар л байсан. Асуудал шийдэгдээгүй шүү дээ. Өнөөдөр.

Тэгэхээр энэ ажил хариуцаж байгаа хүмүүсийн мэдээллийг сонсоод ярилцаад явъя л даа. Ажлаа хийе л дээ. Хэдүүлээ. Ийм саналтай байна.

Одоо дахиад бүр энэ хурлыг байхгүй болготол нь санал хураах юм уу. Тэгвэл шууд одоо энэ сайтуудыг оруулж ирж байгаад хэдүүлээ LIVE хийгээд хэдий болтол үзэх юм тэгээд үзэж байгаад байхгүй болгоё л доо. Хурлаа.

Б.Бейсен: Б.Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Ямар ч байсан сая санал хураалт дээр энэ яах аргагүй ажилласангүй. Хэд хэдэн гишүүнийх. Минийх ажилласангүй.

Тэгэхээр энэ дээр ингээд энэ чигээр нь шийдэж болохгүй. Дахиж санал хуруулахыг хүсэж байна.

Хоёрт, бид одоо яг ингээд ярилаа гээд дарга нар нь байхгүй, гишүүд өөрсдийгөө л нэг товойлгосон улс төр л болно шүү дээ. Шийдэл байхгүй шүү дээ.

Тэгээд нэгмөсөн тэр ажлын хэсгээ томилж байгаад дараа нь арай буурьтай суурьтай явсан нь зөв байх.

Б.Бейсен: С.Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Энэ ийм байгаа юм. Манайхан. Энэ асуудал бол Б.Бейсен дарга аа, зөвхөн энэ Байнгын хорооны асуудал биш.

Энэ дээр яах вэ гэхээр Төсвийн байнгын хороо орж ирэх ёстой, Хууль зүйн байнгын хороо орж ирэх ёстой, манай Ёс зүй, дэгийн байнгын хороо орж ирэх ёстой, Хүний эрхийн дэд хороо орж ирэх ёстой.

Яагаад гэхээр иргэний амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх гээд эрхийн асуудал орж ирнэ.

Өөрөөр хэлбэл энэ бол нэг Байнгын хорооны хэмжээний асуудал биш. Энэ бол Байнгын хороод дундын буюу Улсын Их Хурал, мөн Засгийн газрын зарим бүтцийн байгууллагууд, хот орж ирээд ийм том ажлын хэсэг байгуулах ёстой гэж үзэж байгаа юм.

Тэр утгаараа Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцээд Д.Цогтбаатар дарга, Х.Баасанжаргал гишүүн, миний бие бид гурвыг Хууль зүйн байнгын хорооноос томилсон. Энэ ажлын хэсэгт ороорой гэж.

Тэгээд өөрөөр хэлбэл ингээд Төсвийн байнгын хороон дээр ч гэдэг юм уу, ингээд бусад Байнгын хороонууд дээрээс ингэж гарч ирнэ.

Тэгэхээр яах вэ гэхээр Байнгын хороод дундын ажлын хэсгээ байгуулаад, Б.Бейсен дарга аа, ажлын хэсгээ байгуулаад энэ асуудал дээр маш хурдан нухацтай авч үзэх хэрэгтэй байгаа юм.

Тэгэхгүй болохоор ингээд хойшлуулаад байж болохгүй байгаа юм. Нэг.

Хоёрдугаар асуудал нь болохоор зарим гишүүд маань энэ мэддэг сэдэв ярина гэж яриад байгаа. Түүрэн Л.Мөнхбаясгалан гишүүний яриад байгаа, Б.Бат-Эрдэнэ гишүүний яриад байгаа үндэслэлтэй зүйл нь иргэдийн мэдэх эрхийг бид ингээд явц дундаа хангах ёстой юм. Өөрөөр хэлбэл иргэдийн мэдэх эрхийг хугацаа алдахгүйгээр хангаж байх ёстой.

Дээрээс нь энэ Байнгын хороогоо бас мэдээлжүүлж байх ёстой болчхоод байгаа юм.

Тэгэхээр нэгэнт одоо ингээд дэгээр юу байхгүй учраас саяынхаа шийдсэнээр шийдэж яваад тэр дараагийн ажлын хэсэг байгуулах ажил руугаа яаралтай орчихмоор байна.

Гэхдээ ажлын хэсэг байгуулахдаа ингээд аль болохоор олон Байнгын хороо хамтарсан. Тэгэхдээ маш чанартай, маш хурдтай ажиллах юм орохгүй бол одоо энэ Байнгын хорооноос ажлын хэсэг гардаг, сонсгол нь сонсголын тов чинь бас хугацаатай байгаа шүү дээ. Хугацаагаа тавиад яаралтай явахгүй бол нэг цагаан сар гээд л энэ сэдэв чинь ингээд улс төрийн хувьд бүгдээрээ мартагначихдаг.

Тэгээд манай Хууль зүйн байнгын хорооноос 8 сарын 14-нөөс хойш энэ сэдвээр асуултууд явуулаад, мэдээлэл цуглуулаад сонсгол хийхээр явж байсан боловчиг нөгөө хүний эрхтэй холбоотой эрүүдэн шүүлтийн сонсгол болчихсон учраас нэг Байнгын хороон дээр олон сонсгол давхцаж болохгүй гэдэг журмын дагуу танай Байнгын хороо руу энэ асуудал нь сэдвийн дагуу ороод ирчихсэн байгаа.

Одоо болохоор ингээд дундын ажлын хэсгийг яаралтай байгуулаад явъя.

Энэ дээрээ харин тэр Шадар сайд, тэр хотын дарга, эрх мэдэл албан тушаалтай, хариуцлага хүлээх эцсийн үг нь, эцсийн шийдвэр гаргагч тэр хүмүүсийг нь дуудаж байлцуулж байгаад яриагаа явъя гэсэн тийм л одоо санал л байна.

Тэгээд эхэлтлээ энэ чинь аягүй удлаа шүү дээ. Тэгээд эхэлсний дараагаар хэлэлцэх асуудлаа батлаад гялалзуулахгүй болохгүй байгаад байна. Тэгээд цаг тулчихсан байгаад байна шүү. Яаравчилмаар байна.

Б.Бейсен: Ж.Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Байнгын хороон гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Тэгэхээр би одоо ерөөсөө энэ гадаа талбай 70 гаруй мянган иргэд энэ утааны асуудал, эрүүл мэндтэй холбоотой, амь нас үрэгдэж байгаа энэ асуудал ноцтой байна гэдгийг гарын үсэг зураад e-parliament-аар энэ иргэдийн мэдэх эрхийг хангах нийтийн сонсгол хийх энэ хууль эрх зүйн орчин үүсчхээд байгаа.

Бид өнөөдөр энэ Шадар сайдын болон энэ Тавантолгойн түлшний мэдээлэл бидэнд цаасаараа ирчихсэн байгаа. Бид үүнийг уншчихсан.

Одоо бид яах вэ гэхээр нэгэнт ард түмнээ төлөөлж сууж байгаагийн хувьд энэ хэн нь хаана ямар алдаа гаргаад байгаа юм, хэн нь юу болохгүй байгаа гэдгийг олон нийтэд мэдэх эрхийг нь олгох энэ нийтийн сонсголд бэлтгэх хороог байгуулах ёстой.

Тэгэхээр энэ ажил руугаа илүү орох нь чухал гэж бодож байна. Нэгэнт хариуцлагаа энэ ажлыг зохион байгуулж удирдаж байгаа улсууд нь өөрсдөө байхгүй байна. Одоо харж байгаарай. Бид ингээд сонсоно, ярина. Тэгэнгүүтээ баахан гишүүд тэгэхгүй яасан юм, ингэхгүй яасан юм гээд ярихаар хариулт хэлэх нэг ч хүн байхгүй сууна.

Тэгэхээр бид өөрсдөө юмаа уншдаг биз дээ. Урд байгаа юмнуудаа уншчихсан, харчихсан, хаана юу байгаагаа мэдчихсэн. Харин олон нийтэд мэдэх эрхийг нь хангахын төлөө хэдүүлээ маш хурдтай ажиллах тэр ажлын хэсэг хийх байгуулах ажил руугаа, гурав дахь асуудал руугаа орсон нь илүү хурдан байх болов уу гэсэн ийм бодолтой байна.

Тэгээд энэ саналыг дахиж хураалгаж өгөөсэй л гэж хүсэж байна.

Б.Бейсен: Урьд нь хоёр удаа санал хураагаад уначихлаа шүү дээ. Тэгээд тоног төхөөрөмж ажил өгөөд 3 гишүүн хэллээ.

Тийм учраас мэдээллээ сонсчихвол яасан юм, ер нь С.Одонтуяаг сайд, Засгийн газрын гишүүн одоо танилцуулбал яасан юм. С.Одонтуяа сайд танилцуул. Ажлын хэсэг оруул.

Тэгвэл хэлэлцэх асуудлаа баталчихъя. С.Лүндэг гишүүний микрофон өгье.

С.Лүндэг: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгээд асуудал ямар хурц байгааг аягүй сайн мэдэж байгаа. Утааны асуудлыг анх шийдэл гарахаас нь эхлээд энэ ажилд оролцож явсан хүний хувьд энэ асуудлыг маш сайн мэдэж байгаа.

Тэгэхдээ өнөөдөр бид энд нэг ийм аягүй тийм муухай жишиг тогтоох гээд байна шүү. Наад төхөөрөмж чинь ажиллахгүй байна шүү дээ. Тэгээд үүнийгээ нэг болохоор ашигтайгаар аль талдаа ингэж ашиглагдаа болимоор байна.

Тэгэхээр би таны саяын энэ шууд бидний саналыг асуулгүйгээр танилцуулга хийх гээд байгаа чинь энэ аягүй том буруу жишиг болно шүү. Тэгээд төхөөрөмж ажиллахгүйгээс болоод л аль дуртай талдаа ашиглаад байдаг ийм буруу жишиг тогтоож болохгүй ээ.

Тэгэхээр үнэхээр ажиллаагүй гээд хэлээд байгаа энэ гишүүдийнхээ үгийг бас сонсох хэрэгтэй. Үүнийгээ нэг талдаа гаргах хэрэгтэй. Эсвэл одоо бүр энэ төхөөрөмжийнхөө асуудлыг ер нь яривал яасан юм. Дандаа л ийм асуудал үүсэж байх юм.

Тэгэхээр миний хувьд би таныг одоо шууд залгуулаад санал асуухгүйгээр явах гэж зөвшөөрөхгүй шүү.

Б.Бейсен: Төхөөрөмж ажиллаагүй хийгээд шууд гараа өргө дөө. Минийх ажиллаагүй. Тийм ээ.

Төхөөрөмж ажиллаагүй учир одоо дахиад урд юугаа хүчингүй болгоод санал хураая. Сая гишүүдийн санал гарлаа. Энэ хариуцах эзэн нь байхгүй. Тэгээд тодорхой юм байхгүй. Өнөөдөр ажлын хэсгээ байгуулъя гээд ихэнх гишүүд ярьж байгаа учраас Б.Найдалаа гишүүн санал гаргая. С.Лүндэг гишүүн ажиллаагүй гэсэн үү. Тийм ээ.

С.Замираа гишүүн санал гаргая гэж байна.

С.Замира: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Одоо ер нь энэ Байнгын хороог тоохгүй байгаа юм уу. Байнгын хороо гэдэг чинь төрийн албан ёсны Их Хурлаас томилогдсон. Их Хурлын дарга бид нарт даалгасан ажил шүү дээ энэ чинь. Утааны асуудал гэдэг чинь.

Ард түмэн өдрөөс өдөрт эрүүл мэндийн хохиролд учраад амь нас хүртэл яригдаад байхад ийм эвгүй байдалд оруулмаар байна шүү.

Тэгэхээр нэгэнт төрийн түшээд хариуцаад сууж байгаа учраас энэ хүмүүст арга хэмжээ авах хэрэгтэй. Шадар сайд хэрвээ тийм томилолттой юм бол яах гэж бид нарыг өнөөдөр цуглуулсан юм. Тэр бүгдийг нь урьдчилан төлөвлөх ёстой шүү дээ.

Х.Нямбаатар дарга одоо хоёр дахь удаа ирэхгүй байгаа. Ер нь ажил хийхгүй бол ажил хийхгүй нь зөндөө байдаг шүү дээ. Нэгдүгээрт үүнийг хэлмээр байна.

Хоёрдугаарт, нэгэнт хариуцах эзэн нь байхгүй. Одоо яах вэ албан хаагчид нь ирээд нэг тайлагнана. Тэрийг бид гартаа авчихсан. Бичигээрээ ингээд танилцаж болж байна шүү дээ. Тэгээд тэр хүмүүс одоо дахиад бид нарт. Шийдвэр гаргах эрх байхгүй хүмүүс орж ирэх гээд байна.

Тийм учраас одоо энэ удаагийн юуг хойшлуулаад яг тухайн үед хэдний өдөр бид энд цуглараад тэр хоёр хүн хэзээ ирж бид нарт бүх юмаа тайлагнаад бид энэ асуудлыг нэг тийш нь болгох ёстой гэдэг өдрийг өнөөдөр товлоод тэгээд тэр үед

тэр хүмүүсийг байлгах л хэрэгтэй. Ингэж тоглоом тохуу маягийн юм болгож болохгүй.

Тийм учраас санал хураалтыг хүчингүй болгоод дахиад санал хураах гээд үзье. Одоо яах вэ ихэнх нь дэмжиж байвал энэ удаа хойшлуулъя. Тэртээ тэргүй хариуцлага эзэнгүй юм байна. Ийм санал хэлэх гэсэн юм.

Б.Бейсен: Б.Нандалаа гишүүний саналаар түрүүчийн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Нэгдүгээр асуудлыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Хойшлуулахыг дэмжих санал хураалт явуулъя. /алх цохив/

Энэ ерөөсөө л төхөөрөмж ажиллахгүй юм байна. С.Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би ирцдээ орсон. Тэгээд үүнийг сонсох ёстой гэдэг байр суурьтай байгаа. Үргэлж эсрэг талд нь байгаа. Энэ бол машин эвдрээгүй.

Өнөөдөр бид үүнийг хойшлуулах бараг ямар ч эрхгүйгээр хүнд байдал үүсчихсэн байгаа учраас сонсох ёстой. Харин би зүгээр нэг горимын асуулт байгаад байгаа юм. Байнгын хорооныхноос.

Ер нь Байнгын хорооны гишүүд бид ард иргэдийн сонгогдсон мандат авсан төлөөлөл. Х.Нямбаатар болон бусад Засгийн газрын сайд нар. Яг сайд нар бол ард түмнээс сонгогдоогүй шүү дээ. Биднээс ажил авсан улсууд.

Тэгэхээр өнөөдөр Байнгын хороог ийм үл хүндэлсэн байдалтайгаар асуудалд хандаад байхад харамсалтай байна.

Тэгээд хамгийн гол миний горимын асуулт бол асуудлаа яг хариуцсан шийдвэр гаргах ёстой хүмүүс нь заавал байх ёстой гэсэн Байнгын хорооны дүрэм журамд юм байна уу?

Эсвэл энэ сайд болон холбогдох хүмүүс нь байхгүй байхад мэргэжилтнүүдийг нь сонсчихсон байхад тэр нь тэгээд шийдвэрээ гаргаад явдаг юм уу? Энэ Байнгын хорооны эрх хэмжээ, статусыг муутгасан, багасгасан асуудал руу орчих уу, үгүй юу?

Өнөөдөр бид ард иргэдээс Улсын Их Хурлын мандат авсан энэ өндөр шийдвэр гаргах энэ статусыг бас хадгалах учиртай гэдэг утгаараа би энэ асуулт асууж байгаа юм. Энэ Байнгын хорооны дүрэм журамд одоо юу байна.

Уг нь би хуучин сонсоход дэд сайд байхад л бид хөөгөөд л гаргадаг байсан санагдаад байх юм.

Тэгээд одоо ямар шатандаа явсан юм бол? Өөрчлөлт орсон юм болов уу?

Б.Бейсен: Байнгын хорооны дүрэмд тийм журам байхгүй.

Тэгэхдээ өнөөдрийн юугаар бид мэдээллийг нь сонсох ёстой. Нийтийн сонсголыг дараа нь ажлын хэсэг байгуулж байгаад дараа нь шийдэх ёстой байхгүй юу.

Тэгэхээр мэдээллийг одоо гурван удаа санал хураагаад уначихлаа. Мэдээллийг нь сонсьё.

С.Одонтуяа гишүүнд танилцуулсан нь зөв байх гэж бодож байна.

Нэг.Агаарын бохирдлын асуудлаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын мэдээллийг сонсох

Уг нь мэдээллийг сонсох ёстой байхгүй юу. Нийтдээ сонсгол албан ёсны. Дараа хийнэ шүү дээ. Ажлын хэсэг томилж байгаад, шинжээч томилж байгаад хийгээд Их Хурлын даргад ийм чиглэл өгсөн.

Мэдээлэл нь нийт гишүүд тараагдсан байгаа шүү.

С.Одонтуяа: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгээд мэдээллийг уншиж танилцуулъя. С.Амарсайхан дарга гадаадад томилолттой явсан учраас мэдээллийг миний бие танилцуулъя.

Нэг.Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ, төлөвлөлт, агаарын бохирдлын өнөөгийн байдал эх үүсвэр.

Агаар бохирдуулагч эх үүсвэрийг судалгаагаар агаарын бохирдлыг авч үзвэл гэр хорооллын айл өрх 55.6 хувь, автомашин 28.9 хувь, бусад хүчин зүйлс 15.5 хувь тус тус эзэлж байна.

Гэр хороололд амьдардаг айл өрх 2023 онд 50.2 хувь байсан бол 2024 онд 44 хувь болж буурсан үзүүлэлттэй байна.

Агаар бохирдуулагч бодисын агуулгын хувьд $PM_{[particulate\ matter]}-2.5$ болон PM_{10} тоосонцор гэр хорооллын хувьд 17.6 хувь, автомашинаас ялгарах нь 52.3 хувь, бусад эх үүсвэрт 30.1 хувь байна.

Нүүрстөрөгчийн дутуу исэл нь гэр хорооллын хувьд 64.1 хувь, автомашинаас ялгарах нь 24.9 хувь, бусад эх үүсвэр нь 11 хувь байна.

Хүхэрлэг хий гэр хорооллын хувьд 71.7 хувь, автомашинаас ялгарах нь 3.8, бусад эх үүсвэр нь 24.5, азотын давхар исэл нь гэр хорооллын хувьд 28.2, автомашинаас ялгарах нь 63.2 хувь, бусад эх үүсвэр нь 8.6 хувийг эзэлж байна.

Судалгаанаас харахад хүхэрлэг хий болон нүүрстөрөгчийн дутуу исэл нь гэр хорооллоос PM2.5, PM10 тоосонцор болон азотын давхар исэл нь автомашинаас ялгарах утаанаас агаарын бохирдолд их нөлөө үзүүлж байна.

Агаарын бохирдлын ихээхэн хувийг автомашинаас үүдэлтэй бохирдол эзэлж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 712 мянга 992 автомашин 2022 онд бүртгэлтэй байгаагаас 74.2 хувь нь 10-аас дээш жилийн насжилттай байна.

Автомашин нь 0-ээс 5 километр цаг хурдтай явахад түүнээс ялгарах хорт бодисын хэмжээ энгийн үеэс 2-оос 3 дахин их байдаг.

Иймд автомашинаас ялгарч буй бодисын хэмжээ байнга өсөх хандлагатай байгаа тул түгжрэлийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

Нийслэлээс хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ.

1.Орон сууцжуулалт.

Гэр хорооллийг орон сууцжуулан хотын төвлөрлийг сааруулан нэг төв хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх бодлогын хүрээнд дэд төвүүдийг бий болгон иргэдийг эрүүл, аюулгүй орчинд стандартын шаардлага хангасан орон сууцад амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 202 мянга 626 айлын орон сууцын төслүүдийг хэрэгжүүлж байна.

Дэд төвүүдийн бүтээн байгуулалтын хүрээнд 41 мянга 584 айлын орон сууц, дахин төлөвлөлтийн хүрээнд 148 мянга 323 айлын орон сууц, гадаадын зээл тусламжийн хүрээнд 12 мянга 719 айлын орон сууцыг барьж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мөн хот байгуулалтын мэдээллийн санд аж ахуйн нэгж, байгууллагууд 51 мянга 200 айлын орон сууц архитектур төлөвлөлтийн даалгавар авсан бүртгэлтэй байна.

Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн дэд бүтцийн ажлыг бүрэн дуусгаж, 20 минутын хот концепцыг бүрэн хэрэгжүүлэх, 20 мянган айлын Сэлбэ дэд төв 12 мянга, Баянхошуу дэд төв 8 мянга, жишиг орон сууцын хороолол барих ажлыг эхлүүлсэн.

Сэлбэ дэд төвийн төслийн газарт өртсөн 2206 нэгж талбарын 1502 нэгж талбарыг чөлөөлж, төслийн эхний ээлжийн барилга угсралтын ажлын тендерийг зарлаад байна.

Баянхошуу дэд төвд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр эхний ээлжийн 3 мянган айлын ногоон орон сууцын төслийг эхлүүлсэн.

Дэд төвүүдийг орон сууцжуулснаар агаарын бохирдлыг 22 хувиар, авто замын түгжрэлийг 36.3 хувиар бууруулахаар тооцсон.

2.Хийн түлшний шилжилт.

Хатуу түлшний хэрэглээг бууруулж, гэр хорооллын айл өрхийг хийн түлшинд шилжүүлэх төслийг эхлүүлсэн.

Төслийг 3 үе шаттай хэрэгжүүлэх ба 2025 онд 15 мянган өрх, 2026 онд 40 мянган өрх, 2027-2028 онд 45 мянган өрх, нийт 100 мянган өрхийг хийд шилжүүлснээр гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлыг 27.8 хувиар бууруулахаар тооцсон.

3.Сэргээгдэх эрчим хүчний шилжилт.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран гэр хороололд сэргээгдэх эрчим хүчний шилжилтийг дэмжих замаар амьжиргааг нэмэгдүүлэх төслийн хүрээнд 45 өрхийг нартны эрчим хүчний эх үүсвэрт холбон бүрэн дулаалга хийж цахилгаан халаагуурт шилжүүлнэ.

Төслийн үр дүнд өрх бүр нүүрстөрөгчийн ялгаруулалтыг жил тутам 10-аас 20 20 тонноор бууруулж, эрчим хүчний зардлаа 70 хүртэл хувиар хэмнэж, цаашлаад нүүрстөрөгчийн кредит борлуулснаар нэмэлт орлоготой болох боломжийг бүрдүүлсэн.

Төслийг үргэлжлүүлж 2025-2026 онд 1000 өрхийг, 2027-2028 онд 10 мянган өрхийг сэргээгдэх эрчим хүчинд шилжүүлэхээр төлөвлөсөн.

4.Автомашины үүдэлтэй бохирдлыг бууруулах бодлого.

Туул хурдны зам, Баянзүрхийн товчоо, Туул голын гүүрнээс баруун аймаг салдаг аюулгүйн тойрог хүртэл 32 километр хурдны авто зам, Туулын хурдны замыг байгуулснаар түгжрэлийг бууруулах ач холбогдолтой гэж байна.

Хөдөлгөөний дундаж хурдыг 13.5 хувиар нэмэгдүүлж, автомашинаас үүдэлтэй агаарын бохирдлыг 8 хувиар бууруулна.

Шинэ тойрог зам ашиглалтад орсноор нийт 68.4 километр буюу хотын гол гудамж 13 километр дотор тойрог замыг шинэчлэх, хотыг гадна тойрог байдлаар 55 километр шинээр авто зам барьж байгуулах бөгөөд 4-өөс 6 эгнээтэй олон түвшний уулзвар, огтлолцол бүхий байдлаар хийгдэнэ.

Гэрлэн дохиогүй хоёрдугаар түвшний тойрог хурдны авто замыг байрлуулснаар нэвтрүүлэх чадварыг 27 хувиар нэмэгдүүлж, автомашинаас үүдэлтэй агаарын бохирдлыг 17 хувиар бууруулахаар тооцсон.

5.Их багтаамжийн нийтийн тээвэр. /Метро/

Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө 17.7 километр их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл метро сүлжээг нэвтрүүлнэ.

Метроны шугам 14 буудалтай. Буудал хоорондын дундаж зай нь 1.3, нийт аяллын хугацаа 27 минут, дундаж хурд 39.2 километр байх бөгөөд нийт 17 мянга 500-аас 26 мянган хүртэл хүн тээвэрлэх хүчин чадалтай байхаар төлөвлөсөн.

Ингэснээр замын хөдөлгөөний дундаж хурдыг 48 хувиар нэмэгдүүлэх тооцооллын гаргасан. Төсөл хэрэгжсэнээр иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөл сайжирна.

Мөн метро барих ажил эхэлснээр 156 мянган шинэ ажлын байр нэмэгдэнэ.

6.Тусгай замын автобус. /BRT/

Би жоохон товчилж уншихгүй бол их олон хуудас байна.

Энэ ашиглалтад орсноор автомашинаас үүдэлтэй агаарын бохирдлыг 14 хувиар бууруулна.

7.Дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэр.

Эрчим хүчний тасралтгүй найдвартай байдлыг хангахаар дулааны II, III цахилгаан станцыг өргөтгөн Бөөрөлжүүтийн цахилгаан станц* Багануурын цахилгаан станцуудыг ашиглалтад оруулж, нийт 750 мегаватт хүчин чадлаар, бие даасан дулааны тархмал эх үүсвэрийг 10 байршилд байгуулж, Налайх дүүргийн дулааны станцыг барьж, нийт 1545 мегаваттын хүчин чадлаар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

Мөн хог шатааж эрчим хүч гарах үйлдвэрийг Морингийн даваа, Цагаан давааны хогийн цэг төр хувийн хэвшлийн түншлэлээр хийхээр төлөвлөж тендер зарлах бэлтгэл ажлыг хангаж байна.

8.Хяналт шалгалтын талаар.

Нийслэлийн 8 постод Цагдаагийн Ерөнхий ны газрын Экологийн цагдаагийн алба, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар 24, 7 цагийн хяналтад тавьж, Засгийн газрын 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн 2024 онд Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, Ногоон хөгжил, агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн баталсан удирдамжийн дагуу 7 дүүрэгт иргэдийн зөв галлагаа, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж, Засгийн газрын 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын Агаарын бохирдол хариуцсан орлогч даргын гээд товчлоод уншъя.

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн баталсан Монгол Улсын Засгийн газрын түүхий нүүрсний хэрэглээг хориглох тухай 62, 223 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Цагдаагийн ерөнхий газар, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар, Экологийн цагдаагийн алба, Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хорооны Засаг дарга болон Ажлын албатай хамтран Баянзүрх, Баянгол, Налайх, Сүхбаатар дүүргүүдийн нутаг дэвсгэрт агаарын чанарыг нь сайжруулах бүсэд мөрдөх журмыг зөрчсөн хууль бусаар түүхий нүүрс хэрэглэсэн бусад хориглосон шатах материал түлсэн эсэхийг айл өрх бүрээр нэг бүрчлэн шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах, эд зүйлс болон зөрчлийн ул мөрийг баримтжуулан ажиллах арга хэмжээг 4 дүүргийн нутаг дэвсгэрт 18 хорооны гэр хорооллын айл өрхүүдийг хамруулан пийшин зуухны галын аюулгүй байдлыг хангаагүй зөрчил илрүүлэн заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Нийт сурталчилгааны материал 10 мянга гаруй ширхгийг тарааж ажилласан.

Ингээд товчлоод уншихъя. Та нарт бас тараагдсан болохоор би гол гол зүйлүүдийг нь хэлье.

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн үр дүнд 2025-2026 онд 674 өрхийг орон сууцад, 15 мянган өрхийг хийд, 1000 өрхийг сэргээгдэх эрчим хүчинд шилжүүлж, Агаарын бохирдлыг 15 хувиар, 2027-2028 онд 20 мянган өрхийг орон сууцад, 40 мянган өрхийг хий, 10 мянган өрхийг сэргээгдэх эрчимд шилжүүлэн агаарын бохирдлыг 48-аас 50 хувиар, 82 мянга 600 өрхийг орон сууцад, 45 мянган өрхийг хийд 30 хувьд хүргэж, агаарын бохирдлыг нийтдээ 80 хувиар бууруулахаар урьдчилсан тооцооллын гаргаад байна.

Нийт 2024-2028 онд 80 хувиар бууруулна гэсэн байна.

Тавантолгой түлшнийх бол дараа нь мэдээлэл өгөх учраас орхиод уншихъя.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас хэрэгжүүлж буй бодлого төсөл, арга хэмжээ.

1.Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Агаар орчны бохирдлыг бууруулах сангийн санхүүжилтээр агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн байгальд ээлтэй ногоон төсөл үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн хүүгийн дотаци олгох ажлыг 2019 оноос хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, гэр, байшингийн дулаалга, эко ариун цэврийн байгууламж зэрэг 34 нэр төрлийн ногоон бүтээгдэхүүнийг худалдан авахад зориулж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд жилд 8 хүртэлх хувийн хүүтэй ногоон зээлийн үйлчилгээг “Хас банк”, “ХААН банк”, “Төрийн банк”-тай хамтран 6 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

Энэ хугацаанд 4.1 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийг олгож, 11 мянга 393 иргэн, аж аж ахуйн нэгж, байгууллага ногоон зээлийн үйлчилгээг авч үр өгөөжийг нь хүртсэн байна.

2.Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа суурин харуулуудын байнгын ажиллагааг хангах зорилгоор агаарын чанарыг хянах иж бүрэн 2 суурин харуулыг шинээр ашиглалтад оруулсан бөгөөд Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын дэмжлэгээр Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд агаарын чанарын хяналтын автомат суурин харуулыг засварлах, шинээр суурилуулах ажлуудыг хийж дуусгасан.

3.Агаарын чанарыг сайжруулах бүсэд байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дотоод орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн 50 сургууль, 126 цэцэрлэг, 9 эмнэлэгт нийт 23 мянга 973 ширхэг PM2.5 тоосонцор шүүгч цонхны хаалтыг суулгаж, дотор орчны агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн хүрээнд агаарын чанарын стандартад өөрчлөлт оруулж, дотоод орчны агаарын стандартыг салгаж, үзүүлэлтийг олон улсын стандартын түвшинд хүргэх ажлыг 2025 онд “Нэг эрүүл мэнд” төслийн хүрээнд Эрүүл мэндийн яамтай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

4.2024 оны 9 дүгээр сарын байдлаар нийслэлд нийтийн тээврийн үйлчилгээнд 1191, төрийн үйлчилгээнд 2000 ширхэг тээврийн хэрэгсэл авто замын хөдөлгөөнд оролцож байна.

Нийслэл хотод нийтийн тээврийн болон төрийн албаны тээврийн хэрэгслүүдэд экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахуун хэрэглэх, тээврийн хэрэгслийн техникийн үзлэг хяналтаар агаар бохирдуулагч бодисын ялгарлын хэмжээ нь стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах тухай Байгаль

орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын албан даалгаврыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарт 9 дүгээр сарын 13-ны өдөр хүргүүлсэн байна.

Ашигт малтмал, газрын тосны газарын мэдээгээр Евро-5 стандартын түлш нь 14 хувьтай байдаг юм байна. Нийт түлшний.

Ингээд Евро-5 шатахууны импортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар Оросын Холбооны Улсын Байгалийн нөөц, экологийн сайд Козловт 01 тоот албан бичиг тус тус хүргүүлсэн байна.

5.Олон нийтийн цахим сүлжээнд иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл болон удирдлагын шийдвэрээр “Тавантолгой түлш” компанийн боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс салбарын хяналтын газар, Нийслэлийн агаар орчны тэмцэх газартай хамтран төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж эхлээд байна.

Шалгалтаар “Тавантолгой түлш” компанийн зүүн бүсийн үйлдвэр, баруун бүсийн үйлдвэр, төвийн бүсийн үйлдвэрүүдийг хяналт шалгалтад хамруулж, сайжруулсан шахмал түлшний түүхий эдүүд болон үйлдвэрлэлийн орчмын хөрс агаараас дээж авч, лабораторийн шинжилгээнд явуулсан.

Одоогийн байдлаар шинжилгээний дүн гараагүй байна.

Мөн “Тавантолгой түлш” компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд тус компанийн дотоодын хяналт лабораторид давхардсан тоогоор 8 нэр төрлийн химийн бодисыг тусгай зөвшөөрөлгүй ашиглаж байсан зөрчил илрүүлсэн ба химийн бодисуудыг Эрүүгийн хуулийн дагуу Экологийн цагдаагийн албан бичгээр шилжүүлсэн байна.

6.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын санаачилгаар тус яамнаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдамжаар хангах, сайн туршлага хуваалцах, салбар хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор агаарын бохирдлын талаар судалгаа хийдэг судлаач төрийн байгууллагын төлөөллийг хамруулан агаарын бохирдлын талаар зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан байна.

Дээрх уулзалтаас судлаачдын гаргасан саналын хүрээнд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэнтэй холбогдуулан Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах талаар богино, дунд хугацаанд хэрэгжүүлэх ажлын саналыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарт хүргүүлсэн.

Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус яамны зүгээс аймгийн төвүүдийн агаарын бохирдлыг бууруулах, үйл ажиллагааг Агаарын тухай хууль, Агаар бохирдуулсны төлбөрийн журам, агаарын

чанарын стандартууд болон асфальт бетон хольцын үйлдвэр, зуурмаг, хайрга, дайрганы үйлдвэр, хуванцар, яс боловсруулах үйлдвэр гэх мэт хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг агаар бохирдуулах бусад эх үүсвэрүүдэд экологийн нэгдсэн стандарт тогтоох ажлуудыг эхлүүлээд байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Улаанбаатар хот өдөр ирэх тутам тэлж байгаа бөгөөд агаар бохирдуулагч эх үүсвэрийг хянах суурин харуулын тоог Улиастай, Дарь-Эх, Чингэлтэй, Орбит, Тахилт, Морингийн даваа, III, IV хороолол гэх мэт газруудад нэмж байршуулах шаардлагатай байна.

2025 онд 4 байрлалд шинээр нэмэхээр төлөвлөгдсөн.

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа дулаан үйлдвэрлэх, түгээх тусгай зөвшөөрөлтэй 20 аж ахуйн нэгж, байгууллагын 173 усан халаалтын зуухнаас Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа сургууль, цэцэрлэгийн халаалтын зуух нь 30 хувь, Эрүүл мэндийн яамны харьяа сургууль, эмнэлгийн халаалтын зуух нь 2.9 хувь, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяа хорооны халаалтын зуух 6.3, Батлан хамгаалах яамны харьяа цэргийн ангийн халаалтын зуух 12.1, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа хорих ангийн халаалтын зуух 16.8-ыг тус тус эзэлж байна.

Иймээс Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт сайд нар агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг хариуцахаар заасан байдаг тул усан халаалтын зуухуудад технологийн шинэчлэл хийхэд шаардагдах төсвийг холбогдох асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь тухайн жилийн төсвөөр шийдэж зуухыг солих асуудлыг шийдвэрлэх.

Монгол Улсын сайжруулсан шахмал түлш техникийн шаардлага нь MNS20/10 стандартын дэгдэмхий хий нийт хүхрийн үзүүлэлт нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 2 дугаар ангилал, Бүгд Найрамдах Солонгос Улсын 5 дугаар ангиллын шахмал түлшний стандартын үзүүлэлтийн түвшинд байна.

Иймд стандартын үзүүлэлтийг олон улсын стандартад хүргэх шаардлагатай байна.

Цаашид шахмал түлшний орцод орж байгаа эрчим хүчний нүүрсийг антрацидын төрлийн нүүрсээр солих, эсвэл Тавантолгойн ордын нүүрсийг угаан баяжуулах технологийг өөрчлөх шаардлагатай.

Улаанбаатар хотод нийт 277 цэцэрлэг, 162 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2024 онд нийслэлийн 126 цэцэрлэг, 9 эмнэлэгт, нийт 23 мянга 973

шүүгчийг суурилуулсан бөгөөд үлдсэн 263 сургууль цэцэрлэгт 35 мянган цонхны хаалтыг нэмж суурилуулах шаардлагатай байна.

Авто тээврийн хэрэгслээс үүсэх хүлэмжийн хий ялгарлын бууруулахын тулд экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахууны импортыг нэмэгдүүлэх, шатахууны үнийг бууруулж Евро-2 стандартын түлшний үнэтэй дүйцүүлж хэрэглээг нэмэгдүүлэх.

Евро-5 стандартын түлшний нөөцийг 30 хувиар нэмэгдүүлэхэд Нийслэлийн агаар чанарын бүсэд явж байгаа тээврийн хэрэгслийг хангах боломжтой юм.

Хийн түлшээр ажилладаг халаалтын системд айл өрхийг шилжүүлэх, яндангүй бүсээс гадуурх айл өрхийн зуухыг сайжруулсан зуухаар шинэчлэх асуудлыг судлан шийдвэрлэх гэсэн байна.

Саяын миний уншсан танилцуулга бол Шадар сайд С.Амарсайхан даргын бэлтгэсэн танилцуулга байна. Тэгээд та бүхэнд бас цаасаар хүргүүлсэн байгаа.

Б.Бейсен: Өнөөдрийн хуралдаанд оролцсон ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Агаарын бохирдлын асуудлаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын Онцгой комиссын даргын мэдээллийг Агаарын орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайд С.Одонтуяад танилцууллаа.

С.Одонтуяа сайд оролцож байгаа. И.Лувсанцэрэн Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилт зохицуулах газрын дарга байна уу?

Цаг уур, орчин шинжилгээний газрын дарга Л.Оюунжаргал.

Засаг дарга ирээгүй байгаа. А.Амартүвшин Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдол хариуцсан орлогч, Ч.Батзориг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Н.Отгонбаяр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүү, удирдлагын гзарын дарга, Л.Алтангэрэл Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн дэд бүтцийн газрын мэргэжилтэн. Байна уу?

Б.Марс-Од Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, Ч.Буянжаргал Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын Сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн дарга, Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлдвэрийн газар гэнэ. Байна уу? Ч.Буянжаргал.

Ц.Эрдэнэбаяр “Тавантолгой түлш” ХХК-ийн захирал. Ирээгүй байна. А.Батзориг “Тавантолгой түлш” ХХК-ийн Санхүү, эдийн засгийн газрын дарга, Д.Өлзийбат “Тавантолгой түлш” ХХК-ийн Ерөнхий технологич, Д.Эрхэмбулган

Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга. Ирсэн байна. О.Ганбат Нийслэлийн цагдаагийн удирдах газар газрын дарга, цагдаагийн хурандаа, Б.Батсайхан Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн цагдаагийн албаны Экологийн цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа.

Ийм бүрэлдэхүүнд ажлын хэсэг ирсэн байна.

Сая сайдын мэдээлэлтэй холбоотой гишүүдээс асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

О.Номинчимэг гишүүнээр тасалъя. М.Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Асуудлыг хойшлуулахгүй хэлэлцэж байгаа нь зөв өө гэсэн ийм байр суурьтай байгаа. Цаашдаа бас Байнгын хорооны үйл ажиллагаа доголдохгүйгээр явах ёстой. Танилцуулга хийж байгаа дарга нараас хамаарахгүйгээр ажил нь явж байх ёстой.

Нөгөө талаасаа утааны асуудал бол цаг үеийн үнэхээрийн тулгамдсан асуудал байна. Зарим гишүүдтэй үнэхээрийн санал нэг байна.

Зөвхөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо биш бүх Байнгын хороо энэ асуудлаар хэдэн ч удаа хуралдсан одоо ер нь энэ асуудалд анхаарал хандуулахаас өөр аргагүй ийм нөхцөл байдалд орсон байгааг бид бүхэн ойлгох хэрэгтэй байна.

Энэ утгаараа асуудлуудаа хэдэн ч удаа ярьсан яах вэ. Дарга нартай дахиж хурлыг ойрын хугацаанд үргэлжлүүлээд хийсэн ч болохоор ийм нөхцөл байдлууд байгаа гэдгийг манай гишүүд бас доор бүрнээ анхаарах нь зөв гэсэн ийм бодолтой байна.

Өнөөдрийн хувьд яг одоо ирсэн мэргэжилтнүүдээс тодорхой чиглэлийн мэдээллүүд байвал бас нэмж өгөөч гэж. Иргэдийн бас мэдэх эрхтэй холбогдолтой асуудлууд явж байгаа.

Сонсгол цаашлаад үргэлжлээд нэлээн эрчимжээд ингээд явна гэсэн ийм ойлголттой байна.

Үндсэндээ болоод байгаа процесстой холбогдолтой асуудал бол яг энэ явж байгаа бүх асуудал дээр хэн юугаа хариуцаж, хэн яаж оролцох вэ гэдэг ийм ойлголт бид бүхний дунд алга. Ялангуяа С.Амарсайхан сайдаар ахлуулсан энэхүү танилцуулгыг би хүлээхдээ яг энэ онцгой үеийн, цаг үеийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдолтой авч хэрэгжүүлэх тухай танилцуулга байх болов уу гэсэн ийм хүлээлттэй байлаа.

Гэтэл яг үндсэндээ Засгийн газраас хэрэгжүүлж байгаа урт болон дунд хугацааны бүх танилцуулгуудыг нийлүүлээд орж ирж байна.

Тэгэхээр яг ойрын хугацаанд Улсын Онцгой комисс, Онцгой байдлаас нийслэлийн иргэдийн өмнө тулгамдаад байгаа асуудалтай холбогдолтой яг тодорхой ажил асуудлууд байвал энэ дээр нэмж танилцуулга юмнууд хийгээч ээ.

Тусгайлаад ерөнхийлөн асуухад энэ шийдвэр гаргах процесст яг ямар байдлаар явж байна аа? Шинэ дарга нар гарч ирэхээрээ шинэ төслүүд яваад үндсэндээ энэ утааны асуудал дээр нэгдсэн тодорхой бодлогогүйгээр дандаа ийм цоо шинэ сюрпризүүдийг бид бүхэн ард түмэндээ барьсаар байгаад ингээд энэ үр дүнд хүрэхгүй байсаар ирлээ.

Тэгэхээр эрдэмтдийнхээ санаа бодлыг яг яаж сонсдог юм дарга нар маань, ямар зөвлөл, баг та бүхэнд яг үндсэндээ зөвлөдөг юм. Хувийн хэвшлийнхээ саналуудыг яаж ямар судалгаан дээр үндэслэж энэ олон сайн төслүүд хийе гээд явж байгаа хүмүүсээ яаж та бүхэн сонсоод тэрийгээ нэгдсэн бодлого болгож оруулж ирдэг юм бэ? Олон улсын байгууллагын олон тусламж дэмжлэгүүд энэ дээр байна гэж ингэж ярьдаг.

Тэгэхээр тэр санал, зөвлөмжүүдийг үндсэндээ энэ бодлогодоо яаж тусгаж шийдвэр гаргадаг юм бэ? Шинэ дарга гарч ирээд шинэ бодлого танилцуулж явсаар байгаад өнөөдөр бид бүхэн нөхцөл байдал ингээд ямар ч уялдаа холбоогүй ийм нөхцөл байдал руу орж байна.

Тэгэхээр богино хугацаандаа юу хийх юм? Шийдвэр гаргалт нь яг яаж явдаг юм бэ?

Б.Бейсен: Сайд хариулах уу? Эндээс ямар хүн хариулах вэ? Ажлын хэсгийнхнээс. 6 номер. А.Амартүвшин орлогч.

А.Амартүвшин: Байнгын хорооны дарга, гишүүд Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Ойрын хугацааны ажил дээр ямар төлөвлөж байна гэж байна. Ойрын хугацааны ажилд бид сая нэг дэх өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёр дахь өдөр Улсын Онцгой комисс хуралдаад тодорхой чиг үүрэг даалгавруудыг өгсөн байгаа.

Нийслэлийн зүгээс 8 сарын 20-ноос эхлээд Улаанбаатар хот руу орж байгаа нийт 8 пост дээр хяналт шалгалтын ажлууд хийгдээд явж байгаа. Энэхүү хяналт шалгалтын ажлууд хийх явцын хүрээнд Улаанбаатар хот руу орж ирж байгаа түүхий нүүрс, мөн Улаанбаатар хотоос гарах гэж байсан сайжруулсан түлшийг илрүүлээд тухайн газар дээр нь хурааж аваад улсын орлого болгоод явж байгаа.

Мөн 9 сараас эхлээд манай дүүрэг, хороо нийслэлтэйгээ хамтраад бүх гэр хороолол байдаг 7 дүүргийн хороодуудтайгаа хамтраад чиг үүрэг даалгаврыг нь өгөөд айлаар угаарын хийгээс урьдчилан сэргийлэх, мөн пийшин зуухаа хөөлгөх, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар жил болгон хийж явдаг ажлаа үргэлжлүүлж хийгээд, дээрээс нь шинэчлэлүүдийг хийгээд айл өрх дээр ороод явж байгаа.

Тэр дээр нөгөө ямар шинэчлэлүүд хийгдсэн бэ гэх юм бол аав, ээж хоёр нь ажилдаа, эмээ, өвөө ч юм уу, эсвэл харгалзан хамгаалагч нь гэртээ байхгүй үед хүүхдүүд яаж хэрхэн галаа түлэх вэ. Хэрхэн аюулгүй байдлаа хангах вэ. Хэрхэн өөрсдийнхөө аюулгүй байдлыг хангах вэ? Гал алдсан үед мөн тогтой холбоотой аюул гарсан үед хэрхэн хүүхдүүд өөрсдийгөө тухайн аюулаас хамгаалах вэ. Яаж Монгол гэрээсээ зөв гал гарсан үед одоо ингэж гарах вэ гэдэг аюулгүй байдлын сурталчилгааны ажлууд айл гэр болгонд нь энэ ажлуудыг орж танилцуулгуудыг хийж, мөн сургуулиудаар дамжуулан танилцуулгуудын ажлуудыг хийж явсан.

10 хоногийн өмнө ажлын хэсэг байгуулаад удирдамжийг би өөрөө батлаад. Энэ дээр ямар ажлууд хийх гэж байгаа бол өйл болгон дээр ороод угаарын хийгээс хамгаалах, угаарын хийн мэдрэгчүүдийг шалгах. Тэр дээр нь юу шалгаж байна вэ гэх юм тухайн мэдрэгч нь ажиллаж байна уу, тухайн мэдрэгчдэд нь зай байна уу, тухайн мэдрэгчтэй айл байна уу, мэдрэгчгүй айл байна уу гэдэг дээр нь яг хөрсөн дээр шалгалтыг хийгээд явж байгаа.

Өнөөдрийн байдлаар нийтдээ 75 мянган өрх дээр манай нийслэл, дүүрэг, хороодын ажилтан, мөн цагдаа болон онцгой байдлын ажилтнуудыг ингээд дайчлаад нийтдээ 2500 төрийн албан хаагчийг дайчилж ажлын бус цагаар мөн амралтын өдрүүдээр ажиллаад явж байгаа.

Энэ дээр мөн санамжуудыг хүргүүлээд тухайн айл өрхүүдийн гэрийн гэрийн гишүүдэд нь тодорхой санамж эрсдэлүүдийг биечлэн танилцуулж ажиллаж байгаа. нийтдээ 75 мянган айл өрхөөр орчихсон явж байгаа. Цаана нь дахиад 100 гаруй мянган айл өрх байгаа. Энэ ажил хэвийн үргэлжлээд явж байгаа.

Тэгээд мөн энэ шалгалтын хүрээнд манай Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт уурын болон усан халаалтын 173 зуухан дээр үйл ажиллагааны шалгалтууд явчихсан байгаа.

Тухайн зуух нь усан филтэртэй байна уу, филтер нь шаардлага хангаж байна уу. Тухайн филтер чанар стандартыг нь шалгаад шалгалтын ажил явж байгаа.

Нийтдээ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явж байгаа тухайн филтерээ ашиглаж байгаа нийтдээ 519 аж ахуйн нэгжээр шалгалтыг оруулж яваад ажил хэвийн үргэлжилж байгаа.

Б.Бейсен: Дарга аа, тодорхой хариулмаар байх юм. Т.Баярхүү дарга хариулчих. 9 номерт.

Т.Баярхүү: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулья.

Улсын Онцгой комиссын 2024 оны 6 дугаар хуралдаан 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр болж энэ өвөлжилтийн бэлтгэл ажил болон нийслэл хотод тулгамдаад байгаа агаарын бохирдолтой холбоотой асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагуудын мэдээллийг сонсож, Улсын Онцгой комиссын гишүүн байгууллагууд болон холбогдох яам, агентлагуудад холбогдох үүрэг чиглэлийг өгсөн.

Үүнтэй холбоотойгоор эхний ээлжид авч хэрэгжүүлсэн арга хэмжээ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар гэх мэт холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо байгуулах асуудлыг өчигдөр Засгийн газрын хуралдаанд оруулж байгуулсан.

Өнөөдрөөс Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар ахлуулсан Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо байгуулагдаж салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ойрын болон дунд урт хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөлтийг хийж танилцуулах ийм үүрэг чиглэл өгөөд энэ ажил эхний ээлжид хэрэгжээд явж байна.

Хоёрдугаарт нь, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах чиг үүрэгтэйгээр Улсын Онцгой комиссын Шуурхай штабыг өргөтгөн зохион байгуулж яг энэ агаарын бохирдолтой холбоотой асуудлуудаар мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах үйл ажиллагаанд орсон.

Мөн одоо нийслэлийн Онцгой комиссын дэргэд нийслэлийн шуурхай штабыг байгуулан мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж нийслэлээс зохион байгуулж байгаа энэ хяналт шалгалтын ажлууд тэр шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна.

Гуравдугаарт нь, энэ яг одоо сайжруулсан шахмал түлшний чанар стандарттай холбоотой асуудал нэлээн эргэлзээ төрүүлж асуудлууд яригдаж байгаа. Хэд хэдэн удаагийн дотоодын лабораторийн шинжилгээнүүд гарсан боловч гэсэн энэ дээр бас нэлээн олон асуудалтай юу байна гэдэг ийм эргэлзээ байгаа учраас энэ Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчны сайдаар ахлуулсан энэ хороонд болон тагнуул, цагдаагийн байгууллагын албан тушаалтнуудад холбогдох үүргийг өгсөн.

Энэ хөндлөнгийн гадаадын шаардлагатай лабораториудад энэ түлшний чанар, стандарт, үйлдвэрийн процесс дээр шалгалтуудыг хийж 14 хоногийн хугацаанд Улсын Онцгой комисст танилцуулах ийм үүрэг чиглэлийг өгөөд ажиллаж байна.

Үүнээс гадна бас яг энэ агаарын бохирдол, дээрээс нь улсын хэмжээнд томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор Улсын Онцгой комиссын хуралдаан дээр бас энэ асуудлыг ярилцаж, Эрүүл мэндийн сайдад эмнэлгийн орны зохион байгуулалтыг хүртээмжтэй, оновчтой зохион байгуулах, энэ халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд өргөн хүрээнд зохион байгуулах үүрэг чиглэлийг өгөөд эрүүл мэндийн байгууллагууд холбогдох зохион байгуулалтын ажилдаа ороод ингээд ажиллаж байна.

Б.Бейсен: М.Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Баярлалаа. Хэн яг юу хийх гээд байгаа нь ойлгомжгүй бол болохоор л бухимдал үүсээд байна л даа. Тэгээд олон нийт тэрийгээ тодорхой болгоод өгөөч л гэж байгаа юм.

Тэгэхээр Т.Баярхүү даргын хэлж байгаа Улсын Онцгой комисс яг ковидтой адилхан, бусад цаг үетэй адилхан шуурхай штабаа байгуулаад энэ цаг үеийн асуудлаа хариуцаад үндсэн бодлогынхоо ажлыг нийслэл нь байх юм уу, үндэсний хорооныхон хийгээд явах.

Дээр нь хувийн хэвшил, бусад иргэдийг яаж оролцуулах гэдэг юмаа тодорхой танилцуулаач ээ гэдэг ийм л нийгмийн хүлээлт одоо бид бүхэнд тулгаад байна шүү дээ.

Тэгэхээр би нэмээд Шуурхай комисс дээр энэ сурагчдын амралттай холбогдолтой асуудлыг нэг анхаараач ээ. Одоо ингээд энэ долоо хоногт ингээд бага ангийнхан, дээр нь нэмээд ирэх долоо хоногоос бусад ахлах болон дунд ангийнхан амарна. Нэг сар гэртээ байна. Тал өдөр байдаг байсан бол бүтэн өдөр байна. Галлагаа гээд олон юм болох байх. Дээрээс нь энэ амарч байгаа сурагчдыг, ахмадуудыг Эрүүл мэндийн даатгалаараа амралт сувилалд амрах байдаг юм уу, өөр одоо энэ.../минут дуусав/

Б.Бейсен: М.Ганхүлэг гишүүний 1 минут.

М.Ганхүлэг: Нэгмөсөн асуучихъя. Үүнийг судалж өгөөч ээ. Энэ одоо ингээд нэг тулгамдсан бас нэг яаралтай асуудал болох нь ээ? Тийм болох нь.

Хоёрт нь болохоор 10 янданг 1 болгож байгаа энэ хувийн хэвшлийн төсөл, санаачилгуудыг яг энэ бодлого маань яаж дэмжих юм бэ? 10 янданг 1 болгож байгаа. Заавал бид 100 мянгаар нь асуудлыг нь шийдэх гээд байна, байж бай гэхээсээ гадна энэ богино хугацааны шийдлүүдийг яаж дэмжих юм бэ?

Дээрээс нь, энэ 30 мянган айлд зуух өгч байхаар яндангаа байхгүй болгосон айл гэж дэмжиж болохгүй юм уу? Яндангаа байхгүй болгосон айлийг. Энэ асуудлыг ул мөрөөр нь шийдэж байгаа энэ хүмүүсээ дэмжих тал руугаа явж болохгүй юм уу? Тэгээд өмнө алдчихсан энэ алдаануудаа дахин дахин давтсан, энэ эргэж буцсан энэ ухарсан шийдвэрүүдийг чинь л олон нийт ойлгохгүй байгаад байна л даа.

Тэгэхээр энэ зүйлүүдийг нэг тодорхой тайлбарлаж өгөөч ээ.

Б.Бейсен: 6 номер хариулья.

А.Амартүвшин: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулья.

Сурагчдын амралттай холбогдуулаад мөн талбай дээр жагсагчдаас тавьсан шаардлагын дагуу бид нийслэлийн хэмжээнд сая өнгөрсөн долоо хоногт судалгаа шинжилгээнийхээ ажлыг хийж дуусгаад эхний ээлжид гурван чиглэлийн автобус агаарлах цэгүүд дээр гарахаар шийдвэрлээд явж байна.

Эхнийх нь Сүхбаатарын талбайгаас Тэрэлж рүү, хоёр дахь автобус нь жишээлбэл Сүхбаатарын талбайгаасаа “Скай ресорт”, дараачийнх нь чиглэл нь Сүхбаатарын талбайгаас “Дугуй цагаан” руу явж байгаа. Энэ талаар бид 3 өдрийн хугацаанд олон нийтийн санал асуулгыг хийсэн байгаа.

Өнгөрсөн долоо хоногийн тав дахиас эхлээд нэг дэх өдөр хүртэл ингээд нийтдээ бүтэн 3 өдрийн хугацаанд санал асуулга хийгээд, санал олон нийтийн санал асуулга дээр хамгийн өндөр санал авсан 3 газар луу чиглэлийн автобуснуудыг сурагчдын амралт эхлэхтэй холбогдуулаад д явуулахаар эхэлсэн байгаа.

Мөн сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулаад гэртээ хүүхдүүд маань байна. Гэртээ байхдаа өөрсдийнхөө аюулгүй байдлыг хангах зорилгоор хийгдэж байгаа ажлуудыг би өмнөхтөө аюулгүй байдлын хүрээнд дэлгэрэнгүй хэлсэн байгаа.

32 мянган зуухны хувьд манай Улаанбаатар хотод амьжиргааны түвшнээс доогуур оноо авсан нийтдээ 94 мянган өрх байдаг. Эдгээр өрхүүд дээр манай нийслэл хотоос тухайн айл бүрээр нь ороод нөгөө зуухынх нь нөхцөл байдал угаартаас урьдчилан сэргийлэх ажлынхаа хүрээнд тухайн өрх айлуудтай орж ажиллахад хөрсөн дээр тухайн зуух нь нэг стандарт бол бус гар хийцийн зуух, нөгөөдөх нь уламжлалт зуухууд байгаа маш их таарч.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж яриулах уу? 6 номер.

А.Амартүвшин: Тэгээд уламжлалт зуухууд байгаа. Уламжлалт зуухууд нь яг нөгөө битүүмжлэл алдагдсан, энд тэндээ ан цав үүссэн, ашиглалтын шаардлага

хангахгүй нийтдээ 72 мянган зуух бидний хяналт шалгалтын бус иргэддээ санаа сонор сэрэмжийг өгөх, аюулгүй байдлыг хангах зорилгоор хийх ажлын хүрээнд л тоологдсон байгаа.

Тэгэхээр энэ зуух маань агаарын орчны бохирдол бууруулах гэхээсээ илүү нөгөө зорилтот бүлгийн айлуудын, тэд нарын хүүхдүүдийг угаарталтаас урьдчилан сэргийлэх, угаартахаас амь насыг нь аврах стандартын зуухыг хэрэглүүлэх энэ ажлын хүрээнд үүнийг ингээд авч хэрэгжүүлэхээр энэ ажлыг хийж байгаа юм шүү. Хариулж дууслаа.

Б.Бейсен: С.Одонтуяа гишүүн нэмж хариулъя.

С.Одонтуяа: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Яамд ер нь энэ ямар уялдаатай байх юм. Та нар нэг ийм онцгой байдлын үе шиг нэг ажиллаж болох уу? Асуудлаа яриад гээд хэлж байгаа.

Тэгэхээр энэ дээр санал нийлж байгаа. Тэгээд өчигдөр Засгийн газар дээр Үндэсний хороо байгуулагдсан. Үндэсний хороо нийт Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо. Энд агаар, хөрс, ус, хог гээд бүх зүйлүүд орж байгаа.

Энэ дээр гол анхаарч ажиллах нь хамгийн яаралтайгаар агаарын бохирдол байгаа.

Үндэсний хорооны гол зорилго бол өмнө нь би түрүүн хэлсэн. Эхлээд Үндэсний хороо байж байгаад ерөөсөө хариуцлагууд хуваагдаад байна, хариуцах эзэнгүй болоод байна гээд ярьж байгаад 2024 оны 3 сард Засгийн газраас тийм шийдвэр гарсан юм байна лээ. Ерөөсөө нийслэлийн утааг нийслэлд шууд дангаараа хариуцъя. 100 хувь хариуцъя.

Тийм учраас энэ Үндэсний хороогоо татан буулгая гээд татан буулгачихсан. Гэтэл одоо нөгөө нийслэл.../минут дуусав/

Б.Бейсен: С.Одонтуяа гишүүн гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Нийслэл дангаараа хариуцахаар бусад салбарын оролцоо зайлшгүй хэрэгтэй болдог.

Онцгой комисс, тэгээд л энэ манай Онцгой байдлын ерөнхий газар, бусад яамдууд гээд л. Ингээд л аймаг, орон нутагт ер нь ийм уялдаа холбоо их чухал байгаа учраас энэ Үндэсний хороог ер нь дахин шинээр сэргээж байгуулж байна гэсэн үг.

Тэгэхээр Үндэсний хороо өнөөдөр дөнгөж тогтоол албажиж гарсан учраас бид төлөвлөгөөгөө гаргаж байна. Яаж одоо яг таны саяын хэлдэг зөвхөн нэг яам ч

юм уу, нэг нийслэл хариуцах биш бүх нийтээрээ одоо энэ уялдаа холбоог нь яаж хийх юм бэ.

Үүнийгээ нарийн хариуцлагажуулж үүрэгжүүлээч ээ. Ийм шуурхай эрчимтэй ажиллаач ээ. Хэвлэл мэдээллээр бас мэдээлэл өгөөч ээ. Хүүхдүүдэд бас ийм асуудлыг нь шийдээч ээ гэсэн энэ бүх зүйлүүдийг бид төлөвлөгөө гаргаад яаралтай байгууллагуудыг үүрэгжүүлж ийм ажлыг хийж байна.

Б.Бейсен: Б.Бат-Эрдэнэ гишүүнд асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Өнөөдрийн байгаа нөхцөл байдал дээр бол жоохон хэцүү л дээ. Яг ний нуугүй хэлэхэд.

Уг нь энэ чинь богино, дунд, урт хугацааны хөтөлбөр, утаагүй болох асуудал. Ямар алдаа гараад байна гэхээр дунд хугацааны хөтөлбөрөө тогтвортой хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал байгаа.

Өөрөөр хэлбэл сайжруулсан шахмал түлш гэдэг бол богино хугацааны шийдэл. 4 жилийн хугацаанд сайжруулсан шахмал түлш богино хугацааны шийдлээ явуулаад 2025 оны эхний улиралдаа багтаад хагас коксны үйлдвэрээ байгуулж эцэслээд ажилдаа ороод явъя.

Урт хугацааны хөтөлбөр бол мэдээж эрчим хүч, дэд бүтэц, орон сууцжуулах ажлууд. Энэ бол богино дунд, хугацааны хөтөлбөр явагдаж байх процесс дээр зэрэг явагдаж байх ёстой байхгүй юу.

Тэгээд энэ дээр л алдаа гарчхаад байх шиг надад харагдаад байгаа юм. Бид нарын хувьд яах вэ одоо энэ тэгээд л. Би сая яагаад дунд хугацааны хөтөлбөрийн тухай ярьж байна гэхээр энд нэг ийм шинэ юм орж ирчхээд байна л даа. Хийн түлшний шилжилт гээд. Энэ метан хийн орд яг хаана олдчихоод байгаа юм? Улаанбаатар хотын ойролцоо. Урьд нь энэ Тавантолгой түлш, Тавантолгой, Өмнөговьос шууд Тавантолгой дээрээс Эрдэнэс Тавантолгой тэндээс гарч байгаа метан хийг наашаа 586 километр хоолой татаад авъя гэдэг юм яриад санхүү мөнгө нь шийдэгдэхгүй учраас больё гээд явж байсан юм.

Тэгээд одоо хийн түлшний шилжилтийн тухай яриад эхэлчихсэн. 100 мянган өрхийг нийтэд нь шилжүүлнэ гээд явж байх шиг байна. Утаа нь агаарын бохирдол 27.8 хувиар буурах гээд.

Нүүрс чинь 52-оос 55 хувь дэгдэмхий. Сайжруулсан шахмал түлш чинь 22-оос 25 багцаа.

Тийм учраас 50 хувь буурсан гээд байгаа учир шалтгаан тэнд байгаа. Хагас кокс гэдэг чинь өнөөдөр Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон Улс хэрэглээд л явж

байгаа. Энэ чинь 8-аас 12 хувь байхгүй юу. Тэгэхээр дахиад 50 хувь буурах боломж.

Тэгээд Эрдэнэс Тавантолгой компаниас нарийвчилсан ТЭЗҮ энэ тэр хийгээд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам тухайн үед өгч байсан тэр ТЭЗҮ хаана явна вэ гэдгийг дүгээрт би асуумаар байна.

Тэгээд 2 дугаарт саяын асуусан асуулт буюу хийн түлш буюу метан хийн орд хаана олдчихсон байгаа юм бэ? энэ ямар учиртай юм яваад байгаа юм билээ гэдгийг асуух гэж байгаа юм.

Энержи ресурсээс мидлингийг авч байсан. Одоо үндсэн түүхий эд шүү дээ. Сайжруулсан шахмал түлшний. Энэ мидлингийг үргэлжлүүлж авч байгаа юм уу, эсвэл Эрдэнэс Тавантолгойгоос авч байгаа юм уу? Энержи ресурсээс мидлинг авч байгаа бол одоо ёроолд нь үлдсэн гэдэг шиг ийм мидлинг болчхоод байгаа юм биш биз дээ? Энэнээс ч их хэмжээний дэгдэмхий гараад байгаа юм биш биз дээ гэдэг ийм хоёр дахь асуултыг би асуух гэж байна.

Уг нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас дэгдэмхийг Эрүүл мэндийн яаманд 5 хувиас хэтрүүлэхгүй барь гэдэг ийм чиглэл ирсэн шүү дээ. Зөвлөмж.

Тэгээд л юун 5 хувь байна л даа. Одоо бид чинь бараг 30 хувь руугаа орчхоод явж байх шиг байна. Тэгээд үүнийг одоо бид хэзээ хэрэгжүүлж эхлэх боломжтой вэ гэдгийг асуух гэж байгаа юм.

Дараагийн асуулт. Уурын зуухуудад зөвшөөрөл өгдөг. Улаанбаатар хот, Эрчим хүчний яам. Одоо яг Улаанбаатар хотын хэмжээнд хэчнээн уурын зуух ажиллаж байна. Энэ уурын зууханд хэдий хэмжээ.../минут дуусав/

Б.Бейсен: Б.Бат-Эрдэнэ гишүүн гүйцээж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Энэ уурын зуухууд дээр нэлээн их хэмжээний гал түлэгдэж байгаа.

Энэ хэдий хэмжээний уурын зуух хаана хаана ямар байрлал дээр ажиллаад байна вэ гэдгийг хэлээд өгөөч ээ.

Дараагийнх нь, ер нь яах вэ энэ борлуулалтын цэг ихсэж байгаатай холбоотой асуудлууд. Ер нь зүгээр он оноор нь харьцуулаад харахаар борлуулалтын цэг дандаа ихэсдэг л юм байна лээ л дээ. Нийслэлийн ярьж байгаа нэг сайхан зүйл бол иргэд рүүгээ ойртуулж байна гэж ярьдаг.

Гэтэл борлуулалтын цэг нэмэгдэхийн хэмжээгээр нөгөө төлөх хэмжээ ихэсдэг. Үүнтэй холбоотой асуудал байна. Эрчим хүчний сайдын түрүүний хагас кокстой холбоотой 2023 оны 4 сарын 18-ны өдрийн дробь 94 дүгээр тушаал гарч байсан. Энэ тушаалын хэрэгжилт юу болж байгаа вэ гэдгийг би асуух гэж байна.

Шахмал түлшний чийглэгийн хэмжээг 10 хувь байсныг шинэчилсэн стандартаар 6 хувь болгосон гээд. Энэ стандартаа яг мөрдөж чадаж байгаа юм уу? Өнөөдрийн нөхцөл байдал дээр. Чийгшилтэй холбоотой асуудал яалт ч байхгүй хөндөгдөх сэдвийн нэг.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 7 номер хариулъя.

Ч.Батзориг: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хийн түлшний шилжилтийн талаар тодруулаач гэж байна.

Хийн түлшийг энэ ийм учиртай. Одоо Улаанбаатар хотод сая 12 сарын 01-нээс “Тавантолгой түлш” үйлдвэр шилжиж ирсэн. Үүнтэй холбоотойгоор “Тавантолгой түлш” дээр нөхцөл байдал ямар байгаа вэ гэхээр сүүлийн 6 жил бол жилдээ 500 гаруй мянган шахмал түлшийг 518 мянган төгрөгөөр үйлдвэрлээд 150 мянган төгрөгөөр борлуулж байгаа. Энэ борлуулалтын зөрүү мөнгийг бол бид санхүүжилтийг нэмж авч байгаа.

Өөрөөр хэлбэл 360 мянган төгрөгийг Эрдэнэс Тавантолгойгоос санхүүжилт авч байна. Улаанбаатар хотоос жилдээ 50-аас 60 тэрбум төгрөгийг эдгээр 500 гаруй мянган тонн шахмал түлшийг тээвэрлэх агуулах борлуулалтын ажилтнуудын урамшууллын олгоход зориулж байна.

Ингээд 350 орчим тэрбум төгрөгийг одоо сайжруулсан шахмал түлшний санхүүжилтэд олгож байгааг өнөөдөр хийн түлш хэрэглэвэл хийн түлшинд хэрэглэж байгаа хэрэглэгчдэд олгох замаар богино хугацаандаа шийдэх шийдлийг шинээр оруулж ирж байгаа.

Метан хийний хувьд өнөөдөр таны хэлдэг зөв. Тавантолгой, Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт нийтдээ 5 аж ахуйн нэгж хоёр улсын хөрөнгө оруулалттай компаниуд бүтээгдэхүүн хуваах гэрээ хийгээд явж байгаа.

Улаанбаатар хотын хувьд хүрэн нүүрсний орд газрыг ашиглаад нүүрсийг гүн боловсруулах, нүүрснээс шингэрүүлсэн хий гаргаж авах энэ төслийг хамтад нь явуулахаар төлөвлөж байгаа.

Олон улсын зүгээр жишиг үнээр тооцох юм бол 3 мянгаас дээш илчлэгтэй хүрэн нүүрсийг бид гүн боловсруулахад 10-аас 12 тонн нь нэг тонн шингэрүүлсэн одоо хий гарч байгаа. “Эл Пи Жи”. Энэ маань олон улсын жишгээр авч үзэх юм бол бид Оросын Холбооны Улсаас шингэрүүлсэн хийг өвлийн улиралдаа 680 ам.доллараар. Өвлийн биш зуны улиралдаа 420 ам.доллараар худалдаж авч байгаа.

Улаанбаатар хот хэрвээ Багануур болон Налайх, Чойрын орд газрын хүрэн нүүрсийг ашиглаад хэрэв шингэрүүлсэн хий гаргаж авбал тонн нь ойролцоогоор

газар дээрээ 380 доллароор үйлдвэрлэх бололцоотой байна гэж ийм урьдчилсан ТЭЗҮ байгаа.

Тэгээд үүнийг үндэслээд үндсэндээ хийн түлшээ эхний 3 жилдээ Оросын Холбооны Улсаас, дараа нь бид 2027 оноос хэрэв Дорноговийн нефтийн үйлдвэр ашиглалтад орвол тэндээс жилдээ 60 мянган тонн шингэрүүлсэн хий үйлдвэрлэх ийм хүчин чадалтай болно.

Дээр нь нүүрсийг гүн боловсруулах үйлдвэр орж ирвэл бид дотооддоо ямар ч байсан 70-аас 80 хувь нь хангах бүрэн бололцоотой гэсэн ийм тооцоо. Нөгөө талдаа бол сайжруулсан шахмал түлшний одоо өгч байгаа санхүүжилтийг л хийн түлш хэрэглэж байгаа хэрэглэгчдэдээ олгоё гэсэн Агаарын тухай хуулийн заалтыг л хэрэгжүүлэх гэж энэ төсөл орж ирж байгаа.

Б.Бейсен: Энэ ажлын хэсгийнх нь нэр, албан тушаалаа танилцуулаарай.

Нөгөө талаар одоогийн өсөөд байгаа нөхцөл байдалтай холбоотой ард иргэдийн яг хүсэж байгаа энэ утааны найрлагын хоруу чанарын асуудал байж байна. Түлшний тэр стандарт шаардлага хангахгүй байгаа талаар асуудал тодорхой. Нөгөө талаар зуухны асуудал байна шүү дээ. Сая.

Үнэхээр зуух хийж байгаа тендер авсан байгууллагууд нь тэрний тендер дээр нь ажиллаж байна уу? Утаа яагаад ихсэж байна гэдэг дээр тодорхой хариулт өгөөрэй. 6 номер.

А.Амартүвшин: Уурын зуухны асуудал гэх юм бол одоогийн байдлаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас олгосон зөвшөөрлийн дагуу дулаан үйлдвэрлэх, түгээх зориулалттай буюу 100 келоваттаас дээш хүчин чадалтай 19 аж ахуйн нэгжийн 174, технологийн зориулалттай уур үйлдвэрлэгч 84 аж ахуйн нэгжийн 94. Тэгээд нийтдээ 103 аж ахуйн нэгжийн 268 зуух дулаан хангамжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор угааж баяжуулсан нүүрс буюу мидлинг түлж хэрэглэж байна.

Дээрх аж ахуйн нэгж байгууллагуудыг түлж байгаа угааж баяжуулсан нүүрс буюу мидлингийг татан авалт ашиглалтад хяналт тавин ажиллаж байгаа.

Тэгээд мидлингийн асуудал, шахмал түлшний чийгшлийн асуудал, тэгээд хагас коксожсон асуудлаар номер 4 хариулна.

Б.Бейсен: 4 номер нэмж хариулах юм байна.

Д.Өлзийбат: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. “Тавантолгой түлш” компанийн ерөнхий технологич Д.Өлзийбат.

“Тавантолгой түлш” компани 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл “Энержи Ресурс”-ийн баяжуулах үйлдвэрийн боловсруулж ангилсан эрчим хүчний нүүрс мидлингийг ашиглаж байна.

Гэрээ бол энэ нь дуусаад сая 2024 оны 11 сарын 19-ний өдөр “Эрдэнэс Тавантолгой” болон “Энержи ресурс”, “Тавантолгой түлш” компанийн хооронд гуравласан гэрээ байгуулагдаж 2025 оны 3 сараас эхлээд “Э Ти Ти”-ийн баяжуулах үйлдвэрээс гарсан мидлингийг ашиглахаар ийм гэрээ байгуулсан. Одоо өнөөдрийн түвшинд бол “И Ар”-аас бид мидлингээ авч байгаа.

Тэр дэгдэмхий бодис өссөн асуудал дээр. Ер нь “И Ар”-ын мидлингийн стандарт гэж өөрөө байгаа. MNS6226/2011 гэсэн стандарттай. Тухайн стандарт дээр бол дэгдэм.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Д.Өлзийбат: Тухайн стандарт дээр дэгдэмхий бодисын агууламжийг бол 26 хувиас ихгүй гэж заасан. Бидний өнөөдрийн хэрэглэж байгаа мидлингийн дэгдэмхий бодис 20, 21 хувьтай байна.

Ер нь эхний 2019-2020 оны үед ирж байсан мидлинг бол нэг дундаж нь 18.5 хувийн дэгдэмхий бодисын гарцтай байсан бол одоо энэ жилийн хувьд нийлүүлж байгаа мидлингийнх 20-оос 22 хувьтай болж тодорхой 3-аас 4 пунктээр өсчихсөн байгаа. Дэгдэмхий бодисын гарц.

Стандартаа мөрдөж ажиллаж байгаа. Тэр дээр бид шахмал түлш болон эрчим хүчний нүүрснийхээ стандартыг тогтмол шалгаж стандартаа мөрдөж ажиллаж байгаа.

Чийгийн асуудал дээр бид яг энэ MNS56/79 дээр бид шахмал түлшний чийг 6 хувиас ихгүй гэж заадаг. Үйлдвэрээс гарч байгаа шахмал түлш бол стандартын шаардлагыг бүрэн хангаж гарч байгаа. Магадгүй энэ зуны бороо их орсонтой холбоотой зарим нэг.../минут дуусав/

Б.Бейсен: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм. Тэгэхээр ийм байгаа байхгүй юу.

Наад мидлинг чинь 18.5 байсан. Одоо 3-аас 4 гэхээр чинь өснө шүү дээ. Утаа ч ихэснэ. Тийм ээ. Та өөрөө мэргэжлийн хүн. Мэдэж байгаа.

Хоёрдугаарт, барьцалдуулагчтай холбоотой асуудлууд байна. Барьцалдуулагчийг Даваацэрэн захирал байхдаа Монголд бид үйлдвэрлээд дахиад 5 хувь ч билүү нэг баахан л нэг ийм шпосттой л нэг юм яриад л байсан.

Одоо барьцалдуулагч тэр Даваацэрэн захирлын ярьж байсан хэмжээнд Монгол дотооддоо үйлдвэрлээд байна уу, гадаадаас аваад байна уу? Барьцалдуулагчийн чинь стандарт нь өөрөө явж байна уу, явахгүй байна уу? Энэ бас нэлээн чухал үзүүлэлттэй холбоотой асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ барьцалдуулагч дээр би хариулаад өгчхөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Дулаалга шийдсэн айлууддаа уг нь тэр урамшууллаа өгөөд явж болдоггүй юм уу? Хийн ордтой метан хийтэй холбоотой ордны холбоо асуудал байхгүй. Хүрэн нүүрснээсээ гаргаж авахтай холбоотой асуудал хөндөж байгаа юм байна гэж ойлголоо. Тийм ээ. Би барьцалдуулагч дээр хариулт авчхаад дахиад нэг тодруулчихмаар байна.

Б.Бейсен: 4 номер хариулья.

Д.Өлзийбат: “Тавантолгой түлш” компани шахмал түлш үйлдвэрлэлдээ 2 төрлийн барьцалдуулагчийг ашигладаг.

Нэг нь, цардуул суурьтай, байгалийн бентонитийн хольцтой нэг барьцалдуулагч. Дотоодын аж ахуйн нэгжээс нийлүүлдэг целлиоз болон долометой орцтой барьцалдуулагчийг ашиглаж байгаа.

Б.Бат-Эрдэнэ гишүүний түрүүний асуудаг тэр “шпос” ингэсэн гэдэг нь энэ манай дотоодын аж ахуйн нэгжээс нийлүүлж байгаа барьцалдуулагч буюу оюуны өмч нь бас манай компанид ажиллаж байсан докторын хийсэн ажил.

Тэгээд энэ оюуны өмчөөр баталгаажсан ажлыг мэргэжлийн холбогдох бүх байгууллагуудаас нь зөвшөөрөл аваад “Тавантолгой түлш” компани үйлдвэрлэлтэйгээ ашиглаж байгаа.

Стандартын тухайд “Тавантолгой түлш” компани өөрийнхөө байгууллагын стандартыг 2024 оны 3 сард нэл батлуулаад одоо ажиллаж байна. Яг энэ барьц шахмал түлшинд холбоотой барьцалдуулагчийн стандарт Монгол Улсад байдаггүй.

Тэгэхээр энэ батлуулсан стандартаа бид ирэх онд Монгол Улсын стандарт болгож ашиглахаар төлөвлөөд ажиллаж байна.

Б.Бейсен: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулья.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм.

Тэгэхээр тэр нөгөө нэг наадах чинь барьцалдуулагчийн стандарт чинь өнөөдрийг хүртэл батлагдахгүй яваад байгаатай л холбоотой асуудал давхар байгаад байна шүү дээ.

Тэгэхээр барьцалдуулагчийнхаа стандарттай холбоотой асуудлыг хөндөх хэрэгтэй байх. Би зүгээр нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Би өөрөө Байгаль орчны сайдаар ажиллаж байсан.

С.Одонтуяа сайдыг маань бага муулаарай. Яагаад гэхээр энэ утаа гэдэг бол эрчим хүч буюу дулаан үйлдвэрлэлтэй холбоотой асуудал байхгүй юу. Миний үед нэг ярьж байж Эрчим хүчний яам руу шилжүүлсэн юм. Даргыг нь.

Одоо манай С.Одонтуяа сайд дээр буцаад ирчхэж. Уг нь энэ авах ёсгүй л дээ. Эрчим хүчний сайд хариуцаад явах ёстой ажил. Эсвэл С.Одонтуяа сайд дээр тэр үйлдвэрүүдээ өгөх хэрэгтэй. Инженерүүд өгөх хэрэгтэй. Байгаль орчны яам ний нуугүй хэлэхэд тэрэн дээр инженерүүдтэй нь ч очоод тулж чадахгүй, үйлдвэртээ ч очоод ажил үүрэг чиг үүргийн хувьд хариуцлага тооцох боломжгүй. дундын зохицолгоо хангаад яваад байдаг. Нэг талдаа.

Нөгөө талдаа “Тавантолгой түлш” компанийг олон хүмүүс дуудаж үүрэг чиглэл, хурал зөвлөгөөнд дууддаг. Үүнийгээ бид төрийн түвшинд багасгаасай гэж хүсэж байгаа. Энэ хүмүүс ажлаа хийх хэрэгтэй байгаа. Энд тэндхийн хурал цуглаан, зөвлөгөөнд дуудагдахаас илүүтэй.

Б.Бейсен: Санал хэллээ. Ж.Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: л яриад л байвал бүтэхгүй ээ.

Сая одоо тэр Ерөнхий технологич гээд хүний ярьж байгааг стандартын дагуу хийж байна л гэж байна. Хаа байна тэр стандарт чинь. Ийм муу стандарт та нар баталчихсан юм уу? Одоо энэ амьсгалж байгаа агаараа хар л даа. Бид нарын уушги худлаа яриагүй шүү.

Бид түүхий нүүрснээсээ салаад арай нэг хагас коксжсон, сайжруулсан түлш гээд юм руу орлоо. Үгүй ээ, 2019-2020 онд энэ чинь аятайхан болсон шүү дээ.

Тэгээд болж болдог хэрнээ яагаад ухардаг юм. Одоо муужруулдаг түлш болчихоод байгаа шүү дээ, наадах чинь.

Тэгээд хэв нэг стандарт нь дажгүй гэж яриад байх юм. Яасан ичдэггүй юм. Энэ ард иргэдийн гадаа цуглаад 70 мянган хүн гарын үсэг зураад ерөнхий сонголт хийх хүсэлтийг гаргачхаад байж байна шүү дээ. Одоо бид энэ хэлэлцүүлгийн дараа энэ асуудлаа шийдэх гэж байна.

Төрийн ажлыг ингэж хийхгүй ээ. Энэ чинь олон түмний эрүүл мэнд, таны өөрийн чинь ч гэсэн эрүүл мэнд. Одоо миний өөрийн хийсэн судалгаа байна. Түүхий нүүрс түлснээс ялгарч байгаа ди метил сульфат 4 элэгний хавдартай хүн тутмын нэгнийх нь шалтгаан болоод молекул генетикийн түвшинд батлагдчихаад байж байна шүү дээ.

Тэгээд хэв нэг стандарт дагуу хийж байгаа гэж яаж ярьж чадаж байна аа. Яаж амнаас чинь гараад байгаа юм. Эсвэл монголчуудыг хороо гэсэн үүрэг даалгавар авчихсан юм уу. Наадах чинь арай дэндэж байна.

Яагаад энэ гарч байгаа утаандаа энэ Шинжлэх ухааны академийг хамруулаад, тэр химийн хүрээлэн энэ тэрийг яагаад хийж болдоггүй юм?

Түрүүн хэлж байна. Олон улсын байгууллагын лабораториудад тэр гарч байгаа хий утааг нь шалгуулах гээд өглөө. Зөв. Би бол итгэхгүй байна, та нарт. Олон улсын байгууллага, хараат бус байгууллагуудаар хийлгэе. Энэ чинь арай дэндэж байна шүү дээ энэ чинь.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга байж байна. Энэ утаатай холбоотой эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа та нар нотолгоо баримтууд юу байна хэлж өг. Ургийн эндэгдэл, дутуу төрөлтүүд, дээрээс нь одоо томуу, томуу тест өвчинтэй холбоотой. Тэгээд дээрээс нь энэ угаартсан хий. Нийлээд астма, юу ч болоод байгаа юм мэдэхгүй. Би хүртэл өөрөө ханиалгаад салахгүй байна. Энэ талаар мэдээллээ хэлж өг.

Бас нэг хэлэх гэж байгаа зүйл бол энэ нөлөөллийн болон сурталчилгааны материал тараах гэсэн ажлуудыг хийсэн гэж байна. Энэ үнийг нь хэлээдэх. Яг хэдэн төгрөгт хийсэн юм бэ, ямар үр дүн гарсан юм?

Тайланд хагас кокс нүүрсээр шахмал түлш хийж хэрэглээнд нэвтрүүлсэн тохиолдолд агаарын чанарыг сайжруулахад шууд нөлөө үзүүлнэ гэжээ. Ийм судалгаа хийсэн юм байна. Хэзээ хийсэн, ямар судалгаа вэ? Үүнийг чинь сонсмоор байна. Энэ референсийг нь өгөөч.

Яагаад хагас коксжуулах нүүрсээ ашиглах боломжгүй болчихсон юм? Хэн шийдвэр гаргасан юм? Үүнийг хэлж өгөөч.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 8 номер.

П.Эрхэмбулган: Анагаах ухааны доктор Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулья.

Таны хэлж байгаа асуудалтай санал бүрэн нэгдэж байгаа. Одоо энэ нийслэл хотод болж байгаа агаарын бохирдлын улмаас хүний эрүүл мэндэд ямар сөрөг нөлөө үзүүлж байгаа талаар зөвхөн Монголын биш бас олон улсын судалгаанууд хийгдсэн байдаг.

Хамгийн сүүлд Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яам хамтарсан бас нэг төслийн хүрээнд судалгаа гаргасан. Энд дотоод орчны бохирдол болон гадаад орчны бохирдлын улмаас шууд болон дам нөлөөгөөр нь хэдэн хүн нас барсан бэ гэдэг ийм тодорхой тоонууд гарсан. Энэ албажиж бас эцэслэгдээгүй байгаа байх.

Би яг Нийслэлийн эрүүл мэндийн газрын өөрийнхөө чиг үүргийн дагуу хэрэгжүүлж байгаа нийт угаарын хийн хордлогын бүртгэл болон угаарын улмаас нас барсан тоо мэдээллийг танд яг өнөөдрийн байдлаар мэдээлэл өгье.

Энэ оны 01 сарын 01-ний өдрөөс авхуулаад 12 дугаар сарын 19-ний өдрийн 8 цагийн байдлаар Нийслэлийн түргэн тусламжийн төв болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудад угаарын хийн хордлогын 1988 тохиолдол бүртгэгдсэн байгаа.

Энэ тооноос яг өнөөдрийн байдлаар 38 нас баралтын тохиолдол бүртгэгдсэн. Яг цаг гарнын өмнө 39 дэх тохиолдол бүртгэгдээд цагдаагийн байгууллагад бид мэдээллээ шилжүүлсэн байна.

Агаарын бохирдлын улмаас хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг манай нийгмийн эрүүл мэндийн төв голлож зарим судалгаануудыг сүүлийн 10 жилд хийсэн байдаг. Тухайлбал ЮНИСЕФ-тэй хамтраад дотоод орчны бохирдлыг бууруулсан буюу хепа филтерт тавьсан айлуудад хийсэн жирэмсэн эмэгтэйчүүдийн ургийн өсөлтийн судалгаа, хяналтын бүлэгтэй харьцуулж үзэхэд ургийн өсөлт багассан. Өөрөөр хэлбэл удааширсан гэсэн ийм дүн байдаг.

Одоо тухайн үеийн Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн даргаар ажиллаж байсан н.Цогтбаатар нарын хийсэн судалгаа байдаг.

Бас сүүлийн 10 жилийн байдлаар бид нийслэлийн иргэдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг авч үзэхэд яг хамгийн түрүүнд амьсгалын замд сөргөөр нөлөөлж байгаа гэсэн ийм олон улсын мэдээллүүд байдаг учраас энэ мэдээллийг харьцуулж үзэх юм шинээр бүртгэгдсэн уушгины хорт хавдрын өвчлөл 2014 онд бодит тоогоороо 140 тохиолдол байсан бол 2023 онд 208 тохиолдол байгаа юм.

Тэгэхдээ дундаа бас 2018 болон 2020 онд 189, 191 гэсэн утгатайгаар.

Тэгэхээр их огцом биш ч гэсэн бас өсөлт явагдаад байгаа. Шинээр бүртгэгдсэн уушгины хавдрын өвчлөл.

Эндээс нэг анхаарал татахаар нэг зүйл мэдрэлийн системд бас сөрөг нөлөө үзүүлэлтийг тогтоосон байдагтай холбоотойгоор мэдрэлийн системийн эмгэгүүдийг сүүлийн 10 жилээр авч үзэхэд хүүхдийн аутизмын өвчлөл 2014 онд 30 бүртгэгдэж байсан бол 2023 онд 1732 бүртгэгдсэн байгаа. Энэ бол шууд өсөлт гэж бас дүгнэх нь бас буруу байх. Харьцангуй шинэ эмгэг учраас илрүүлэг нь сайжирсантай бас холбоотой байх.

Тэгэхдээ энэ төрлийн өвчлөл нэмэгдэж байгааг эндээс харж болох нь ээ.

Б.Бейсен: Хоёр дахь асуудал дээр. Сурталчилгааны материал тараасан асуудал. 6 номер.

А.Амартүвшин: Ж.Чинбүрэн гишүүний асуусан асуултад хариулъя.

2019 оноос харьцуулахад утаа их байна гэж асуулаа. 2019 онтой харьцуулахад бидний судалгаанаас их байгаа.

Тэгэхдээ энчээ гол шалтгаан нь судалгаан дээр харахад 2019 онд бүртгэлтэй Улаанбаатар хотод явж байсан машины тоо 568 мянга гаруй байсан. Яг тоо нь 561 мянга 866 автомашин явж байсан бл өнөөдөр Улаанбаатар хотод 804 мянга гаруй автомашин хөдөлгөөнд орж байна.

Энэ дээ дээр нь нэмэгдээд мөн 35 мянган орон нутгийн дугаартай автомашин Улаанбаатарт хотод орж ирээд гарсан нь бүртгэлгүйгээр явж байна.

Хоёрт, Тавантолгой түлшний үйлдвэрлэж байгаа нүүрснийх нь тоон хэмжээг нь харахад 2019 онд 380 мянган тонн сайжруулсан түлшийг үйлдвэрлэж тухайн өвөл нийлүүлж байсан бол одоо 520 тонныг хэрэглэнэ гэж төлөвлөж үйлдвэрлэсэн байгаа. Түүнийгээ нөөцтэйгөө нийлээд энэ жилийнх дээр 560 мянган тонныг үйлдвэрлээд явж байна.

Энэ хэрэглэж байгаа одоо нүүрснийх нь тоо нь мөн нэмэгдсэн нэмэгдээд явж байгаа. Мөн энэ дээр нэмэгдэхэд манай Улаанбаатар хотод жилд 15-аас 20 мянган айл орон нутгаас шилжиж орж ирдэг ээ. Энэ дээр нь мөн шилжих хөдөлгөөний асуудлууд бас нэмэгдээд явж байгаа.

Сурталчилгааны материал гэх юм бол сайжруулсан түлшний хяналтын хэлтсээс нийтдээ 60 мянган сурталчилгааны материалыг гарч хэвлэсэн байгаа. Санхүүгийн асуудлаар нь тухайн газрынх нь дарга нь хариулах байх.

Манай нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газраас нийтдээ 18 сая төгрөгөөр 60 мянган угаарын хийгээс, мөн зуухаа хэрхэн хөөлөх вэ, зуухтай хэрхэн зөв харьцах вэ, хүүхдүүдэд зориулсан санамжуудыг 60 мянган ширхгийг хэвлэж тараасан байгаа. Одоо ч гэсэн тараах ажил нь үргэлжлээд явж байгаа.

Хариулж дууслаа.

Б.Бейсен: Ж.Чинбүрэн гишүүн тодруулъя.

Ж.Чинбүрэн: Утаанаас бултахгүй ээ. Одоо автомашин руу түлхээд утаа бол тийм асуудалгүй гэж ойлгож болохгүй.

Хамгийн энгийнээр ажиглахад зуны цаг, хаврын цаг, намрын цаг. Ингэж хөшиг татсан юм шиг булингартай угаартаад байгаа биш шүү дээ.

Тэгэхээр би түлшний тухай сайжруулсан түлш буюу муужуулсан түлшний тухай л яриад байна. Мэдээж ойлгож байна. Автомашин ихсэж байгаа. Угаар гарч байгаа, хий гарч байгаа ойлгож байна.

Гэхдээ өнөөдөр яагаад ийм яг өвлийн улирлаар утаа ихсээд байгаа юм. Яагаад тэр барьцалдуулагч бодис энэ тэр чинь одоо ийм муу чанаргүй байгаад байгаа юм. Энэ асуудал чинь өөрөө онцгой анхаарал татаад байгаа байхгүй юу.

Одоо би одоо үнэн худлыг нь мэдэхгүй байна. Барьцалдуулагч бодисыг нууцлалд авсан гэдэг үнэн үү? Энд нэг хариулт авчихъя. Энэ нууцлалд авсан уу, аваагүй юу? Барьцалдуулагч бодисыг.

Б.Бейсен: 6 номер хариулъя. 4 номер.

Д.Өлзийбат: Барьцалдуулагч бодисыг нууцлалд аваагүй ээ.

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Агаар орчны бохирдол үнэхээрийн хүнд байна.

Тийм учраас Монгол Улсын төрийн тэргүүн энэ чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдээ илүү бодитой, үр дүнтэй болгох талаарх тодорхой чиглэлүүдийг холбогдох байгууллагуудад өгсөн гэж ойлгож байгаа.

Тэр дагуу Засгийн газар дээр Үндэсний хороо байгуулагдсан юм байна. Үндэсний хороо тодорхой ажлуудаа төлөвлөж үйл ажиллагаагаа явуулах байх. Ер нь манай холбогдох байгууллагууд өнөөдрийн байж байгаа энэ агаар орчны бохирдол дээрээ үнэлгээ хийгээд яг ямар түвшинд байна гэж үзээд байгаа юм бэ? Тэр цагийн байдал дээрээ тулгуурлаж хариу арга хэмжээний чинь төлөвлөгөө яаж гараад байгаа юм бэ гэдэг асуудал хамгийн өөрөө чухал зүйл ээ.

Хэдүүлээ юм ярихаараа урт болоод дунд хугацаанд хэрэгжүүлж байж бодит үр дүнд хүрэх юмнуудаа давамгайлж ярьчихаад яг хойшлуулшгүй авч хэрэгжүүлэх ёстой цагийн байдал дээрээ үнэлэлт хийж авах ёстой арга хэмжээнүүдээ удаашруулаад байгаа юм биш биз дээ. Энэ талынхаа юмыг бодмоор байдаг.

Энэ агаарын бохирдлыг бий болгоод байгаа агуулгынх нь хувьд авч үзээд та нар чинь 4 гол юм ярьсан байна шүү дээ.

Тэгээд тэр нүүрстөрөгчийн дутуу исэл хүхэрлэг хийн асуудлыг гэр хорооллоосоо 64.1-ээс 71.7 хувийг нь гэр хорооллоос үүдэлтэй юм байна гээд. Тоосонцор, азотын давхар исэл хоёроо болохоор автомашин 52.3-аас 63.2 хувийг нь үүдэлтэй юм байна гээд үзчихсэн байна шүү дээ.

Тэгээд үүнийг бууруулах тал дээр энэ хоёр луу чиглэсэн ямар арга хэмжээнүүд аваад байна. Одоо 2020 оноос гэдэг юм уу өнөөдрийг аваад үзэхээр

гэр хорооллын чинь өрхийн тоо буюу яндангийн тоо бараг 60 гаруй мянгаар нэмэгдчихсэн. Гэр хорооллоосоо байшин руу буюу инженерийн шугам сүлжээтэй амьдрах нөхцөл рүүгээ шилжсэн нь 10-аад мянга юм уу. Ийм л юм болоод байна шүү дээ. Автомашины чинь тоо 300 гаруй мянгаар нэмэгдчихээд байна шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ дүгээрт яаж өсгөхгүй барих тухай асуудал байгаа юм.

Хоёрдугаарт, энэ хоёр үндсэн чиглэл дээрээ яаж чанар, стандартыг нь сайжруулах юм гэдэг талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээ л илүү нарийсгаж тодруулмаар санагдаад байх юм. Том юм яриад цаг алдаад суугаад байж болохгүй. Энэ хүн болгон мэднэ.

Тэгэхээр тэр нь том зорилтод хүрэхийн тулд завсрын буюу нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд гэж байдаг. Бид энэ айл өрхүүдийг бүгдийг нь.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүнд минут олгоё.

Ж.Батжаргал: Байшин хороолол гэдэг юм уу, тэр дэд төвүүд рүү шилжүүлтэл цаг хугацаа орно. Тэр хүртэл хэдүүлээ энэ иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс ямар ямар арга хэмжээнүүдийг авах юм.

Тэгээд улсууд ярихаар энэ нийгмийн сэтгэл зүйд их зөв мэдээлэл юмнуудыг нь өгмөөр байх юм. Тэр зуухны тухай ярина лээ. Би бол буруу зүйл гэж бодохгүй байгаа шүү дээ. Яагаад 30 хэдэн мянгыг нь ч гэсэн түүгээр нь шийдээд явж болохгүй байгаа юм. Тэр чинь эргээд энэ агаарын чинь чанарын агуулгад л нэмэр болох юм байгаа биз дээ.

Тэгээд энэ талынхаа юмыг бодмоор. Тэр зуухыг бас би Төв аймагт анхны туршилтыг нь хийж л байсан юм байна. 2900 айлд тэр давхар шаталттай зуухыг нэвтрүүлээд тухайн үеийн манай Ус, цаг уур, орчны шинжилгээний байгууллага сүүлийн 5 жилийнхээ үзүүлэлтүүдийг өдрөөр нь ч, агаарын температурын нөхцөлөөр нь ч хоёр нөхцөлөөр нь авч үзээд тулгалт хийгээд явахаар зэрэг 41.3 билүү.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 9 номер хариулъя.

Т.Баярхүү: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө танилцуулга мэдээлэл дээр Нийслэлээс болон Байгаль орчны яам, Монгол Улсын Засгийн газрын түвшинд дунд, урт хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар нэлээн мэдээллүүдийг дурдсан.

Ер нь ойрын хугацаанд өчигдөр бас Засгийн газрын хуралдаан, Улсын онцгой комиссын хуралдаан дээр нийслэлээс танилцуулсан. Ер нь богино

хугацаанд газын шилжилттэй холбоотой 2025 оны дүгээр улирал гэхэд тодорхой ахиц дэвшлүүд дийг гаргах ийм зорилттойгоор эхний ээлжид ажиллаж байгаа.

Хоёрдугаарт нь, түгжрэлтэй холбоотой автомашинаас ялгарч байгаа урт утааг бууруулахтай холбоотойгоор ялангуяа яндангийн шүүлтүүргүй явж байгаа автомашинуудыг журамлах, шүүлтүүрийг нь буцааж тавих, торгууль шийтгэвэр оногдуулах чиглэлээр нийслэлээс тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд, ялангуяа тодорхой гол гол уулзварууд дээр ухаалаг хяналтын камерын системүүд байршуулж цагдаагийн байгууллагатайгаа хамтраад ийм арга хэмжээнүүдийг аваад явж байгаа.

Ялангуяа автомашины нүүрсэн филтер шүүлтүүргүйгээр явснаас болж азотын давхар исэл гээд хүнд металлтай их хэмжээний хорт утаа ялгарч байна гэсэн ийм дүгнэлт мэдээллүүд байгаа учраас энэ чиглэлд арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хоёрдугаарт нь, богино хугацааны асуудал дээр нийслэлд Засгийн газрын 62 дугаар тогтоол буюу түүхий нүүрсний хэрэглээг хориглох тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр Нийслэл өнгөрсөн 8 сараас эхлээд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж нийслэлийн орох гарах постууд дээр экологийн цагдаа, холбогдох мэргэжлийн байгууллагуудаас хяналт шалгалтуудын ажлуудыг зохион байгуулж хууль бусаар оруулж байгаа, журам зөрчиж оруулж байгаа түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах чиглэлийн арга хэмжээнүүд, хяналт шалгалтын ажлуудыг авч хэрэгжүүлж байгаа.

Түүнээс гадна түрүүн хотын орлогчийн мэдээлэл дээр дурдагдсан. Ялангуяа зөвхөн түүхий нүүрснээс гадна дугуй, хаймар зэрэг бусад хориглосон шатах материал ашиглаж агаар бохирдуулж байгаа үйл ажиллагаан дээр нийслэлийн холбогдох байгууллагуудаас нийтдээ 2500 орчим төрийн албан хаагч нар яваад шалгалт хийх, айл өрхүүдээр орж зөвлөмж, сэрэмжлүүлэг өгөх ийм ажлуудыг хийгээд явж байгаа.

Үүний хажуугаар дулаалахтай холбоотой асуудлаар мөн айл өрхүүд дээр үнэлгээ дүгнэлтүүдийг хийгээд нэн даруй тухайн гэр байшингаа дулаалах шаардлага зөвлөмжүүдийг газар дээр нь өгөөд явж байгаа.

Тэр автомашины тоо хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотой дугаарын хязгаарлалтад авсан арга хэмжээний талаар хотоос бас илүү дэлгэрэнгүй хариулт өгөх байх.

Б.Бейсен: С.Замира гишүүн асуулт асууя. 6 номерын гүйцээж хариуля.

А.Амартүвшин: Нийслэлийн зүгээс автомашины тоог хязгаарлах иргэдийн хурлын шийдвэр гарсан байгаа. Агаар орчны бохирдлыг бууруулах, замын түгжрээг бууруулах зорилгоор нийслэлээс 720 мянгад барья гэдэг албан ёсны

шийдвэрийг гаргасан. Үүнд экологид ээлтэй, байгальд ээлтэй автомашин орохгүй. Нөгөө электрон автомашинууд орохгүйгээр орсон байгаа.

Мөн Байгаль орчны яамнаас гаргасан шийдвэрийн дагуу манай нийслэл болон харьяа байгууллагууд Евро-5 руу авто баазынхаа бүх машинуудыг шилжүүлэх судалгаа, шинжилгээнүүд хийгдээд явж байгаа.

Ерөнхийдөө төрийн байгууллагуудаасаа нийслэлээсээ эхлээд Евро-5 руу шилжих. Шаардлагагүй тохиолдолд автомашин ашиглахгүй байх гэдэг бодлогыг баримтлаад явж байгаа.

Нийслэлийн Засгийн газрын 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлаар 9 сараас эхлээд бүх постууд дээрээ, айл өрхүүдээрээ, аж ахуйн нэгжүүдээрээ, тэр дундаа нөгөө уурын зуух болон усан халаалтын зуухуудыг ажиллуулж байгаа аж ахуйн нэгжүүдээрээ онцгой анхаарал хандуулаад хяналт шалгалтыг хийгээд явж байгаа.

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Би тэгээд хэлмээр л байна. С.Одонтуяа сайд энэ төлөвлөлтийнхөө юмыг тэр урт, дунд хугацааныхаа бодлогын хүрэх зорилтот түвшнээ хангахын төлөө бодлого, хөрөнгө оруулалтынхаа асуудлыг тасалдалгүй эрчимжүүлэх тухай нэг асуудал байгаа юм.

Хоёрдугаарт, энэ богино хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлуудаа их тодорхой болгохгүй бол нэг том юм яриад, тэгээд энэ жижиг юмнуудаа шийдэлгүй орхиод үүнээсээ болоод хүндрэлийг улам бий болгоод байгаа чинь одоо яах аргагүй л энэ агаар орчны бохирдлыг ч өнөөгийн байдал бий болгоод л байгаа байхгүй юу.

Улсын Их Хурлын дээр тэр приусны яндан нүүрсийг нь гадагш нь гаргаад байна гээд хориглосон хууль хүртэл гаргасан шүү дээ.

Тэгээд одоо яг тэр стандарт хангаагүй яндантай автомашин хэчнээн байгаа юм. Тэрийгээ зогсоох тухай. Хүмүүсийн хэрэглэчихсэн ид утаа гаргадаг болсон үе дээр нь бид импортлоод байж болохгүй болчихоод байгаа байхгүй юу.

Тийм учраас наад импортын.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн 1 минут олгоё.

Ж.Батжаргал: Насжилтаа бодохоос өөр аргагүй л байхгүй юу. Тэгж байж энэ нэг автомашины ялгарлын асуудал, дээр нь тэр хөдөлгөөнд оролцох барих юмнуудыг нь хязгаарлах барих юмнууд байх нь ойлгомжтой байх.

Энэ нэг гэр хорооллынхоо айл өрхийн тоо, яндангийн тоог хүн амьдрах, оршин суух газраа өөрөө сонгодог юм гэдэг юм яриад дур зоргоор нь тавьчихаар

бидний авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ ямар ч үр дүнд хүрэхгүй байгаад байгаа байхгүй юу. Наадхаа яаж хязгаарлах юм бэ? Ерөөсөө гол юм чинь энд л байгаа шүү дээ. Хэчнээн мянган сайхан дэд төвүүд байгуулаад ч бид өнөөгийн энэ хөгжлийн хурдыг гүйцэхгүй ээ. Нэг хэсэг гүйцэж чадахгүй.

Тийм учраас энэ дээр бид боломжит бүхий л арга хэмжээнүүдийг тал бүрээс нь авч байж л бодлогын том цогц зорилтууд чинь ажил болж хэрэгжинэ. Энэ дээрээ одоо би илүү их анхаарч ажиллаасай гэж зориуд хэлмээр байна.

Тэгээд Их Хурлаас ажлын хэсэг байгуулагдана. Энэ Үндэсний хороо байгуулагдана. Мэргэжлийн.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн санал хэллээ. Хариулт авах юм уу? Санал уу? С.Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа.

Уг нь манай улсын хувьд энэ сайжруулсан л түлш, утааны асуудлыг яриад төчнөөн жил болж байна л даа. Харин энэ хугацаанд хэчнээн олон хүн нас барж, хэчнээн олон хүний эрүүл мэнд алдлаа. Жил болгон өвөл утаа ярина. Бид хэд ерөөсөө. Тэгээд хавар зун мартчихна. Ирэх жил дахиад өвөл болно гэдгийг мартдаг юм уу, эсвэл энэ ер нь манай улс агаарын бохирдлын хэмжээ болон авлигын үзүүлэлт харилцан холбоотой юм уу? Ер нь. Энэ тал дээр хийсэн судалгаа байгаа юм уу?

Ер нь хэн нэгний бизнесийн төлөө хүмүүс эрүүл мэндээ алдаад байгаа юм биш үү.

Манай улс өнгөрсөн долоо хоногийн байдлаар дэлхийн агаарын хортой нөхцөлөөрөө дээрээсээ 4-д бичигджээ. Эхний 4-д явж байгаа юм байна. Хэдэн зуун сая хүн амтай үйлдвэржсэн томоохон хотуудтай адилхан хэмжээний бохирдлын энэ жижиг нийслэл маань яаж бий болгоод байна гэдэг нь ойлгомжгүй байна шүү дээ.

Одоо тэгээд машин ярих юм, янз бүрийн нэг айлын пийшин ярих юм. Эцсийн эцэст дахиад нэг ард түмний нуруун дээр бүх юмыг тохох гээд байна шүү дээ. Тийм биш байхгүй юу даа.

Агаарын бохирдолтой тэмцэх бүс нутгийн бүтцээр ажиллахгүй бол бид дангаараа юмаа шийдэж чадахгүй байна. Одоо хоёр хөрштэй тохиролцоод тэд нарын ямар нөхцөл байдал байна, ямар боломж бололцоо байна тэр бүгдийг нь бид татан оролцуулах хэрэгтэй. Хамтран ажиллах хэрэгтэй.

Тийм учраас агаарын бохирдолтой бүс нутгийн хөрш зэргэлдээ улсуудыг оролцуулж тэмцэж буй ямар нэгэн санал санаачилга байгаа юу? Та бүхэнд.

Тэгээд одоогийн Ерөнхийлөгч маань Ерөнхий сайд байхад нэг өвөлдөө та бид ер нь ямар ч утаагүй өнгөрөөсөн л дөө. Яг энэ үед ямар юугаар тэр өвлийг утаагүй бид өнгөрүүлнэ. Ядахдаа тэр дээр хийсэн судалгаа байгаа юу? Ингээд өвөл болгон утаа яриад, өвөл болгон хүмүүс хордож бариад л ард түмэн эрүүл мэнд аюултай байдалд орсон байгаа шүү дээ.

Тэгээд бас цахилгааны үнэ нэмэгдсэн. Дээрээс нь. Одоо нэг боломж байна. Энэ цахилгаанаар хангаад яг өвлийн үед цахилгааны үнийг нь бууруулж өгөөд

Тэгээд гэр хорооллуудыг цахилгаан халаалтад хамааруулах яаралтай авах авах арга хэмжээ дээр энэ л байгаа. Эхний ээлжид. Дараачийн ээлжид энэ хийн юуг ашиглан бусад улс орнууд шиг ямар ч утаагүйгээр амьдрах боломж гэр хорооллуудыг хангах л ёстой. Худлаа нэг.../минут дуусав/

С.Ганбаатар: С.Замира гишүүнд гүйцээж асуултаа асууя. 1 минут өгье.

С.Замира: Одоо өвөл болгон дуутай яриад дахиж суумааргүй байна шүү. Өнгөрсөн 30 жил үүгээр өнгөрлөө. Өнгөрсөн 5, 6 жил үүгээр өнгөрлөө. Утаа яриад. Одоо шинэ 30 жилийг яаж эхэлье гээд та нар ер нь санаачилга санаа гаргаж байна. Тэрнийг л сонсмоор байна.

Түүнээс биш тэр түлшний орц, тэр стандарт тэр бүгдийг нь жил болгон ярьдаг юм. Сайжирсан юм алга л байна шүү дээ. Баярлалаа.

С.Ганбаатар: С.Замира гишүүн гарц гаргалгаа судалгаан дээр тулгуурлаж ажиллаж байна уу гэж асуулт асуулаа. 6 номерын микрофонд. Улаанбаатар хотын орлогч дарга хариулъя. Нэр усаа хэлээрэй. Протоколд тэмдэглэгдэж байгаа шүү.

А.Амартүвшин: С.Замира гишүүний асуултад хариулъя.

Улаанбаатар хотын орлогч А.Амартүвшин байна.

Агаарын бохирдлыг өнөөгийн байдалтай бид мөн 2019 оноос сайжруулсан түлш түлснээс хойш судалгааны ажлууд хийгдээд явж байгаа. Судалгааны ажлуудтай нь ЖАЙКА-тай хамтраад 2023 оноос хойш хийгдээд явж байгаа.

Тус судалгааны хүрээнд гэр хороололд 198 мянга 840 мянган айл байгаа. Эд нь нийт агаарын бохирдлын 55.6 хувь, автомашин 804 мянга 200 гаруй автомашин байгаа. Энэхүү автомашины 74.2 хувь нь 10-аас дээш насжилттай ийм автомашинууд манай Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцоод явж байгаа.

Бусад буюу дулааны цахилгаан станцаас гарч ирж байгаа үндсэн сангийн бохирдол нийтдээ 15.5 хувийг эзэлж ажиллаж байгаа.

2019 оноос хойш бид нарын хэрэглэж байгаа нүүрсний тоо хэмжээ болон Улаанбаатар хотын зам дээр байгаа автомашины тоо нэмэгдсэн байгаа. Түүрүүн

мөн Ж.Чинбүрэн гишүүн асууж байхад хариулж байсан. 2019 онд нийт манай Улаанбаатар хотод 568 мянга гаруй машин хөдөлгөөнд оролцож явж байсан бол одоо 804 мянга гаруй машин орж хөдөлгөөнд авч явж байна.

Үүн дээр нэмэгдээд мөн 35 мянга гаруй орон нутгийн дугаартай автомашин Улаанбаатар хотод хөдөлгөөнд оролцоод явж байна.

Нүүрс үйлдвэрлэлийн хэмжээнд 2019 онд 380 мянган тонн нүүрс үйлдвэрлээд иргэдэд нийлүүлж байсан. Энэ жил бид 560 мянган тонноор төлөвлөж, 520-оос 525 мянган тонн нүүрс хэрэглэгдэнэ гэж явж байгаа. Жил бүр нүүрсний хэрэглээ 10-аас 15 мянган өрхөөр нэмэгдээд явж байгаа.

Гадаадын санал санаачилгыг хэрэгжүүлж ажиллаж байна уу гэж байгаа. Хийн түлшийг Улаанбаатар хотод нэвтрүүлэх хэрэгжүүлэх ажлаар яг өнөөдөр 12.00 цагт гадаадын хөрөнгө оруулагчид хийн түлшийг Улаанбаатар хотод нэвтрүүлэх сонирхолтой.

Улаанбаатар хотын Засаг дарга хоёр долоо хоногийн өмнө Бээжин хотод бизнес форум хийсэн. Тухайн хийгдсэн бизнес форумын хүрээнд мөн хүрэлцэн ирж Улаанбаатар хотын нөхцөл байдалтай танилцах гээд хийн түлшийг нэвтрүүлэх ажлын хүрээнд экспертүүд, хөрөнгө оруулагчид яг өнөөдөр ирчихсэн газар дээр нь танилцаад явж байгаа.

Хийн түлшийг энэ жил нэвтрүүлээд хууль эрх зүйн ажлыг хууль эрх зүйн ажилд оруулаад, дээрээс нь хийн түлшний хэрэглээг зөв хэрэглэх, аюулгүй нөхцөл байдлыг нь хэрэглэх, иргэдийг соён гэгээрүүлэх ажлууд энэ жилээс хийгдээд эхэлнэ.

2025-2026 он руу шилжих өвөл нийтдээ 100 мянган айлийг хийн түлш рүү шилжүүлнэ гэсэн нь том зорилгыг тавиад нийслэлийн зүгээс ажиллаж байгаа. Ингэснээр нийт гэр хорооллоос үүдэлтэй 55 хувийн агаарын бохирдлын тал нь шийдэгдэнэ гэсэн гол зорилгыг тавиад ажиллаж байгаа.

Мөн дараа өвөлд цахилгааны асуудлуудыг тодорхой хэмжээгээр шийдээд явна гэж байгаа. Бөөрөлжүүтийн цахилгаан станцын эхний ээлжийн 150 мегаваттын нийлүүлэлт удахгүй эхэлнэ. Мөн Багануурын батарей цахилгаан станцын 50 мегаваттын.../минут дуусав/

С.Ганбаатар: Тодруулах юм уу? С.Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Таны хэлснээр гишүүн болгонд тайлбарлаад байгаа тэр гэр хороолол, машины асуудлыг би асуугаагүй л дээ. Тэр тоог бүгд цээжилсэн.

Хамгийн гол нь бид ядахдаа одоогийн Ерөнхийлөгч тэр жил яагаад энэ утаагүй явуулж байв. Энэ чинь нэг их судалгаа, тийм гадаадын туслалцаа энэ тэр

авах юм биш шүү дээ. Тэрнийг ядахдаа тэр жил яаж бид өвөлжөв гэдгийг судлаад тэрнийг яаралтай хэрэгжүүлэх боломж байдаг юм уу?

Эсвэл тэр үеийн сайжруулсан түлш одоогийн түлш хоёулаа газар тэнгэр шиг ялгаатай болчихсон юм уу? Эсвэл хэн нэгний бизнес яваад байна уу? Тэгж асуусан.

Тэгээд ч жил болгон дуутай яриад өвөл болгон суугаад байдаг. Ер нь энд ямар нэг хахууль, ямар нэг саад бэрхшээл тийм юм байгаа юм уу? Энэ бүгдийг нь ил гарга.

С.Ганбаатар: 6 номер хариулъя. Авлигал байна уу? Өмнө нь болоод байсан юм яагаад болохгүй байна вэ л гэж тодруулж байна.

А.Амартүвшин: Энэ нэг дэх өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өгсөн үүрэг даалгаварт, мөн хоёр дахь өдрийн хуралдаанаар улсын онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын дагуу тухайн үед хэрэгжүүлж байсан арга хэмжээг шат дараалалтай хэрэгжүүлэх үүрэг даалгаварууд өгсөн байгаа.

Тийм болохоор нийслэлийн зүгээс, мөн нийслэл нь дүүрэг, хороотойгоо хамтраад, бусад төрийн байгууллагуудтайгаа хамтраад бол тухайн үед хэрэгжүүлж байсан хяналт шалгалтын ажлуудыг сэргээн явуулах бэлтгэл ажлаа хангаад явж байгаа.

Нийслэл өөрийн зүгээс хяналт шалгалтынхаа ажлыг аль 9 сард хийгдээд явсан. Одоо илүү өргөн хүрээтэй бөгөөд олон айлуудыг хамарсан, мөн аж ахуйн нэгжүүдийг хамарсан хяналт шалгалтыг сайжруулсан.

Мөн түүнийхээ хажуугаар соён гэгээрүүлсэн, дээрээс нь угаарталтын хийгээс урьдчилан сэргийлэх ажлууд давхар хийгдээд явах бэлтгэл ажлыг хангаад явж байна.

С.Ганбаатар: Хугацаандаа багтааж хариулаарай. Б.Найдалаа гишүүн асуултаа асууя.

Б.Найдалаа: Энэ танилцуулга мэдээллийг үзлээ. Энэ бол ажлын төлөвлөгөө биш байна л даа. Мэдээж хэрэг.

Ямар сэтгэгдэл төрж байна гэхээр Монгол Улсад өнөөдөр утаатай тэмцэх ямар ч төлөвлөгөө байхгүй байгаа юм байна. 2019, 2020 онд нэг шахмал түлшний үйлдвэр бариад, тэгээд л хаячихсан.

Монгол Улсад ямар ч төлөвлөгөө байхгүй байна. Одоо энэ саяын танилцуулгын жишээлбэл урт ба богино хугацааны ажлууд бүгд холилдчихсон. Яг энэ төлөвлөгөөг сайн харах юм бол хамгийн олон өгүүлбэртэй их хэсэг нь хяналт шалгалт.

Өөрөөр хэлбэл нөгөө утааны мэдрэгч, юу түлж байгаа эсэх, харуул байгуулах гээд иймэрхүү л тулга тойрсон ажлууд байгаа байхгүй юу. Бусад чимэг гэмээр ажлууд нь нөгөө метро, урт хугацааны, хэзээ биелэх нь тодорхойгүй ийм ажлууд байна.

Тэгэхээр ямар ч байсан эндээс дүгнэлт зүгээр яах вэ, дараа тэр хяналтын сонсгол хийгээд бүр нарийн тодруулах ёстой. Хаана байгаа, ямар алдаа хийснээ Монгол Улс нийтээрээ сууж байгаад дарга, цэрэггүй сууж байгаад ил тод яриад тодорхойлох хэрэгтэй юм байна.

Ямар ч байсан тодорхой зүйл одоо шууд дүгнэхэд Монгол Улсад утааг бууруулах ямар ч төлөвлөгөө байхгүй.

Тэгээд яах вэ, ажлын хэсгээс одоо яг шийдвэр гаргаж байгаа, бодлого гаргаж байгаа хүмүүс байхгүй болохоор асуух асуулт бол үнэндээ утгагүй байна.

Гэхдээ нэг хэдэн хөнгөхөн зүйл асууя. Жишээлбэл, Сэлбэ, Баянхошуу төв гээд л орчихсон байна. Эд нарыг оруулснаараа тэдэн хувь тэдэн хувь буурна гэхихсэн байна. Энэ миний мэдэхээр олон жил ярьж байгаа төсөл. Бүтсэн юм байхгүй байгаа. Яг хэзээ ашиглалтад орохыг нь. Хугацаа байхгүй.

Хий гээд л ярьж байна. Яг хий чинь дөнгөж нэг санаа төдий зүйл ярьж байгаа шүү дээ.

Тэгээд гэр хороололд, гэрт, байшинд яаж хэрэгжүүлэх юм. Дэд бүтэц гээд энэ чинь асар их ажилтай. ТЭЗҮ-г нь хийсээр байгаад л хэдэн жил болох байх. BRT гээд л ярьж байна, метро гээд л ярьж байна. Хэзээ тэр нь дуусах юм. Яг тодорхой хугацаа ямар ч ажил дээр нь байхгүй байгаад байхгүй юу.

Тэр нөгөө хүлэмжийн хийг зарна гэхихсэн байна. Зүгээр зарна гэж бичингүүтээ зарчихдаг зүйл биш. Зөндөө олон ажил, үе шаттай, бэлтгэл ажил, асар их юмтай. Энэ яг тодорхой хугацаа байна уу гээд нэг асуулт.

Урт хугацааны тэр том том метро ч юм уу, 10 жилийн дараах гоё төслөөсөө гадна яг өнөөдөр богино хугацаанд яг юу хийх гэж байгаа юм бэ? Тэр хоёрыг ялгаад хэлээд өгөөч. Би урт хугацааны гоё гоё ажлыг яриагүй шүү. Яг өнөөдөр маргааш ийм ийм ажил хийх гэж байгаа, ингэсний хүчинд утаа буурна, эсвэл өнгөрсөн жил ийм ажил хийж байсан юм гэсэн юм нь яг юу байна. Тэрийг тодруулж өгөөч.

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо байгуулагдсан байна. Сайн хэрэг.

Гэхдээ С.Одонтуяа сайд яг энэ бүх асуудлыг хариуцна гэсэн үг мөн үү, эсвэл зүгээр ерөнхийд нь зохицуулагч гэх юм уу, эсвэл яг хариуцна гэсэн үг юм уу? Үүнийг жоохон тодруулж өгөөч. Ийм байна.

Б.Бейсен: 6 номер хариулья.

А.Амартүвшин: Нийслэл Улаанбаатар хотын орлогч А.Амартүвшин байна.

Б.Найдалаа гишүүний асуултад хариулья.

Орон сууцжуулалтын бодлого хэрэгжээд явж байгаа. Нэгд, 6 дэд төвөө түшиглээд 145 мянга 544 хүнийг, 41 мянга 584 хүн орон сууцад оруулахаар явж байгаа. Эхний ээлжид Сэлбэ болон Баянхошуу дэд төвүүд хийгдээд явна.

Тухайн ажил нь 2025-2028 оны хооронд хэрэгжинэ. Нийтдээ Сэлбэ дэд төв дээр 12 мянган айл, Баянхошуу дэд төв дээр 8 мянган айл хэрэгжээд явна.

Тухайн төслийг хэрэгжүүлэх холбоос дэд бүтэц нь өнгөрсөн жилийн хугацаанд татагдаад дууссан. Одоо 2 дэд төвийн хэрэгжүүлэх тендер нь зарлагдчихсан явж байгаа. Нийтдээ 4-өөс 6 хэсэгчилж хувааж тендерийг зарлах гэж байгаа. Эхний ээлжийн тендер нь гүйцэтгэгч компаниудын тендер нь зарлагдчихсан явж байгаа.

Мөн газар чөлөөлөлтийн ажил нийтдээ 70 хувь буюу 1682 нэгж талбайг чөлөөлөөд явж байгаа.

Дараачийнх нь, хийн асуудлыг дараа нь хариулчихна.

Замын асуудлаар гэх юм бол Туул хурдны замын асуудал нийтдээ 32 километр Туул хурдны зам барих төлөвлөгөө ороод явж байгаа. Нийтдээ 2025 оны 4 сард тендерийг зарлахаар төлөвлөж байна. Ажлын гүйцэтгэл нь 2007 оны 10 сард дуусахаар төлөгдөж байгаа.

Санхүүжилтийг нь барилга угсралтын тендерээр AP plus availability payment-ээр хэрэгжүүлэхээр төлөгдөөд явж байгаа.

Туул хурдны зам ашиглалтад орсноор замын хөдөлгөөний дундаж хурд 13 хувиар нэмэгдээд автомашинаас үүдэлтэй агаарын бохирдол нийтдээ 8 хувиар буурна гэж үзэж байгаа.

Дараа нь шинэ тойрог замын ажил байгаа. Шинэ тойрог замын ажил 2027 оноос 2032 оны хооронд хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа. Туул хурдны зам ашиглалтад орсны дараа хэрэгжүүлэхээр явж байгаа.

Их багтаамжтай нийтийн тээвэр буюу метроны ажил нийтдээ 17.7 километр урттай, нийтдээ 14 зогсоолтойгоор төлөгдөж байгаа. Хэрэгжих хугацаа нь 2025

оны 2 сард метроны ажлаа эхлүүлэхээр EPC-2 тендерийг зарлахаар болж байгаа. Тухайн ажлын хүрээнд хотын дарга долоо хоногийн өмнө Их Британи руу яваад холбогдох хэлэлцээрүүд болон холбогдох санхүүжилтийн асуудлуудыг нь шийдвэрлээд эхэлсэн. Метроны ажил ирэх оны бол 2 сард ажил нь эхлэхээр төлөгдөөд явж байгаа.

Тусгай замын автобус буюу BRT 2 шугамаар хийхээр төлөвлөж байгаа. Эхний шугам нь 11.9 километр, хоёрдугаар шугам нь 13 километрээр төлөгдөж байна. Тухайн ажил нь 2025 онд эхний ээлж нь хэрэгжихээр явж байгаа.

Тэгээд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжихээр явж байна. Тухайн ажил маань хэрэгжсэнээр замын хөдөлгөөний дундаж хувь 13 хувиар нэмэгдээд, авто замын үүдэлтэй бохирдол 14 хувиар байна.

Түрүүний хэлж байсан. Метро ашиглалтад орсноор замын хөдөлгөөний дундаж хурд 48 хувиар нэмэгдээд автомашинаас үүдэлтэй бохирдол 40 хувиар буурна гэж тооцоолж үзэж байгаа.

Газын холбоотой асуудлаар 7 номер үргэлжлүүлээд хариулъя.

Б.Бейсен: 7 номер хариулъя.

Ч.Батзориг: Б.Найдалаа гишүүний асуултад хариулъя.

Сэлбэ, Баянхошуу дэд төвийг түшиглэсэн нийтдээ 20 мянган айлын орон сууцын хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлэх үндсэн хөтөлбөртэй. Сэлбэ дэд төвийг түшиглээд нийтдээ 12 мянга. Нийтдээ 4 багц байгаа. 3 мянга, 3 мянгаар.

Баянхошуу дээр нийтдээ 8 мянган айлын орон сууцыг Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банкны туслалцаатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хийн түлшний хувьд ТЭЗҮ хийгдсэн үү гэж. Агаарын тухай хуульд 2023 онд урьдчилсан бэлтгэлийг хангуулж шинэ заалт орсон. Энэ нь эрчим хүчний цахилгаанаар болон хийн түлшээр дулаан хангамжаа шийдсэн тохиолдолд үүний 50 хувийг хөнгөлнө гэсэн шинэ заалт орсон. Үүний дагуу Засгийн газарт бид журам боловсруулж оруулсан байгаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтраад урьдчилсан судалгааг бид 2022, 2023 онд хийсэн. Бэлтгэл ажлын хүрээнд Байгал орчин, аялал жуулчлалын яам хуучин нэрээр Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон улстай карбон кредитийг худалдах гэрээний хүрээнд бэлтгэл ажлууд явж байгаа.

Одоо өнөөдөр бид нөхцөл байдлын үндсэн үнэлгээ гэдэг зүйлийг яг хийгдээд явж байгаа.

Эдгээр нь бид ирэх 3 жилд нийтдээ хийн түлшинд холбох 100 мянган айлын эмишн буюу нүүрстөрөгчийг буулгаснаар нэг тонныг нь 18 долларт зарах хүсэлтийг урьдчилсан байдлаар судалгаа хийгээд явж байгаа.

Ер нь карбон кредитийг сая COP-29-өөс дүрэм гарсан. Энэ дүрмийн хүрээнд Азийн орнуудад 8-аас 10 доллароор яг зарагдаж байна. Тонн тутамд нь. Европын холбоонд 7-оос 80 доллароор зарагдаж байгаа.

Тэгэхээр бид ирэх онд хийн түлшний болон хийн хангамжийн тухай хууль бас Байгаль орчин, уур амьсгалын яаман дээр явж байгаа. Энэ хуулиудыг бид түшиглээд хийн түлшний дэд бүтцийн ажлыг хийхээр төлөвлөсөн.

Үндсэн бэлтгэл ажлаа өнгөрсөн 2 жилийн хугацаанд хийсэн юм. Суурь ТЭЗҮ бол албан ёсоор гуравдагч орны ТЭЗҮ-ээр батлуулаад 2025 оны 12 сарын 31 гэхэд бүх ажил дуусаад шинэ хуулийг 01 сарын 01-нээс мөрдүүлэхээр бэлтгэл явж байгаа юм.

Б.Бейсен: С.Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр Б.Найдалаа гишүүний асуултад хариулъя.

Энэ Үндэсний хороо бол одоо нөгөө дүгээрт төсөв батлагдсан учраас ямар нэгэн төсөв байхгүй. Тэгээд ажлын алба энэ тэр гэвэл бас болчихсон.

Тэгэхээр яах вэ энэ бол нэгэнтээ Засгийн газрын тогтоол гарсан. Ямар зорилгоор гарсан бэ гэхээр та нар санаж байгаа байх. Ковидын үед Улсын Онцгой комисс байнга хуралдаж бүх салбаруудад үүрэг даалгаврыг өгч байсан.

Тэгэхээр энэ удаа агаарын бохирдол дээр онцгой байдал үүссэн гэж үзэж энэ Үндэсний хороог байгуулж байгаа.

Шадар сайд дээр яагаад ахлуулаагүй юм бэ гэхээр одоо Шадар сайд дээр бас өвөлжилт, янз бүрийн зудын асуудал ч юм уу маш олон асуудлууд гардаг.

Тийм учраас орчны бохирдлын асуудал учраас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар ахлуулсан гэж би үзэж байгаа.

Тэгэхээр энд бид бэрхшээлд дурдаад суухгүй. Ямар ч байсан ажиллана. Энэ дээр гол нь юу хийх вэ гэхээр бид одоо дунд хугацаа, урт хугацаа, яаралтай хийх ажлуудыг төлөвлөгөө гаргаад салбар хоорондын уялдааг сайн хэрэгжүүлж ажиллах юм.

Өөрөөр хэлбэл Үндэсний хороо хуралдаад танайх ийм ийм ажлыг танайх хий гэдэг үүрэг даалгавруудыг өгнө. Яагаад гэхээр хэдийгээр өчигдрийн Засгийн газрын хурал дээр Ерөнхий сайд Нийслэлийн Засаг даргыг та нар 100 хувь ер нь Үндэсний хороо байгуулагдсан ч гэсэн нийслэл 100 хувь энэ асуудлаа хариуцана

шүү. Өөрсдөө төсөвтэй хөрөнгөтэй байгууллагатай, ажиллах хүний нөөцтэй нэгжүүд байгаа учраас та нар үүнийгээ 100 хувь хариуцна. Харин энэ салбаруудад дэмжлэг үзүүлэхгүй бол болохгүй байгаа юм.

Яагаад гэхээр одоо жишээлэхэд би ганц л зүгээр жишээ хэлье л дээ. Манай энэ салбар яамдуудын харьяа одоо жишээлэхэд 117 байгууллага байгаа байхгүй юу. Энэ 117 байгууллага гэхэд л дангаараа 126 мянган тонн түүхий нүүрс хэрэглэж байгаа.

Тэгэхээр үүнийг бид Хууль зүйн яам, Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам гээд бас үүрэг даалгаврууд өгөөд энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ. Түүхий нүүрсийг нь солих, утаа гаргахгүй байх. Энэ дээр салбар ажиллах. Энэ бол зүгээр нэг жишээ байгаа юм.

Тэгэхээр бид энэ уялдааг хангана. Байнгын Онцгой комисс шиг хуралдаж үүрэг даалгавруудыг өгөхгүй бол энэ зөвхөн нийслэл бас үүнийг шийдэж чадахгүй байгаа юм.

Тэгээд сая гишүүд асууж байна шүү дээ. Одоо хийн асуудлыг яах юм гэхэд л эрчим хүчний асуудал, байшин барилгын асуудал гэхэд Барилга, хот байгуулалт ч гэдэг юм уу. Маш олон салбарын уялдаа бас шаардлагатай байгаа учраас энэ уялдааг гол нь хангах зорилгоор энэ Үндэсний хороо байгуулагдсан байгаа гэж бодож байна.

Б.Бейсен: Б.Найдалаа гишүүнд тодруулъя.

Б.Найдалаа: Миний түрүүний асуулт юу байсан юм. Одоо бид нарын ярьж байгаа саяын хариулт болохоор дандаа нөгөө дунд болон урт хугацаа яриад байгаа биз.

Биш ээ. Би С.Одонтуяа сайдыг яриагүй. Нөгөө түрүүний хариулт ярьсан шүү.

Дунд болон урт хугацаа гэдэг нь юу гэсэн үг вэ гэхээр асар сайн ажиллаад л хамгийн багадаа 3 жилийн дараа үр дүн нь дөнгөж цухуйх төдий ажил байгаа байхгүй юу. 3, 4 жилийн өмнө хийгээд эхэлчихсэн байх ёстой ажил.

Тэгэхээр одоо бид нөгөө метро яриад л мэлийгээд суугаад байгаа хүмүүс болж таарчхаад байгаа юм. Метро хаа ч байсан юм. Болоогүй байхгүй юу. Тэр байтугай тэр ярьж байгаа Сэлбэ төв ч гэсэндээ олон жил явж байгаа. Тэр ашиглалтад ороод, яндангаа буулгаад байранд ороод ингэтлээ нөгөө нэг харганын ноос түүгээд эсгий хийхтэй л адилхан зүйл яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр миний асуулт дунд, урт хугацаа биш. Яг өнөөдөр яг юу хийх гэж байгаа вэ? Яг тэр ажлуудаа ялгаад хэлээд өгөөч ээ. Тэр нь зуух юм уу, яндан юм уу, яг юу юм бэ? Тэр дээр төлөвлөгөө байна уу, үгүй юу л гэж байгаа юм.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер.

А.Амартүвшин: Б.Найдалаа гишүүний асуултад хариулъя.

Яг өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд Засгийн газрын 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаад ажиллаж байгаа. Үүнтэй холбогдуулаад мөн дундын бодлогын хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг хангаад явж байгаа.

Нийслэлийн барьж байгаа бодлого ерөнхийдөө янданг буулгах. Янданг буулгаснаар утааны асуудлыг бүрэн шийднэ гээд. Жишээлбэл, өнгөрсөн жилээс өнөөг хүртэл Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн дэд бүтцийг оруулж дэд бүтцийг татах, дэд бүтэцтэй холбох ажлууд хийгдээд явсан.

Мөн цаашлаад тархмал эрчим хүчний оруулах. Нийтдээ тархмал эрчим хүчний 10 байршилд ашиглалтад оруулах ажлуудын бас судалгааны ажлууд нь хийгдээд одоо орох гээд явж байна.

Б.Бейсен: Б.Найдалаа гишүүн тодруулъя.

Б.Найдалаа: Тархмал гээд бас яг дахиад юу ярьчихлаа. Тархмал эх үүсвэр гэж байгаад яг юуг? Энэ чинь бас л богино хугацааны асуудал биш байгаад байгаа байхгүй юу. Эрчим хүчний болон дулааны эх үүсвэр ярьж байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгээд 10 газар тархмал гэж байгаа чинь бол асар том ажил. Энэ жилдээ, ирэх жил ч үзэхгүй бид нар.

Тэгэхээр үнийгээ ялгаж хэлээсэй гэж бодож байна. Одоо энд бол хариулт хэрэггүй л дээ. Би ойлголоо. Баярлалаа.

Зүгээр бид нарын асуудал юундаа вэ гэхээр ямар ч төлөвлөгөө байхгүй. Зүгээр дунд болон урт хугацааны мөрөөдөл, ерөнхийдөө төсөөлөл, санаа төдий зүйлийг хоорондоо яриад яг нэг сонгуулийн мөрийн хөтөлбөр шиг юм яриад л яваад байдаг.

Тэгээд утаа нь хэвээрээ л байгаад байдаг. Энэ бид нарын асуудал байгаа байхгүй юу. Тийм болохоор яг одоо ажлын хэсгээс бол энэ хариулт гарахгүй. Ойлгомжтой.

Тэгэхээр яг тэр хяналтын сонсголоо хийж байгаад яг юу болсон, яагаад 3 жилийн өмнө дунд хугацааны төлөвлөгөө хийгээгүй, эсвэл хийсэн юмаа яагаад хэрэгжүүлээгүй гэдэг тухай л ярих ёстой юм байна. Баярлалаа.

Б.Бейсен: Л.Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Бид сайжруулсан шахмал түлш бол утаанаас салгана гэж хэрэглэдэг болоод 6 жилдээ нүүр золгосон байгаа. Энэ хооронд “Тавантолгой түлш” компани 1.3 их наяд төгрөг зарцуулсан байна. Одоо алдагдал нь 816.7 тэрбум төгрөгт хүрчихсэн байгаа.

Тэгээд энэ Монгол Улсын Шадар сайдаас ирүүлсэн энэ дүгнэлт дээр ийм юм байгаа байхгүй юу. Энэ сайжруулсан шахмал түлш нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос, Холбооны Бүгд Найрамдах Герман, Оросын Холбоот Улс зэрэг улсуудын стандарттай ижил түвшинд хүрсэн байна гэж байгаа юм. Тэгснээ төгсгөлийнхөө хуудсан дээр сайжруулсан шахмал түлшийн техникийн шаардлага нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 2 дугаар ангилал, Солонгосын 5 дугаар ангиллын шахмал түлшний стандартын түвшинд байна. Энэ түвшнээ ахиулах ёстой гээд заачихсан байгаа.

Тэгтэл энд хардаа “Тавантолгой түлш” компаниас ирүүлсэн гишүүдэд бэлтгэж өгсөн энэ дүгнэлт дээр 95 хувь нь мидлинг, Ухаа худаг, Энержи ресурсээс нийлүүлж байгаа тийм үү. 5 хувь нь барьцалдуулагч. Ямар ч хоргүй ээ гээд итгэмжлэгдсэн Монгол Улсын 7 лабораторийн дүгнэлтийг бидэнд явуулчихсан байгаа байхгүй юу.

Гэтэл нөгөө Шадар сайдынх нь явуулсан юман дээр дахиад энд болохгүй ээ гээд гаргачихсан байна.

Тавантолгой ордын Ухаа худгийн угаасан нүүрсний мидлинг нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартаар дэгдэмхий хийг тогтоох боломжгүй хүхрийн агууламж ихтэй.

Энд ерөнхий технологич байгаа. Тийм үү? Энэ “Энержи Ресурс”-ийн тэр угаах баяжуулах үйлдвэрээс гаргаж байгаа тэр завсрын бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотод авчирч сая 500 мянган иргэнээ хордуулахад 250 тэрбум төгрөг бид зарцуулчихсан байж байгаа. Одоо.

Ерөнхий технологич та юу хэлэх вэ? Хоргүй гээд 7 итгэмжлэгдсэн лаборатори нь гаргачихсан. Шадар сайдынх нь дээр энэ болохгүй ээ гэхсэн байгаа. Бас “Тавантолгой түлш” дээр тэр хяналт тавьдаг Ч.Буянжаргал билүү? Хэн билээ. Энэ 2 хүнээс асууя.

Энэ дээр одоо юу хэлэх юм. Одоо стандартаа соль гэсэн байна шүү дээ. Хардаа. Тавантолгойн ордын нүүрсийг угаан баяжуулах технологийг өөрчлөх, эсвэл антрацидын төрлийн нүүрсээр соль. Энэ нүүрс. Уучлаарай. Манайд байдаггүй шүү дээ. За юу хэлэх вэ?

Одоо тэгээд яах юм. Хоргүй ээ гээд лабораториуд нь гаргаад байдаг. Хоргүй гээд яваад байдаг. Гэтэл одоо энэ нь болохгүй ээ, хүхэр ихтэй, дэгдэмхий бодис ихтэй гээд гаргачихсан байдаг. Олон улсын стандартын түвшинд хүргэ гээд байдаг. Стандартчиллаа 3 удаа сольсон байдаг. Одоо алинд нь итгэх вэ?

Одоо үргэлжлүүлээд энэ шахмал түлшийг хэрэглэх юм уу? Одоо хортой гэж үзэх юм уу, хоргүй гэж үзэх юм уу?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер хариулъя.

Д.Өлзийбат: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. “Тавантолгой түлш” компанийн ерөнхий технологич Д.Өлзийбат.

“Тавантолгой түлш” компани байгуулагдахдаа “Энержи Ресурс”-ийн эрчим хүчний нүүрсийг ашиглах энэ шийдвэрийг маш олон судалгаа тооцоон дээр үндэслэж хэрэглэсэн байдаг юм байна лээ. Тухайлбал, энэ эрчим хүчний нүүрсийг маш олон эрдэмтэд судлаад одоо яг өнөөдрийн нөхцөлд Монгол Улсад шахмал түлш хийхэд хамгийн тохиромжтой нүүрс гэж сонгосон.

Яагаад гэвэл баяжмалаас гарч байгаа тэр завсрын бүтээгдэхүүн бол шинж чанарын хувьд тогтвортой болдог. Шууд уурхайгаас авч байгаа нүүрс шинж чанарын хувьд харилцан адилгүй байдаг учраас заавал баяжуулсан нүүрс ашиглах ёстой.

Энэ хүрээнд Засгийн газраас энэ мидлингийг ашиглах шийдвэр гаргаад өнөөдрийг хүртэл ашиглаж байгаа.

Тэр тухайн үед авч байсан мидлинг өнөөдрийн авч байгаа мидлингийн хоорондын зөрүү бол. Дэгдэмхий бодис. Би түрүүн хэлсэн. Дэгдэмхий бодисын гарц 3-аас 4 хүүхдээр өссөн байгаа. Өөрөөр ямар нэгэн ялгаа гараагүй ээ.

Тэр хагас коксын асуудал бид өнгөрсөн 2023 онд Эрчим хүчний яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтарсан ажлын хэсэг гараад хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэж болох эсэх, үүний техникийн үзүүлэлтүүд, экологийн үзүүлэлтүүд ямар байхаар судалгаа хийгээд туршилтын ажлуудыг итгэмжлэгдсэн лабораториудаар шинжилгээ хийгээд маш сайн үр дүн гарсан.

Ер нь шахмал түлшийг олон улсад зөвхөн хагас коксоор хийж байгаа.

Тэгэхээр Оросын Холбооны Улс болон Хятад Улсын хамгийн ойрын хоёр стандартыг л хараад үзэхэд Оросын Холбооны Улсын шахмал түлшний стандарт дэгдэмхий байц 20 хувьтай байна. Хятад Улсынх 12 хувьтай байж байна. Хятадынх бол дэгдэмхий бодисын гарц нь 12 хувь гэдэг нь үндсэндээ хагас кокс. Хагас коксын дэгдэмхий бодисын гарц бол 8-аас 12 хувьтай байдаг.

Бидний хэрэглэж байгаа мидлингийн дэгдэмхий бодис бол 22 хувьтай байна.

Энэ мидлинг маань өөрөө уурхайгаасаа стандарттай гарч ирдэг. MNS62/26/2011 гэсэн стандарттай. Энэ стандартынхаа шаардлагыг хангасан

мидлингээр “Энержи Ресурс” компани манай компанид мидлингээ нийлүүлж байгаа.

Өнөөдөр “Энержи Ресурс”-ийн мидлингээ бид үргэлжлүүлэн хэрэглэж байна. Одоо 2025 оны 3 сараас эхлээд “Эрдэнэс Тавантолгой” компанийн баяжуулах үйлдвэрээс гарсан мидлингийг ашиглана гэж одоо төлөвлөгөөнд тусгаж байгаа.

Гэхдээ энэ цаашлаад бид нарын 2025 онд бас нийслэлдээ ярьж байгаад шахмал түлшнийхээ үндсэн түүхий эдийг солих ажлыг, туршилтууд нэлээн хийсэн. Энэ юу байх вэ гэхээр зэрэг “Эрдэнэс Тавантолгой” компанийн тэг давхаргын нүүрсийг баяжуулаад баяжмалаар нь шахмал түлш хийвэл бид нарын одоо өнөөдрийн хэрэглэж байгаа түлшнээс экологийн үзүүлэлт болон техникийн үзүүлэлтүүд нь сайжрах юм. Агаарын бохирдлыг 30-аас 40 хувь хүртэл бууруулах бололцоотой юм гэдгийг урьдчилсан сан байдлаар тогтоочихсон. Үүнийг цаашлаад мэргэжлийн байгууллагуудаар дүгнэлт гаргуулаад хэрэглэж болох эсэх дээр дүгнэлт гаргуулахаар ажиллаж байгаа.

Б.Бейсен: С.Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Би дараа нь танд энэ хүснэгтийг өгөөд нэг тайлбарлахгүй бол энэ бас ойлгоход төвөгтэй юм байна лээ.

Зүгээр энгийн үгээр тайлбарлахад одоо Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс бол дотроо нэгдүгээр зэргийн түлш, хоёрдугаар зэргийнх гээд ингээд ангилчихдаг. Манайх өөрсдөө яг тогтоосон стандартгүй болохоор өөрсдөө нэг MNS56/79 гээд нэг стандарт гаргачихсан. Түүндээ харьцуулаад хэмжээд хэвийн байна гээд гаргаад байдаг.

Гэтэл бусад орныхэрэглэж байгаа түлштэй харьцуулахад манайх юугаараа ялгаатай байна вэ гэхлээр зүгээр энгийн үгээр хэлэхэд дэгдэмхий бодис нь харьцангуй өндөр байгаа байхгүй юу. Монгол Улсын энэ юу бусад орны тэр нь юунуудаас.

Солонгосын гэхэд хамгийн муу 5 дугаар ангиллын юутай л дэгдэмхий нь нисэж байгаа. Тэгэхээр энэ өөрөө маш том. Би бол одоо эрсдэлийг гаргаж байна уу гэж зүгээр өөрөө энгийн мэргэжилтэй биш хүний нүдээр харахад хэлж байгаа.

Тийм учраас энэ дэгдэмхий бодисын хэмжээг л бид багасгахад гол ажиллах ёстой. Энэ нь яах аргагүй тэгээд л нөгөө кокс, хагас коксожсон нүүрс, антрацит. Үүнийг л бид багасгах ийм зүйл байгаа юм. Энгийн үгээр хэлэхэд.

Өөрөөр хэлбэл манай нүүрс бол бид заавал сайжруулъя гэвэл ерөөсөө хагас коксожсон юугаар л сольж байж сайжирна.

Тэгээд нөгөө түрүүн хүмүүс хэлээд байсан шүү дээ. Яагаад өмнө нь яг утаа 2019 онд багасчихсан юм бэ гээд. Түрүүн С.Замира гишүүн бас асууж байсан.

Өөрөөр хэлбэл 2019 онтой харьцуулсан энэ хүснэгтүүдийг би гишүүдэд өгье. PM10 тоосонцор, энэ азотын давхар исэл энэ тэр нь бүгд өмнөх тэр онуудынхаас буучихсан. Гагцхүү энэ хүхэрлэг хий нь асар өндөр өсчихсөн байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид энэ хүхэрлэг хий өөрөө их өндөр болчихсон учраас энэ эрсдэлүүд гараад байна уу. Би энэ бүх он онуудын хэмжсэн юуг л хараад хэлээд байна л даа.

Тэгэхээр бид өмнө нь түүхий нүүрсээ сайжруулсан болгож байсан бол одоо энэ сайжруулсныгаа бүр хагас коксжсон юм руу сольж байж л энэ асуудлууд шийдэгдэх юм уу л гэж би зүгээр сая энгийн юугаар судлаад харахад л тэгж байна. Яах вэ буруу зөрүү ярьж байж магадгүй.

Б.Бейсен: Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: “Тавантолгой түлш” компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд дотоод хяналтын лабораторид давхардсан тоогоор 8 төрлийн химийн бодисыг тусгай зөвшөөрөлгүй ашиглаж байсныг илрүүлээд Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй гээд хуулийн байгууллага руу шилжүүлчихсэн байгаа юм байна.

Тэгэхээр ерөнхий технологичоо танд яаж итгэх юм. Одоо таны наад яриад байгаа энэ ямар ч хоргүй гээд байгаа юмыг чинь бид яаж итгэх юм. Бүхэл бүтэн лабораторид байна шүү дээ.

Энэ чинь маш олон хүний амь нас байхгүй юу. Улаанбаатар хотод сая 500 мянган иргэн. Одоо нас барсан хүний тоо зөвхөн утаа, угаар аараас болоод 7 мянга гарчихсан байгаа.

Түрүүн ярьж байна. Аутизмын тоо нэмэгдсэн, хорт хавдрын тоо нэмэгдсэн гээд хүний амь нас эрүүл мэндтэй холбоотой зүйл ярьж байхад зөвшөөрөлгүй химийн бодис хэрэглээд л сууж байдаг. Энэ мидлинг нь одоо больё, одоо чанарын шаардлагад хангахгүй, стандартад хангахгүй ээ гэдэг.../минут дуусав/

Б.Бейсен: Л.Мөнхбаясгалан гишүүнд 1 минут олгоё.

Л.Мөнхбаясгалан: Одоо мэдлээ, одоо сольё гээд сууж байж болохгүй. Энэ чинь хүний амь нас, эрүүл мэнд шүү дээ.

Тэгэхээр та бол ажлаа өгвөл яасан юм. Танд одоо бид нар яаж итгэх юм.

Энэ “Эрдэнэс Тавантолгой”-н архивд байх ёстой юу, хаана байх ёстой вэ. 1988-1989 онд хийсэн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл байгаа. Дорнын

нүүрс химийн хүрээлэн гээд Оросын Холбооны Улсад хийсэн. Энэ Тавантолгойн нүүрснээс 6 вагон нүүрсэнд хийсэн байдаг юм байна.

Эндээс баяжуулсан нүүрснээс гардаг завсрын бүтээгдэхүүн буюу мидлингийг хүн ам олноор оршин суусан газарт огт хэрэглэж болохгүй гэсэн дүгнэлт байдаг. Энэ дүгнэлтийг, энэ эрдэм шинжилгээний бүтээлийг надад авчирч өгөөч ээ.

Эрдэнэс Тавантолгойгоос хүн байгаа билүү, байхгүй юу? Тэгвэл би тэрийг тусдаа авъя.

Үүнээс хойшоо ямар ч тийм шинжилгээний бүтээгдэхүүн хийгээгүй.

Б.Бейсен: Хариулт хэрэггүй гэсэн үү? Тийм ээ.

Уг нь “Тавантолгой түлш” компанийн захирал Ц.Эрдэнэбаяр ирэх ёстой. Ирээгүй. “Тавантолгой түлш” компанийн Санхүү, эдийн засгийн газрын дарга нь байгаа юм байна шүү дээ.

3.Мэндсайхан гишүүн асуулт асууя.

3.Мэндсайхан: Би хэдхэн янзын зүйл асууя гэж бодож байна.

Энэ утааны асуудалтай түлшний үйлдвэр байгуулахаас нь эхнээс нь аваад л явсан хүний нэг би л дээ.

Тэгээд өнөөдөр бид утааны асуудал маань дахиад л асуудал болж байна. Энэ жил уг нь их харьцангуй дулаан өвөл болоод байгаа байхгүй юу. Яг хүйт эхлээгүй байна шүү дээ. Тэгэхэд утааны асуудал маань ийм хурцаар тавигдаж байна. Одоо 9 эхэлнэ гэж бид ярьдаг. Ингээд хүйтрээд ирэхээр, ид хүйтэн болоод ирэхэд айл иргэд маань галлагаа нэмэгдэнэ, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэнэ.

Тэгэхээр түрүүний ерөөсөө гишүүдийн асууж байгаатай л би нэг л ижил зүйл асуух гэж байна.

Өчигдөр би Х.Нямбаатар даргын ярилцлагыг хараад урт хугацаандаа бол 6 үндсэн том ажил хийх гэж байгаа юм байна. Энэ бол утааг бууруулах нь ээ гэдгийг иргэдтэй адил мэдээлэл авсан.

Бид энэ хурлын хувьд яг юу хийх гээд байна аа? Тийм ээ. Энэ том төслүүд чинь хэрэгжээд үр дүнгээ өгөх хүртэл бид утаанаас яаж салах юм бэ? Энэ мидлинг гэдэг зүйлийг чинь тухайн үед манай эрчим хүчний салбарынхан туршилтаа хийгээд л хамгийн зөв түүхий эд мөн байна гээд ингээд сонгоод л хийсэн түлш шүү дээ. Тэр үед одоо би Төрийн нарийн бичгийн дарга нь энэ ажлыг хийгээд л хариуцаад л явж байсан юм.

Тэгээд энэ технологийн хувьд алдаа гарчхав уу. Яагаад энэ утаа гараад байна. Нүдэн дээр байгаа утааг та нар технологийн дагуу явж байна гэж хэлээд байж боломгүй байна. Үүнийг үнэнээр хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ жил Улаанбаатар хот руу түүхий нүүрс орох тэр хяналтыг хэзээнээс эхэлж тавьсан бэ? Та нар яг ниргэсэн хойно нь хашхиралдлаа гэдэг л болоод байгаа байхгүй юу. Энэ түүхий нүүрс чинь ороод ирчихсэн. Ийм учраас утаа гараад байна.

Тавантолгой компанийн тэр бэлтгэсэн нөөц энэ тэрийг би харсан. Энэ бол одоо яг л хэвийн хэмжээндээ бэлтгээд явсан байна лээ. Энэ тайлан дээр байгаад байгаа байхгүй юу.

Гэтэл нүдэн дээр харагдаж байгаа утаа униар, энэ хорт байдал чинь байж болохгүй болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр ойрын хугацаанд энэ жил, одоо нэг, хоёр сард бид утаагүй болохын тулд өнөө маргаашгүй яг юу хийх гээд байгаа юм? Тэр газрын асуудал, дахин төлөвлөлтийн асуудал гээд энэ ажлууд маань үр дүнгээ өгнө. Энэ метроны асуудал.

Гэхдээ энэ чинь энэ хүртэл бид юу хийх юм бэ гэдгийг л асуугаад байгаа байхгүй юу. Тэр ниргэсэн хойно хашхирна гэдгээ л бодоод байгаа юм. Та нар түүхий нүүрсээ хот руу оруулчихсан байгаа байхгүй юу. Яг энэ дээр ямар хариулт байна.

Яагаад би үүнийг асуугаад байна гэхээр яг энэ хяналтыг чинь бид нэг бүрчлэн тавиад ажиллаж байхад тэнд яндангаас утаа гарч байна шүү гэдгийг бид мэдэж чаддаг байсан байхгүй юу. Тэгтлээ хянаж чадаж байсан байхгүй юу.

Тэгээд одоо бүр та нар маань тасарчхаад “хадганд боогоод тавьчихсан” гээд. Тэр нэг дарга одоо танай нийслэлийн дарга уу? Тэр Онцгой байдлын байдлын хурлын дараа мэдээлэл хийгээд байгаа нөхөр. Ингэж иргэдээ тавлаад л сууж байдаг.

Би нэг минутаа авчихъя.

Б.Бейсен: 3.Мэндсайхан гишүүн 1 минут олгоё.

3.Мэндсайхан: Д.Мөнхбаатар билүү? Тийм ээ. тэр одоо юу хариуцдаг хүн бэ? Ийм байдлаар асуудалд хандаж болохгүй шүү дээ. Хотынхон. Энэ нөхөртэй хариуцлага тооцох ёстой байхгүй юу.

Үгүй ээ, энэ чинь одоо гарч ирээд ард түмнээ тавлаад л төрийн хишиг гээд утааны мэдрэгч хадганд боогоод сууж байдаг тийм ард түмэн байгаа гэж би одоо тэгж бас тавлаж доромжилж болохгүй байх аа.

Хоёрдугаарт, энэ 200 мянган өрхийг бид орон сууцжуулна гэж яриад байгаа шүү дээ. Тийм ээ. Урт хугацаатай үе шаттай хийе гэж.

Та нарын хувьд ийм судалгаа байна уу? Хэчнээн айл жишээлбэл гэр хороолол жилд нэмэгдээд, хэд нь орон сууц руу ороод байдаг юм бэ? Энэ судалгаагаа хийдэг юм уу? Одоо бид 200 гэдэг тоон дотор л эргээд байгаа. Энэ 200-гаа орон сууцжуулах юм бол цаашаа бид утаагүй болчихно гэж одоо сүүлдээ итгэх гээд байна шүү дээ.

Гэтэл энэ чинь хүний амьдрал шүү дээ. Энэ 200 мянган айл чинь хэдээр тэлдэг юм, хэд нь орон сууц руу шилжээд байдаг юм?

Энэ жил цахилгааны үнэ нэмснээс болоод бид шөнийн тарифыг хуримтлуур ашиглаад дулаан ТЭН_[трубчатый электронагреватель] ашиглаад явдаг шүү дээ. Энэ асуудал чинь үнийн өсөлт нөлөөлж байгаа юу? Энэ чинь айлууд ТЭН-ээр халааж чадахаа байчаад гал түлээд байгаа байх байхгүй юу.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 3 номер хариулъя.

О.Ганбат: Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа О.Ганбат байна.

Цагдаагийн байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан 223 дугаар тогтоол, агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтийг хангах хүрээнд хориглосон бүс рүү түүхийн болон зохих зөвшөөрөлгүй баяжуулсан мидлинг оруулахгүй. Сайжруулсан шахмал түлшийг бүсээс гаргахгүй байх зорилгоор Улаанбаатар хотын 8 цэгт 24 цагаар 57 алба хаагч жилийн 4 улиралд ажиллаж байгаа.

Бид мэдээж нүдээр шалгах юм бий. Хүнийг хүчин зүйлээс давсан далд хэлбэрийн юмнуудыг бас үзэхгүй хараагүй юм байж болно.

Тэгэхдээ аль болох орж ирж байгаа машинуудыг бүрэн шалгахыг эрмэлздэг. Ялангуяа энэ хүнд даацын тээврийн хэрэгслүүд дээр.

Бид энэ замын хөдөлгөөнд Налайх, бусад Айцын даваа ч гэдэг юм уу энэ замуудаар орж ирдэг. Байнгын шалгалттай байдгийг та бүхэн бас мэднэ. Эндээс асар олон согтуу жолооч, асар олон зөрчил дутагдал илэрдэг.

Тэгэхээр бид үүгээр бид нүүрсээ оруулаад алдчихсан гэж бас итгэхгүй байгаа.

Тийм учраас энэ эргэлзээг арилгахын тулд нийслэлийн төр захиргааны байгууллагуудтай хамтраад нэгдсэн хяналт шалгалтыг нийслэлийн хэмжээнд энэ

192 мянган янданг тоолох энэ чиглэлийн юмнуудыг үзэх чиглэлээр ер нь нэг явж шалгалт хийе ээ гэдэг нэг ийм юм яригдаж байгаа.

Дээр нь нэмээд саяын яриад байгаа тэр 268 аж ахуйн нэгжийн уурын зуухны асуудал яригдаж байгаа. Түүрчээс нь буюу өчигдрөөс эхлээд Экологийн цагдаагийн алба шалгалтуудыг хийж байна. Зарим нэгэн газар түүхий нүүрс хураачихсан ийм тохиолдол гарсан. Өмнөх жилүүдийн үлдэгдэл гэдэг ийм тайлбар яригдаж байгаа. Тэрийг нь бид падаан бусад юмтай нь нягталж шалгаж үзэж байна. Тооцоо судалгаануудыг нь бас тулгаж байгаа юмнууд байгаа.

Тэгэхээр энэ юмнуудыг бас эргэж нягтлах ийм юмнуудын дараа бол бодитой хариултыг өгье өө гэсэн ийм санал байгаад байгаа юм.

Энэ онд давхардсан тоогоор 4424 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн байна. Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас тэр цахим зөвшөөрөл QR код өгдөг байж байгаа. Энэ зөвшөөрлөөр 2768 тээврийн хэрэгслээр 88 мянган тонн түүхий нүүрс, 96 тээврийн хэрэгслээр 26 мянга 800 тонн баяжуулсан нүүрс орж ирсэн ийм мэдээлэл байж байгаа. Энэ нь нийтдээ тэр өчигдөр уржигдрын мэдээлэл дээр 100 мянган тонн түүхий нүүрс тээвэрлэсэн гэж яриад байгаа нь манай энэ тооцоогоор 88 мянга гаруй тонн нүүрс тээвэрлэгджээ л гэсэн ийм тооцоо судалгаа байж байгаа.

Бид цаашид ер нь энэ хүний хүчин зүйлээс давсан хяналт шалгалтуудыг, нөгөө талдаа бас энэ улс орон хөгжиж байна, бас соёлын түвшин өөр болж байгаа учраас энэ рентген аппаратуудыг авч өгөөч ээ, энэ постууд дээр гэдэг ийм саналыг тавьж байгаа.

Постууд дээр бас тодорхой цагдаагийн хяналтуудыг сайжруулах чиглэлээр 80 гаруй орон тоог батлуулах гээд одоо бас нийслэлд хүсэлтээ өгчихсөн тооцоо судалгаа хийгээд явж байгаа юмнууд байж байна.

Зарим тохиолдолд бас хүн өвдөнө, чөлөөлөгдөнө гээд явхаар хүн хүч дутдаг барьдаг ийм юмнууд бол бий.

Тэгэхдээ хяналтыг бол бүрэн тавьсан л гэж ингэж хэлэх байна.

Б.Бейсен: 1 дүгээр микрофон хариулъя.

Ч.Буянжаргал: Асуултад нэмэлтээр тодруулж хариулъя.

Манай байгууллага бол Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар. Хяналтын хэлтсийн дарга Ч.Буянжаргал.

Манай байгууллагын хувьд сайжруулсан шахмал түлш түлж байгаа хэрэглэгчдээ хариуцаж ажилладаг ийм байгууллага.

Өөрөөр хэлбэл хэрэглэгч маань галлагаагаа хэрхэн зөв хийж байна, тэдний хэрэглэж байгаа зуух, яндан, пийшингийн нөхцөл байдал нь ямар байна, угаарын хий мэдрэгчээ ажиллуулж байна уу, үгүй юу, түлж байгаа тэр түлш нь стандартын түлшээ түлж байна уу, стандарт бус агаар бохирдуулагч түлш хэрэглэж байна уу, хадгалалт хамгаалалт нь ямар байна, угаарын хийн хордлогоос хэрхэн урьдчилан сэргийлж чадаж байна гэдэг энэ юман дээр хяналт тавьж цэвэр хэрэглэгчээ хариуцаж ажилладаг байгууллага байгаа.

Тодруулж хэлэхэд өнөөдрийн байдлаар 198 мянга 720 хэрэглэгч яг энэ түлшийг хэрэглэж байна. 96 мянга орчим айл гэрт амьдарч байна. 104 орчим мянган айл байшин сууцад амьдарч байгаа.

500 гаруй манай хяналтын ажилтан энэ угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх галлагааны зөвлөмжийг иргэддээ хүргэх ийм зөвлөн туслах энэ ажлыг бол хийгээд явж байгаа.

Энэ жил нийтдээ угаарын хийн хордлогод нийт 1988 хүн өнөөдрийн байдлаар хийн хордлогод өртсөн. Үүнийг өрхөөр нь аваад үзэх юм бол 651 өрх байгаа. Бид бүхэн энэ айлууд дээр очоод шалтгаан нь юу байв, яагаад угаартав гэдгийг тодруулдаг.

Нийт 651 өрхийн 85 орчим хувь нь зуухны нөхцөл байдал битүүмж алдагдсан энэ байдлаас болж угаартсан байдаг. Мөн нийт өрхийн 75 орчим хувь нь угаарын хий мэдрэгчгүй байсан ийм шалтгаан нөхцөлүүдийг бид тогтоосон.

Тэгэхээр би өнөөдөр яг юу хэлэх гэж байна гэхээр мэдээж урт, дунд, богино хугацааны энэ шийдлүүд дотор энэ 200 мянган өрхөөс тодорхой хувийг нь газанд шилжүүлэх, орон сууцжуулах ажил хийгдэх байх.

Тэгэхдээ яг өнөөдрийн байдлаар нэн ядуу, амьдралын боломжгүй, өөрөө зуухаа авах боломжгүй байгаа ийм өрхүүд гэр хороололд маш олон байгаа. Яг өнөөдрийн хувьд бол энэ зуухны нөхцөл байдал маш хүнд болсон.

Бид анх 2020 онд энэ түлшийг анх хэрэглэхэд иргэдийн зуухны нөхцөл байдлыг судлахад 42 мянга орчим өрхийн зуух стандарт бус битүүмж алдагдсан байсан бол өнөөдөр 2024 онд энэ тоо нэг дахин нэмэгдэж 80 орчим мянган айлын зуух маш хүнд байдалтай байгаа.

Эндээс бид 25-аас 30 мянган өрх эдийн засгийн хувьд хүндрэлтэй, ямар нэгэн хөшүүргээр зуухаа солих шаардлагатай байгаа ийм өрхүүдийг тодорхойлж гаргасан.

Энэ бол хоёр хүчин зүйлээс бид энд эерэг нөлөө үзүүлнэ гэж байгаа.

Нэгдүгээрт нь, мэдээж иргэдийн амь нас. Амь нас нь эрсдэж байгаа айлууд дээр зуухны нөхцөл байдал маш хүнд байдаг.

Хоёрт, тодорхой хэмжээгээр. Бид үүнийг тооцоолохдоо 6-аас 8 хувиар утааны агаарын бохирдол буурна гэж үзэж байгаа. Зуух нь бүрэн шаталттай зуухтай болсноор. Яагаад гэхээр одоо төлж хэрэглэж байгаа энэ зуух бол ерөөсөө энгийн монгол зуух. Ямар ч одоо дотроо ийм нэмэгдэл хүчилтөрөгчийн цамц байхгүй. Утаагаа бүрэн шатаах ийм процесс тэнд явагдахгүй шууд яндангаар утаа гарч байгаа учраас агаарт дэгдэх энэ тоосонцор, агаарын бохирдолд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа.

Тийм учраас энэ бүрэн шаталттай зуухаар тодорхой хөшүүрэгтэй урт хугацааны бага хүүтэй зээлд хамруулах байдлаар ч юм уу энэ асуудлыг шийдэх юм бол 6-аас 8 хувь агаарын бохирдол буурна. Дээр нь угаартах эрсдэл маань энэ хэмжээгээр буурах ийм үзүүлэлтүүдийг бид гаргасан.

Хугацаа дуусаж байна.

Б.Бейсен: 3.Мэндсайхан гишүүн тодруулъя.

3.Мэндсайхан: Тэр цахилгааны тариф өссөн. Тийм ээ?

Тэгээд яг хэчнээн айл шөнийн халаагуурыг хэрэглэж байсан бэ? 02 киловаттаар бид хөнгөлөлт үзүүлээд байсан шүү дээ.

Тэгээд энэ маань одоо цахилгааны үнийн өсөлттэйгөөр хэд нь цахилгаанаар дулааны асуудлаа шийдэж чадахгүй болсон? Үүнээсээ үүдээд галлагаанд орсон бэ гэдэг ийм тооцоо судалгаа байна уу? Та хэдэд. Энэ асуултыг би дахиж асуумаар байна.

Тэгээд энэ түүхий нүүрсний асуудал дээр сая би асуугаад байгаа гол юм технологийн хувьд ямар нэгэн алдаа гарчихсан юм уу? Яагаад утаа гараад байгаа юм бэ? Үүнийг яагаад хариулахгүй байна. Энэ чинь яг л нөгөө түүхий эд чинь хэвээрээ байгаа юм яриад байна шүү дээ. Өөрсдөө. Тийм ээ.

Тэгээд өмнө нь болж байсан юм одоо яагаад утаа гараад байгаа юм? Яагаад дутуу шаталт үүсээд байгаа юм? Энэ дээрээ хариулт өгөөч ээ.

Б.Бейсен: 7 номерын микрофон хариулъя.

Ч.Батзориг: 3.Мэндсайхан гишүүний хариулт асуултад хариулъя. Хотын даргын зөвлөх Ч.Батзориг.

Өнөөдөр Улаанбаатар хотод өвлийн 8 сарын хугацаанд нийтдээ төвийн эрчим хүчинд 136 мегаваттаар шууд нэмэгддэг.

Өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын 04-ийн шугамын шинэчлэл дээр шууд харьяалагдсан нийтдээ 203 мянган өрхөөс шууд 67 мянган өрх шууд цахилгаан

халаалт хэрэглэдэг гэсэн ийм үндсэн судалгаатай. Үүнээс 32 мянган өрхийн хувьд цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэнтэй холбогдуулаад түрүүн сая манай ажилтны хэлдгээр өрхийн амьжиргааны түвшин доогуур хүмүүс цахилгааны үнийн өсөлттэй холбоотойгоор өөр түүхий материал хэрэглэх, цахилгаанаа төлж чадахгүй байх ийм эрсдэл үүсэж байгаа.

Тэгээд 32 мянган зуухыг бид нийслэлээс өгөх энэ арга хэмжээг авч байгаа.

Ер нь өнгөрсөн 3 жилийн дундаж дүнгээр үзэхэд.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцэд хариулъя. 4 номер. Тодруулж хариулъя.

Д.Өлзийбат: “Тавантолгой түлш” компанийн ерөнхий технологич Д.Өлзийбат.

3.Мэндсайхан гишүүний асуултад хариулъя.

“Тавантолгой түлш” компанийн үйлдвэрлэлийн технологи бол маш энгийн түвэгшил багатай үйлдвэр. Ерөөсөө технологийн тавхан дамжлага байдаг.

Эрчим хүчний нүүрсийг 5 миллиметр хүртэл бутлаад, 5 хувийн барьцалдуулагч эдийг нэмээд, устай холиод л хэвлэх процесст оруулдаг.

Хэвлээд гарсан бүтээгдэхүүнийг хатаах төхөөрөмж буюу 120-оос 150 градуст хатаагаад савлах. Ерөөсөө технологийн үндсэн горим процесс нь л энэ.

Тэгэхээр энд бол технологи зөрчигдөөд технологи нь айхтар өөрчлөгдсөн юм бол байхгүй. Яг энэ технологиороо явж байгаа. Түүхий эдээ бид яг өнөөдрийг хүртэл солиогүй байгаа.

Яах вэ тэр дэгдэмхий бодисын гарц бол 2018 оноос өнөөдрийг хүртэл 4 нэгжээр өсчхөөд байгаа асуудал л байгаад байгаа.

Б.Бейсен: Б.Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе.

Байгалийн ухааны чиглэлээр бүр нэлээн нарийн судалгаануудыг, ялангуяа хатуу биед агуулагдаж байгаа элементүүдийн нарийн судалгаануудыг хийж хийж байгаад төрд ажиллаж эхэлсэн хүний хувьд хэлэхэд бол ер нь энэ утаатай тэмцэх асуудал, энэ утаа, агаарын бохирдлыг бууруулах асуудал нэлээн олон жил үргэлжлэх байх гэж харж байгаа.

2014 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улс яг энэ агаарын бохирдлыг жинхэнэ аюул юм байна гэж үзээд тэгээд маш тийм том далайцтай ажлуудыг шат дараалан

авч хэрэгжүүлээд өнөөдөр 2024 он 10 жилийн дараа агаарын бохирдлоо 35 хувь бууруулсан гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр манайх ер нь олон жил үргэлжлэх байх гэдэгтэйгээ бэлтгэлтэй их тийм олон зүйлүүдийг салбар дамнасан байдлаар хийх ёстой байх.

Тэгэхдээ хамгийн ойрын хугацаанд хамгийн ихээр анхаарах зүйл нь хүүхдийн эрүүл мэнд байгаа гэж харж байгаа.

PM2.5 гээд яриад байдаг. Тэр тоосонцор бол нүдэнд харагдахгүй. Тэр тоосонцор яг энэ нүүрсний шахмал түлш түлж байгаа үедээ өвөл нь их харагдаад зундаа ч гэсэндээ яг энэ PM2.5-ын бохирдол бол байсаар л байх ёстой. Тэгээд бас энэ дээр чинь салхины чигийн асуудал, хүчний асуудал, байгалийн ухааны маш олон тийм олон талын асуудлуудыг барих тийм ёстой.

PM2.5 маш их байх үед хүүхдийн биеийн жин өөрөө бага. Том хүнтэй харьцуулахад их олон амьсгалаад байгаа учраас хүнд элементийг ч тэр тоосонцроор ч тэр маш ихээр хордоод байгаа.

Тэгээд сая Шадар сайдын танилцуулгыг Байгаль орчны сайдыг уншиж байх үед нэлээн анхаарч байсан зүйлүүд нь хамгийн эхлээд энэ дээр бүгдээрээ юу хийх вэ гээд харж байлаа. Тэгэхэд бичээгүй биш бичигдсэн нэг асуудал нь сургууль, цэцэрлэгийн тэр цонхон дээр хаалтыг тавья. 23 мянган хаалтыг аль хэдийн Байгаль орчны сайд тавьсан байгаа гэж дурдлаа. 35 мянгыг тавих ёстой гэж байна.

Тэгэхээр энэ дээр яг шаардлагатай төсөв нь хэд байсан юм бэ гээд С.Одонтуяа сайдаас асуумаар байгаа юм.

Тэгээд энэ 35 мянгадаа таарах төсөв нь тавигдсан юм уу? Хамгийн эхлээд сургууль, цэцэрлэг, энэ хүүхдийнхээ эрүүл мэндийн асуудал дээр анхаарах хэрэгтэй байна. Энэ дээр бас хэлээд өгнө үү.

Эхний асуулт бол тан дээр байгаа. Тийм ээ.

Тэгэхээр хоёрдугаар асуулт нь агаарын бохирдолд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг нийслэлийн хариултаас бүх түвшинд нь харчихсан юм харагдаад байгаа байхгүй юу. Энэ шахмал түлшний асуудал, автомашины тооны асуудал, энэ хэрэглэгдэж байгаа шатахууных нь чанар гээд.

Тэгэхдээ нэг зүйл хаягдаад байх шиг байна. Та хэд маань бас хөндлөнгийн судлаачид авч ажиллуулж байгаа байх. Тэр дээр хөрсний бохирдлын асуудлыг хараадхаач ээ. Энэтхэгийн датануудыг, тайлангуудыг, Хятадынхыг харж байхад хөрсний бохирдол.../минут дуусав/

Б.Бейсен: Б.Уянга гишүүн 1 минут.

Б.Уянга: Хөрсний бохирдлын асуудлыг анхаараад өгөөч гэж хэлмээр байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Хятад Улс яасан бэ гэхээрээ хотдоо боломжит бүх газраа ногоон ургамлын бүрхэвчийг үүсгэсэн байгаа юм.

Тэгэхээр энэ ургамлын бүрхэвчийг үүсгэх дээр ойрын хугацаанд хийх ажил учраас өөрийнхөө төлөвлөгөөнд оруулаад яваад өгөөч ээ гэж бас С.Одонтуяа сайдаасаа хүсье.

Цаг уур, орчны шинжилгээний газрын болон дарга байсан юм. Одоо байдаггүй. Энэ 19 станцаар энэ агаарын бохирдлын PM2.5, 10-ын хэмжээсийг бид авч байгаа. Энэ бол нөгөө “калибрац”^[шалгалт тохируулга]-ЫН түвшиндээ хэр сайн хийгдэж байгаа вэ гэдэг дээр хэмжил зүйнхэн бас санаа зовоод байгаа.

Тэгэхээр өнөөдөр энэ бид эрүүл мэндийн асуудал их яриад байна. Энэ эрүүл мэндийн асуудалд хамгийн эхэнд суурь дата ашиглагдах ёстой. Тэгтэл суурь дата нь гарч ирдэг станцууд нь өөрөө яг калибрац нь зөв хийгддэггүй гээд байх юм. Энэ 19 станцын яг энэ тоон үзүүлэлтийн эх үүсвэр тал дээр та хариулаад өгөөч ээ. Хяналтыг нь хэн тавьж байгаа вэ?

Б.Бейсен: 8 номер хариулъя.

Л.Оюунжаргал: Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунжаргал.

Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Тийм ээ. Манайх Улаанбаатар хотын хэмжээнд 19 цэг дээр агаарын чанарын хяналт хийдэг автомат станцуудтай. Бүгдээрээ бүх үзүүлэлтүүд маань автомат хэмжигчээр хэмжигддэг. Манайх өөрөө доороо Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторитой. Энэ лабораторийн хүмүүс нь тогтмол хугацаанд калибрац ментализыг хариуцаад явж байдаг.

Тэгэхээр энэ хүмүүс минь сенсор бүр дээр нь юу нь болохгүй байна, юу нь болж байна гэдгийг нь, эвдэрсэн бол тухай бүрд нь очоод хийнэ. Сардаа ч юм уу, улиралдаа тэр калибрацын асуудлыг нь хариуцаад явж байдаг.

Хот дээр 19-өөс 6 нь байрладаг. Хотынхныг бол хотынхон хариуцаад явдаг.

Б.Бейсен: С.Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр харин яг зөв ярьж байна л даа. Энэ нөгөө бүх юм чинь нэг ийм цогц болоод байгаа. Одоо энэ тоосонцор нэмэгдэж байгаа чинь бас энэ хөрсний бохирдол, ногоон байгууламжгүй байдал. Эндээс маш их тоосонцор бий болдог.

Тэгэхээр энэ хөрсний бохирдол, ургамлын бүрхэвч, энэ бүх зүйлийг хамтад нь авч үзэх нь зүйтэй гэж хэлж байгаатай санал нэг байна.

Тийм учраас манай энэ Орчны бохирдлын Үндэсний хороо бол бас зөвхөн агаар гэж авч үзэхгүй, хөрсний бохирдол, усны бохирдол, хог хаягдлаас үүдэж байгаа бохирдол гээд бас энэ бохирдлуудыг хамтад нь авч үзэж байгаа.

Тэр цонхны хаалтыг бол ерөнхийд нь нийслэлээс хариуцаад энэ ажлыг хийсэн. Одоо 35 мянга орчим цонхны хаалт нэмж хийх яах вэ шаардлагатай гэж байгаа.

Тэгэхээр ер нь дотоод орчны бохирдол, гадаад орчны бохирдол бол бас холбоотой учраас энэ ажлуудыг хийгээд явсан байгаа. Яг хэдэн дүнгээр хийснийг нь нийслэлийнх хэлэх байх.

Тэгэхээр манай яам бол нөгөө бодлогын яам учраас бид энэ туршилтуудыг хийж байгаа. Сая бас нэг хэсэг хүмүүс ирээд Германы сургууль, цэцэрлэгийн цонхонд хийдэг юм гээд порлонтой, шүүгчтэй юмнууд авчирч үзүүлсэн. Бид үүнийг бид туршъя гээд Төв аймгийн нэг цэцэрлэг, сургуульд туршихаар гэрээ байгуулаад ажиллаж байгаа.

Тэгэхээр ер нь энэ туршилтуудыг аль болохоор хийвэл аль нь үр дүнтэй байна гэдгийг нь хэрэглэх зүгээр. Түүнээс бас шуураад л ингээд баахан юм тавьчихдаг. Сүүлд нь энэ нь эргээд л үр дүнгүй гэдэг ийм шүүмжлэлд өртөж байгаа.

Тэгэхээр нийслэлийнх хэлчих үү. Тийм ээ. Яг дүнг нь.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

А.Амартүвшин: Нийслэлийн Засаг дарга орлогч А.Амартүвшин байна.

Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Б.Уянга гишүүнтэй санал нэг байна. Хүүхдийн эрүүл мэндийг мэдээж энэ агаар орчны бохирдолтой холбоотой хамгаалах ёстой номер нэг ажил. Үүнийхээ хүрээнд нийслэл хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахаас гадна дотор орчны агаарын бохирдлыг хянаж шалгая. Дотор танхимын агаарын бохирдлыг тухайн үзүүлэлтээр нь яг гадаа агаарын бохирдлыг бид яаж хэмждэгтэй адилхан тэрийг сургууль, цэцэрлэг, албан байгууллага энэ дээр нь тавьж шинжилье гэдэг гол бодлогыг барьж авч ажиллаж байгаа.

Өөрөөр хэлэх юм тухайн анги танхимд нь PM2.5 нь яг хэд байна, PM10 нь яг хэд байна, нүүрстөрөгчийн дутуу исэл нь хэд байна. Тэгээд нөгөө хэрэглэж байгаа хивсэнцэр, хивснээс нь гарч ирж байгаа тоосонцорынх нь тоо нь хэмж хэд байна. Тэгээд тухайн анги танхимд яаж байгаа нөгөө хэдэн ягаан туяа нь хүртэл хэдий хэмжээнд байна гэдэг бүгдийг нь хэмжиж бид тодорхой хэмжээний арга хэмжээг нь авъя гэдэг үндсэн бодлогыг бариад явж байгаа.

Түүнээс өмнө тавьж байсан шиг зүгээр шууд цонхон дээр нь филтер тавиад л асуудлыг шийдлээ гэдэг асуудлаар явахгүйгээр.

Ингэснээр бид тухайн анги танхимд нь болон тухайн сургууль, цэцэрлэгт нь яг тухайн байршлаас нь хамаараад яг ямар арга хэмжээ авах вэ гэдэг нь тодорхой болно.

Энэ нь яах вэ гэх юм бол тухайн анги, танхимд нь үнэхээр агаар цэвэршүүлэх төхөөрөмжийг бид байнга ажиллуулж байх ёстой юу. Үүнээс хамааралтай нөгөө вирус байдаг. Тийм ээ. Одоо яг нөгөө ханиад томууны үеэр гарч байдаг вирус. Вирусийнх нь тоо нь их гарч ирэх юм бол нөгөө вирус устгагчаар тухайн анги, танхимыг ариутгах ёстой.

Тэгээд яг агаарын бохирдол гайгүй газарт нь одоо энэ цонхны филтер агааржуулалтыг ингээд явна.

Би тухайн ажлыг аваад 2 сар арай болоогүй явж байгаа учраас өмнө нь энэ дээр хэдэн төгрөгийн яг зардал гарсныг би яг шууд танд тэдэн төгрөг гэж хэлэх боломжгүй байна. Тэгэхдээ 6 орчим тэрбум төгрөгийн зардал гарсан мэдээлэл бол байна.

Б.Бейсен: Б.Уянгаа гишүүн 1 минут.

Б.Уянга: Одоо угаарын хий дээр гялс асуултаа багтаагаад асуугаадахъя.

Нүүрсний тэр шахмал сайжруулсан түлш дутуу шатахаараа л угаарын хий гарч ирж байх ёстой.

Тэгэхээр энэ зуухыг солино гэдгийг дэмжиж байгаа юм. Өмнө нь сольчихсон зуухуудад бас нэг ажиллах хугацаа гэж байсан байх. Өмнө нь байсан зуухнууд нь муудсан байна гэж ер нь бас байх уу? Энэ дээр нэг хариулаад өгөөч.

Тэгээд манай Л.Мөнхбаясгалан гишүүн ярихаар би яагаад сонсдог юм. 7 мянга гаруй хүн эрсдээд байна. Энэ угаарын хийнээс хойш гээд.

Тэгэхдээ Ч.Буянжаргал даргын юун дээр болохоор 1900 гэж гараад байх юм. Яг аль нь бодитой юм бэ? Бүгдээрээ одоо бас яг бодит мэдээллийг өгөх ёстой.

Тэгэхээр та яг хариуцлагатайгаар угаарын хийнд хордсон нь тэд байна, одоо амь эрсэдсэн нь тэд байна гээд хариулаад өгөөч ээ.

Б.Бейсен: 1 номер хариулья.

Ч.Буянжаргал: Миний хэлсэн 1988 гэдэг бол энэ бол Нийслэлийн Эрүүл мэндийн газар манай хоёр холбоотой ажилладаг. Яагаад гэхээр эрүүл мэндийн газарт ирсэн дуудлага дээр бид дуудлагыг аваад очоод шалтгаан нөхцөлийг нь тодруулаад тухайн айлийг дахиж эрсдэлд оруулахгүйн тулд бид урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байгаа.

Энэ 2024 оны 01 сарын 01-нээс өнөөдрийг хүртэл 1988 хүн угаарын хийн хордлогод өртсөн. Тодорхой хэмжээгээр одоо эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан гэж ойлгож болно.

Нас барсан хүний тоог бол Нийслэлийн эрүүл мэндийн газраас хариулах байх аа.

2010 оноос 2013 оны хугацаанд нийтдээ Мянганы сорилын сан, Цэвэр агаар сангийн төслийн хүрээнд 150 орчим мянган төслийн зуухыг тараасан байдаг гэсэн ийм тоо баримт явдаг. Тэгэхдээ энэ маань одоо бидний яг авсан судалгаан дээр нийт хэрэглэгчийн 20.../минут дуусав/

Б.Бейсен: С.Одонтуяа гишүүн нэмж хариулья.

С.Одонтуяа: Тэгэхээр зуухны асуудал дээр бид нүүр тулах ёстой юм.

Сая хэллээ. 2010 онд би бас Улсын Их Хурлын гишүүн байхад бид тэр зуух тарааж байгаа дээр очоод Мянганы сорилын сантай хамт хэмжээд тэндээс тэр утаа гарахгүй байгаа зуухаас нь банкууд карбон кредит дээрээ цуглуулаад ажиллаж байсныг санаж байгаа байхгүй юу. Яг 2010 онд. Тэгэхэд үнэхээр тэр зуухнаас утаа гарахгүй зуухууд зөндөө байсан.

Тэгэхээр энэ ашиглалтын хугацаа дуусаад байна гээд өчигдөр Х.Нямбаатар дарга хэлээд байсан шүү дээ. Энэ чинь ингээд нэг бүтээгдэхүүн л юм болохоороо доторх юм нь салж унадаг юм уу, ингээд нэг ийм чанарын шаардлага хангахгүй болдог юм байна.

Би өөрөө засаг дарга байсны хувьд Баянгол дээрээ бас энэ туршилтыг хийе гээд зориглоод 2023 оны улсын төсөвт суулгаад бид Баянгол дээр хэдэн айлд нэг хороог авч байгаад, энэ тэнд биш яг нэг хороон дээр тэр.../минут дуусав/

Б.Бейсен: С.Одонтуяа гишүүн гүйцээж хариулья.

С.Одонтүяа: Давхар шатлалтай зуухыг тавьсан. Тэр бол үнэхээр ямар ч утаа гардаггүй байхгүй юу. Би одоо бүр гишүүдийг тэр хүмүүст нь очоод үзүүлсэн ч.

Намайг юун дээр буруутгаж байгаа гэхээр дураараа чанаргүй юм авсан. Тэр бол үнэхээр олон хүний амь аварч байгаа гэхээр угаартдаггүй зуух байхгүй юу. Яагаад гэхээр таны саяын хэлдэг угаартана гэдэг чинь давхар шатахгүй байгаа л асуудал байгаа шүү дээ.

Түрүүн Б.Найдалаа гишүүн хэлсэн. Богино хугацаанд юу юм бэ гэдэг чинь богино хугацаанд хүссэн хүсээгүй одоо тэр айлуудын. Одоо яах аргагүй л Монгол айл чинь галаа түлээд сурчихсан байдаг юм байна л даа. Хэдийгээр цахилгаан залгасан ч гэсэн л нөгөө галаа түлээд л.

Тэгэхээр бид энэ шийдлүүд байгаа юу байгаа. Хятадад хэрэглэж байна, Солонгост хэрэглэж байна. Тэгэхээр энэ зүйлүүдийг бид туршилтаар хийгээд үзчихсэн. Өмнөговь аймагт ч туршсан, Төв аймагт туршсан. Манай яам туршиж байна. Ингээд Баянголд туршиж байгаа.

Тэгэхээр энэ бол хүссэн хүсээгүй л бид үнэнтэйгээ эвлэрэх ёстой л болчихоод байна л даа.

Б.Бейсен: 9 номер хариулъя.

Д.Эрхэмбулган: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Д.Эрхэмбулган байна.

Б.Уянга гишүүний асуултад нэмж хариулъя.

62 дугаар тогтоол гарснаас хойш угаарын хийн хордлогын бүртгэлийг тусад нь бүртгэхээр Эрүүл мэндийн сайдын болон Шадар сайдын тушаалаар журамласан байдаг.

Өөрөөр хэлбэл өмнө нь осол, гэмтэл, хордлого гэсэн олон улсын өвчний ангиллаар бүртгэдэг байсныг яг ахуйн угаарын хийн хордлогыг Нийгмийн эрүүл мэндийн төв улсын хэмжээнд бүртгэдэг болсон.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа байгууллагууд болон Нийслэлийн түргэн тусламжийн төвд ирсэн угаарын хийн хордлогын мэдээллийг манайх өдөр бүр нэгтгээд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв рүү явуулдаг. Саяхнаас энэ дээр Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төв бас мэдээллийг энэ үйл ажиллагаанд оролцоод явж байгаа.

Тэгэхээр албан ёсны энэ ямар ч эргэлзээ байхгүй ийм тоо гэж ойлгож болно.

Нийт 1988 угаарын хийн хордлогын тохиолдол, 39 нас баралтын.../минут дуусав/

Б.Бейсен: С.Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Утаа бол энэ өнөөдөр болж байгаа зүйл биш ээ. Сүүлийн 20, 30-аад жил л болж байгаа зүйл. Бид утааныхаа оношийг зөв тавих ёстой.

Утаа юунаас бий болсон бэ гэвэл ер нь энэ материалаас уншихад хяналт шалгалт сул байгаад л, баахан түүхий нүүрс орж ирээд л шатаагаад л, шатаах ёсгүй зүйлүүдийг шатаагаад байгаа учраас л гэдэг ойлголтыг авч байна.

Миний ойлголтоор сүүлийн 30 жилийн улс төрчдийн увайгүй дээрэм хулгай Монголын улс төрчдийн л бүтээл нь өөрөө утаа шүү дээ. Ажилгүйдэл, ядуурал бол утаа. Яг симптом илэрц нь утаа болохоос биш цаанаа цахилгаан, дулаанаа л хүчрэхгүй байгаа улсууд даарахгүйн тулд, тэр шөнийг нэг аятайхан дулаахан авахын тулд юу ч хамаагүй л шатааж байгаа шүү дээ. Бид үүнтэй үзэж байгаа.

Тэгэхээр би тэрийг зөвтгөж байгаа юм биш. Одоо чуулган дээр цахилгаан, дулааны үнийг 64 хүртэл өсгөх гээд байна. Болиоч ээ та нар энэ дээр зөөллөх бодлого байна уу? Үүнээс чинь болж зөндөө олон. Би 17 шалтгаан хэлж байсан. Ийм үр дүн гарна гэж байсан. Тэрний 3 нь энэ утаатай холбоотой. Нэг ч хүн яриагүй л дээ. Уухайн тас бүгдээрээ л реформ хийгээд зөвшөөрсөн.

Тэгэхээр энэ 25-аас 30 мянган өрх нэн ядуу гэж байна. Та нар зуух өгнө л гэж ярьж байна. Маргааш тэр зуухыг чинь зах дээр аваачаад зарчихдаг шүү дээ.

2012-2013 онд утаа гэнэт өссөн. Шалтгаан нь юу юм бэ гэвэл олон улсын байгууллагаар тоолууржуулсан. Хүмүүс цахилгаан, дулаанаа шууд төлдөг болсон гэсэн үг. Ний нуугүй хэлэхэд.

Энэ макро түвшний асуудал. Өнөөдөр урд хөлийг бүдэрвэл хойд хөлийг ташуурдана гэдэг шиг Улаанбаатар хот онцгой байдал нэг хэдэн хүн рүү л яриад байна. Цаад утгандаа ажилгүйдэл, ядуурал, авлигалыг бий болгосны л үр дүн нь энэ байгаа юм.

Тэгээд би асуух гэж байгаа зүйл гэвэл энэ цахилгаан, дулааны асуудал дээр холбогдуулаад, өссөнтэй холбогдуулаад та нар тооцоо, судалгаа хийсэн үү? Эрчим хүчний яам болон холбогдох тэр хүмүүстэй хэлэлцээрт орж энэ дээрээ зөөллөх бодлого барих уу? Энэ янзаараа ингээд туушиндаа дуусах уу?

Би одоо яг чуулган дээр асуухад цахилгаан дулаан 64 хувь хүртэл өсчихлөө. Үүнээс чинь болж хүмүүс юу төлдөг гэж бодож байна Та нар. Покрышк_[дугуй] түлдэг. Юу түлдэг гэж бодож байна. Улаан тоосгыг. Солярк хулгай хийдэг учраас улаан тоосгыг солярканд бүтэн 18 цаг байлгаад тэрийг нь дараа нь түлэхэд 12 цаг нэг

шөнөө даадаг. Энэ асуудлууд дээр одоо тэр хүмүүсийг захиргааны аргаар очоод шөнө хүйтэн хоно гэж хэлж чадахгүй шүү дээ.

Та нарын тэр шидэт түлшийг чинь хүртэл худалдаж авч чадахгүй байгаа. Ийм гарц гаргалгаан дээр та нар юу хийсэн бэ? Яг одоо энэ 30 мянган айл дээр.../минут дуусав/

Б.Бейсен: Хариулъя. 7 номер уу? 7 номер хариулъя.

Ч.Батзориг: С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хотын даргын зөвлөх Ч.Батзориг.

Сая цахилгаан, дулааны үнэ нэмэгдсэнтэй холбогдуулаад өмнө нь байсан, одоо дээр нь бас нэмэгдээд түрүүн ярьдаг 32 мянган айл бол үндсэндээ төвийн 6 дүүрэгт нэлээн хүндрэлтэй буюу цахилгаан, дулааныхаа үнийг төлж чадахгүй ийм нөхцөл байдалтай байгаа гэсэн урьдчилсан судалгаа хийсэн. Энэ бол төвийн дүүргүүдээр хийсэн судалгаа байгаа юм.

Ер нь бид Засгийн газар луу нэг асуудал оруулах гэж байгаа нь цаашдаа бид энэ Агаарын тухай хууль батлагдсантай холбогдуулаад цахилгаан эрчим хүчний үнийг шөнийн тарифт 50 хувь хөнгөлж байгаатай яг адилхан заалт мөн хийн түлш хэрэглэж байгаа хэрэглэгчдэд адилхан байхаар заалт шинээр орсон юм.

Үүнтэй холбогдуулаад Засгийн газар луу шинэ журам боловсруулж Эрдэс баялгийн яамтай хамтарч оруулж байгаа. Энэ маань өөрөөр хэлбэл хэрэв цахилгаанаар хангасан хэрэглэгчийн шөнийн тариф 100 киловаттаас дээш гарч байгаа тарифыг 50 хувь хөнгөлдөгтэй адилхан хийн түлшээр дулаан хангамжаа шийдсэн тохиолдолд мөн бас 50 хувиар хөнгөлөх урамшууллийг олгодог журмыг батлуулахаар оруулах гэж байгаа.

Хэрвээ энэ журам орвол хэрэглэгчид хийн түлшээр өөрсдийгөө дулаан хангамжаа шийдвэрлээд тодорхой хувийг нь бид сайжруулсан шахмал түлшинд өгдөг санхүүжилтээсээ мөн бас хийн түлшинд өгье гэсэн энэ зохицуулалтыг шинээр оруулж байгаа.

Ер нь цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдсэнтэй холбогдуулаад дулааны үнэ бас нэмэгдэж байгаа. Үүнтэй холбогдуулаад бид одоо байгаа дулааны тархмал бие даасан уурын зуухуудыг хийн түлшинд шилжүүлэх ажлыг хувийн хэвшилтэй хамтарч хийж байна.

Ингээд хийн түлшээр дулаан хангамжаар хийсэн тохиолдолд бид эхний ээлжид ямарч байсан хийн түлш дээрээ хөнгөлөлт үзүүлэх энэ асуудлыг Улаанбаатар хотын зүгээс Засгийн газар луу оруулж байгаа юм.

Б.Бейсен: С.Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Хийн түлштэй болно гэдэг сайхан мөрөөдөл санаанд бол би ч гэсэн их дуртай байгаа. Энэ хэрэгжвэл бөөн баяр. Тэр хүртлээ хэдэн жил болно.

Тэр хүртэл хүмүүс үнэтэй цахилгаан, дулаанаа хэрэглэхгүй, тэгээд тэр покрышк, тэр улаан тоосгоо түлэх болж байгаа тохиолдолд та нарт ямар нэгэн шийдэл байгаа юу? Захиргааны аргаар та нар даар. Энэ шөнө битгий үүнийгээ түл гэх юм уу?

Цахилгаан, дулаан, тэр нөгөө шидтэй гоё түлшийг чинь хүртэл худалдаж авч чадахгүй байгаа 32 мянган айл байгаа гэж байгаа шүү дээ. Энэ дээр шийдэл байгаа юу?

Тэр хүмүүс чинь Үндсэн хуулиар олгогдсон амьд явах эрхээ эдэлж байгаа шүү дээ. Тэр амьд явах эрхийг нь эдлүүлэхгүйн тулд та нар ямар арга зам гаргалгаа байгаа вэ л гэж би тодруулж асуусан. Өнөөдөр ажилгүйдэл, ядуурлаасаа болж өнөөдөр бид утаатай байгаа. Монгол орон өнөөдөр хамгийн амиа бодсон ард түмэн. Газын зурваст палестинуудаа шахдаг, Кейптаунд харуудаа шахдаг.../минут дуусав/

Б.Бейсен: С.Ганбаатар гишүүний асуултад хариулья. 6 номер.

А.Амгаланбаатар: С.Ганбаатар гишүүний асуултад хариулья.

Цахилгаан болон нүүрснээс гадна буюу гуравдагч эрчим хүчнээс буюу сэргээгдэх эрчим хүчнээс тухайн айлуудыг холбох ажлууд эхэлчихсэн явж байгаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөр энэ ондоо 45 зорилтот бүлгийн айлийг холбож тухайн айл дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагаас нэгдүгээр шатны ажил нь хэрэгжээд явсан. Энэ 45 айл дээр хэрэгжүүлсэн ажил амжилттай болсны үндсэн дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс дахиад 1000 айлийг хамруулж ажиллана.

Дараагийн жилүүдэд 10 мянган айлийг хамруулж ажиллахаар гэрээ хэлэлцээр хийгдээд явж байгаа.

Тухайн айлуудыг сэргээгдэх эрчим хүч дээр холбосноор өвөлдөө шууд ТЭН_[трубчатый электронагреватель]-ээрээ халчихдаг. Зундаа зуны хэрэглээндээ буюу телевиз, утсаа цэнэглэх ч юм уу, бусад зүйлүүдээ холбож болчихдог.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Уучлаарай. Агаарын бохирдлын 55 хувь нь гэр хорооллоос тоосонцор РМ-ийн 17 хувь нь гэр хорооллоос гэдэг тоо худлаа тоо.

Худлаа юман дээр үндэслэхээр гарах шийдвэр нь худлаа байж таарна.

Нэгдүгээрт, гэр хорооллын агаарын бохирдлын тэр нүүрснээс гарч байгаа утаа өвөл гарч ирдэг. Хэрвээ 50 хувь нь байсан юм бол зун хааччихсан юм. Одоо ингээд худлаа үр дүн тооноос болоод гол асуудал нь машин юм шиг яриад байгаа байхгүй юу. Зун болохоор машин явдаг шүү дээ. Утаа байдаггүй шүү дээ. Хортой элементүүд бол бий. Хийнүүд. Нөгөө бидний айгаад байгаа утаа чинь байхгүй.

Тэгэхээр буруу дүгнэлтүүд.

Нэгдүгээрт нь, үүнээс болоод гэр хороололд дулаан сууц барьж байж цахилгаанаар халаана уу, хийгээр халаана уу, нүүрсээр халаана уу, бага түлш хэрэглэнэ, бага утаа гарна. Хашаандаа дулаан байшин барихад ипотекийн эх үүсвэр олгоно гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулсан боловч санхүү дээр нь эх үүсвэр тавиагүй. Төсөв дээр зөндөө ярьсан. Одоо байхгүй. Ипотек дээр хэдэн төгрөг тавих нэг асуудал.

Дараагийнх нь худлаа дүгнэлт хийсэн учраас цахилгаан машиныг татвараас чөлөөлөх асуудал ярьж байгаа юм. Хятадын цахилгаан машиныг утаагаар далимдуулж дэмжих нь Монголын бодлого биш.

Дараа нь хий. Утаанаас болоод хийг дэмжих. Хий хэрэгтэй. Гэхдээ Оросын хийг дэмжих нь Монголын бодлого биш. Монголд нүүрснээс ямар хий гаргах гэж байгаа юм гэдэг нь асуулт. Байгалийн хий юм уу, савлагаатай хий юм уу. Савлагаатай пропан, бутан юм бол түүнтэй төстэй нүүрснээс DME_[dimethyl ether-диметилийн эфир] гэдэг хий гаргах ТЭЗҮ хийгээд баталчихсан. Аль арван хэдэн жилийн өмнө.

Хэрвээ байгалийн хий юм бол Багануурын нүүрсэн дээрээс үйлдвэрлээд байгалийн хий гаргаад түгээх ТЭЗҮ хийгээд баталчихсан. Бас хэдэн жилийн өмнө.

Хий ашиглаад болох юм бол Монголын хий ашиглана.

Дараагийн буруу дүгнэлт. Цахилгаан станц 350 тэрбум төгрөгийг жил болгон түлшний дотаци болгож өгч байна гэсэн. Тэрийгээ одоо хийд өгье гээд. 350 тэрбум төгрөгөөр 100 мегаваттаар цахилгаан станц барина. Дулааны цахилгаан станц. 5 удаа барих юм бол 500 мегаватт. 500 мегаваттаар 150 мянган айлийг хангана. Цахилгаан халаалтаар болоод, дулаанаар. Гэр хорооллын босоо чиглэлүүдийн дунд нь нэг нэг станц барихад нэлээн хэсгийг нь хангачихна.

Тэгээд дээрээс нь түлшин дээр. Би нэмэлт нэг минутаа залгаад авьчихъя. Тэгэх үү.

Дараагийнх нь түлш, шахмал түлш. Шахмал түлшний дэгдэмхий бага байх юм бол тортог бага гарна. Дэгдэмхий бага байх юм бол илүү агаар хэрэгтэй. Агаар байхгүй учраас угаар хий гарч хүн ойртуулдаг байхгүй юу.

Б.Бейсен: Ж.Золжаргал гишүүнд 1 минут сунгая.

Тийм учраас дэгдэмхий бага байна гэж хэт халуураад хагас коксоор түлэх юм бол угаарын хий илүү ялгарна. Утаа нь бага. Хортой чанар нь эрсдэлтэй. Тэр нь зуухнаасаа хамаардаг. Үнэн. Ховх сороод авчих юм бол гэр лүү гарч ирэхгүй. Тэгэхдээ ямар орчинд монголчууд амьдардаг билээ. Тэрийгээ бодмоор байгаа юм.

Тэгээд түлшний энэ дүгнэлт дээр би харсан. Дэгдэмхий багатай антарцид нэмэх. Болж байна. Магадгүй хагас кокс байвал. Баяжуулсан эрчим хүчний нүүрсээр хийх хэрэгтэй. Үнслэг бага байх ёстой. Түүрүүн Байгаль орчны сайдын яриан дээр гарсан. Дэгдэмхий чухал гээд.

Хоёрдугаарт нь, үнслэг байхгүй юу. Үнс өндөр байна. Үнс чийг өндөр байхаар тал нь шатдаггүй материал. Шатахгүй материалаас угаарын хий гарна. Дутуу шатдаг.

Тэгэхээр яндангүй бүс гэдгийг хийгээд тэндээ энэ дотацынхаа мөнгөөр цахилгаан станцуудаа бариад алхам алхмаар явъя л гэж байгаа.

Б.Бейсен: 7 номер хариулъя.

Ч.Батзориг: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Засаг даргын зөвлөх Ч.Батзориг.

Би өөрийн хариуцаж байгаа хийн түлштэй холбоотой хоёр асуултад хариулъя.

Дэлхийн банкнаас 2022 онд Багануурын хүрэн нүүрсэн дээр метан хийний ТЭЗҮ хийгдсэн. Энэ ТЭЗҮ-ний хүрээнд 1.3 тэрбум төгрөгийн наашаа татах хөрөнгө оруулалтын санхүүжилттэй ТЭЗҮ байгаа.

Түүрүүн ярьсан хүрэн нүүрст түшиглэсэн хийн станц гэдэг маань өөрөө шингэрүүлсэн хий гаргаж авна.

Өөрөөр хэлбэл LPG^[liquefied petroleum gas]. Шингэрүүлсэн хий дотор пропан. C₄H₁₀ гэсэн химийн томъёотой. Тээвэрлэлт нь шингэнээр явна.

Байгалийн хийний хувьд энэ удаагийн гэр хорооллын хэрэглэгчдийг холбох дээр байгалийн хий оролцохгүй. Зөвхөн нефтийн дайвар бүтээгдэхүүн буюу шингэрүүлсэн хийг бид энд үзнэ.

Оросын Холбооны Улсаас авахаас гадна 3 эх үүсвэрийг бид тооцож байгаа.

Нэгдүгээрт нь, 2027 онд Дорноговь аймгийн нефтийн үйлдвэр хэрвээ ашиглалтад орвол жилдээ 60 мянган тонн нефтийн дайвар бүтээгдэхүүнээс гардаг хий гарна. Үүнийг бид хэрэглэнэ.

Дээр нь мөн Нялга, Чойр, Багануурын уурхайг түшиглэсэн нефтийн шингэрүүлсэн хийн станц байгуулна. Энэ шингэрүүлсэн хийн станц. Би түрүүн хариулсан. 10-аас 12 тонн нь нэг тонн шингэрүүлсэн хий гаргаж авах ийм хүчин чадалтай станцын урьдчилсан жишиг тарифаар тооцох юм бол бид 350 сая долларын хувийн хөрөнгө оруулалтаар шингэрүүлсэн хийг ашиглана гэсэн ийм тооцоотой байгаа.

Гуравт нь, бид 2 үндсэн хогийн цэг дээр хий гаргаж авах хог шатаах үйлдвэр байгуулна.

Үүнээс бид 10 мянган тонн метаны хий гаргаж авна гэсэн үндсэн тооцоо байгаа.

Ингээд үндсэн 3 эх үүсвэрээс бид дотоодоосоо өөрсдийгөө бүрэн хангах бололцоотой гэсэн тооцоотой. Үндсэн ТЭЗҮ бол байгаа. ТЭЗҮ дээр үндэслээд бид төр, хувийн хэвшлийн түншлэлийн журам Засгийн газраас батлагдахыг хүлээж байна.

Үүний дараа бид хувийн хэвшилтэй хамтарч энэ ажлыг хийхээр төлөвлөж байгаа юм.

Дээр нь нэмээд хэлэхэд тэр орон сууцтай холбоотой 16 мянга 700 өрхөөс санал асуулга авсан. НҮБ-ын судалгаагаар. Нийтдээ 7 мянган өрх ямар нэгэн байдлаар орон сууцад амьдрахгүй, хашаандаа амьдаръя гэсэн ийм санал өгсөн байдаг.

Тэгэхээр бид цаашдаа дулааны эх үүсвэрийг нэгдсэн байдлаас хийхээс илүү хэсэгчилсэн байдлаар хангахаар төлөвлөгөөнд ТЭЗҮ-д тусгасан юм.

Б.Бейсен: Ж.Золжаргал гишүүн тодруулъя.

Ж.Золжаргал: Нөгөө 55 хувийн гэр хорооллоос гэдэг тоог нэг лавлачихмаар байна.

Тэгээд одоо ингээд бид утааны асуудал ярина. Дараа нь нөгөө сонгогч болно. Бөөн л маргаан болох байх. Тэгээд их айхтар маргаад байхаас илүүтэйгээр шийдлийг гоё зурмаар байгаа юм.

Одоо зүгээр тайлбар яриануудаас сонсохоор хамгийн их асууж байгаа болоод хамгийн их манайхны хийж чаддаг юм нь хяналт шалгалт юм байна.

Тэгээд хяналт шалгалт хийсээр байгаад би бол энэ ажил хариуцаж байгаа хүмүүс бүр залхаж байгаа гэж бодож байна. Бүр ядарчихсан. Байн байн очоод л хянаад л байдаг. Одоо нийслэл дээрээс бас бага гараад л хянаана л гэж байна лээ.

Шийдлүүдийг их тодорхой яриад тэгээд ямар нэгэн тийм ардаа төлөвлөгөө байхгүй худлаа тоогүй үнэн тоон дээр яримаар байна гэж хүсмээр байна.

Б.Бейсен: О.Номинчимэг гишүүн байхгүй. Б.Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Б.Мөнхсоёл: Оройн мэнд.

Энэ агаарын бохирдлын асуудал яалт ч үгүй чухал учраас би хэдийгээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүн биш ч гэсэн ороод сууж байгаа юм.

Үүнийг гишүүний хувьд иргэд ч асууж байна, хэвлэл мэдээллийнхэн ч гэсэн юу болж байна гээд асууж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр одоо ийм байгаад байна. Манай гишүүдийн асууж байгаа, хариулж байгаа байдал, манай харьяалагдах яамдын хүмүүсийн хариулж байгаа байдлыг харахаар цогц мэдээллийг нийгэм маань авч чадахгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ олон жил агаарын бохирдлыг ярьчихсан. Шинэ тутам биш асуудал. Яагаад бид ярьсаар ярьсаар ярьсаар байгаа хэрнээ үр дүн гарахгүй ухарсаар ухарсаар байгаад байна гэдэг том асуудал гарч ирж байгаа юм.

Тэгээд яагаад энэ тулгамдсан байнга анхааралд өртдөг вэ. Мэдээж амь насны асуудал яригдаж байна. Энд эрүүл мэндийн асуудал яригдаж байна. Амьдрах орчин, аюулгүй хотын асуудал яригдаж байна.

Тэгээд мэдээж цаанаа нөгөө талдаа санхүүжилт аваад байгаа янз бүрийн шахмал түлш ч бай, үүнийг хийгээд байгаа газрууд чинь ажлын байр болгоод байна. Тийм цогц асуудал байна.

Тэгэхээр үүнийг иргэдэд ойлгомжтой байлгахын тулд, ажлаа үр дүнтэй болгохын тулд үр ашгийн тооцоолол дутагдаад байгаа юм шиг.

Тэгээд нөгөө англиар хэлдэг шүү дээ. “Monitoring and Evaluation” гэж хэлдэг. Хяналт, дүн шинжилгээ дутаад байгаа юм шиг харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр аливаа ажилдаа шалгуур үзүүлэлт тавиач ээ. Цаг хугацааны хувьд, эрэмбэ дараалал, ач холбогдлын хувьд, хурдын хувьд гээд. Гэх мэтчилэн ийм үр ашгийн нарийн тооцоолол дутагдаад байгаа юм шиг ийм сэтгэгдэл төрөөд байна.

Ингээд өмнөх гишүүд маань ноцтой ноцтой мэдээлэл хэлж байна шүү дээ.

Тухайлбал, манай ХҮН намын Улсын Их Хурлын гишүүн манай Ж.Золжаргал инженер хүн өөрөө хэлээд байна. Тоо худал учраас шийдэл худал гараад байна.

Өөрөөр хэлэх юм бол худал дээр нэмэх худал тэнцүү худал. Худал дээр нэмэх үнэн ч бай тэнцүү худал гэдэг шиг. Шийдэл нь буруу гараад байна гэдэг энэ утгатай юм яриад байна шүү дээ.

Үүнийг нотлох нэг баримт байна. Тухайлбал, “Өнөөдөр” сонин дээр юу гарсан байна шүү? Нийтлэл. Та бүхэн маань харсан байх. Энэ та нартай шууд холбоотой ийм тоо баримт явж байна шүү дээ.

Энэ дээр юу гэж хэлээд байна гэхээр нийслэл дэх суурин харуулууд агаарын чанарын үзүүлэлтийг ташаа мэдээлээд байна гээд хэлж байна шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол манай Монгол тавьсан энэ суурин харуулуудын индекс, агаарын чанарын индекс нь 100 айлд 226-г заагаад байхад энэ Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамнаас 100 айлд тавьсан энэ агаарын чанарын индексийг үзүүлж байгаа энэ төхөөрөмж нь 667-г заасан юм байна.

Тэгэхээр энэ хоёрын индексийн хоорондын зөрүү чинь л гэхэд л 441 нэгжээр зөрөөд байна гээд энэ бүхэл бүтэн нийтлэл энэ төхөөрөмжийн зааж байгаа индексийн тооны зурагтай явж байна шүү. Хүмүүс ээ.

Тэгэхээр энэ чинь аягүй чухал байна шүү. Яагаад хүмүүс итгэхгүй байна вэ гэхээр нэгдүгээрт өвөл болгон утаатай байна. Хүний эрүүл мэнд, хүүхдийн амь нас одоо зөндөө асуудал.../минут дуусав/

Б.Бейсен: Хариулт. 8 номер.

Л.Оюунжаргал: Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Л.Оюунжаргал.

Б.Мөнхсоёл гишүүний хариу асуултад хариулъя.

Ер нь сүүлийн үед байнга наад асуудал чинь гараад байгаа. Энэ яагаад ийм асуудал гараад байна вэ гэхээр тэр хувь хүний өөрийн багаж гар төхөөрөмжөөр хэмжсэн дүн нь болохоор яг тухайн агшны мэдээ байгаад байгаа юм.

Бидний юугаар олон нийтэд хүргэж байгаа “agaar.mn” хүргэж байгаа мэдээлэл болохоор өнгөрсөн 3 цагийн дундаж мэдээлэл байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хоёр зөрнө.

Бид яагаад 3 цагийн дундаж мэдээлэл гаргадаг юм бэ гэхээр стандартууд нь тийм байдаг байхгүй юу. Стандарттай харьцуулахын тулд бид тийм дундаж мэдээллийг авдаг.

Дээр нь бас үүнийг тэгж дунджаар гаргадгийн бас нэг үндэслэл нь юу вэ гэхээр агаар мандалд маань хөдөлгөөнтэй динамик хий учраас тухайн агшиндаа хамгийн их байж болно. Хэдхэн минутын дараа дахиад багасаж болно. Ийм байдаг учраас тухайн агшны утгатай стандартуудыг бол гаргадаггүй.

Тийм учраас стандарт бол одоо цагийн ч юм уу, 8 цагийн, 24 цагийн, хоногийн, сарын, жилийн дунджууд дээр гардаг байхгүй юу.

Тэгэхээр бид тэр утгаа барьж авах нь илүү бодитой тогтвортой мэдээлэл гарна гэсэн үг.

Таны наад сонин дээр гарсан юу чинь бол би яг тэгж ойлгож байна. Тухайн агшинд агаарын чанарын индекс ийм байна гээд тэр дэлгэц дээр гарчихсан мэдээллийг манай агаарын чанарын “агаар.mn” дээр байгаа мэдээлэлтэй харьцуулчихсан дүн байна гэж харж.

Тэгэхээр манайхан бас зөв ойлгоорой. Манайх Цаг уур, орчны шинжилгээний газар яг энэ агаарын чанарын чиглэлээр яг одоо төрөөс гаргаж байгаа хамгийн үнэн бодитой мэдээлэл гаргагдаад тавьж байгаа тэр мэдээ.

Гэхдээ хүмүүсийн тэр зөрүүтэй мэдээлэл гараад байгаа гэдэг нь тэр стандарттайгаа холбоотой байгаа юм. Стандартыг 2016 онд гаргасан стандарт байгаа. Энэ стандартыг гаргахдаа бид Хятадын стандартыг харсан, Америкийн стандартыг харсан. Энэ утгуудыг харж байгаад одоо тэр агаарын чанарын индексийг тооцоолдог аргачлалаа боловсруулаад энэ дүн дээр үндэслээд гаргасан.

Энэ дээр асуудал байна гээд манай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас шийдээд энэ өөрчлөх асуудлыг эхлүүлчихсэн явж байгаа.

Тэгэхээр энэ асуудал удахгүй Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн тэр хүлцэх түвшинтэй нь дүйцүүлэх хэмжээнд хүргэсэн ийм стандарт гаргана гэж бодож байгаа юм.

Б.Бейсен: Б.Мөнхсоёл гишүүн тодруулъя.

Б.Мөнхсоёл: Яасан их агаар бохирдчихсон хүмүүс ууртай уцаартай, амь нас, эрүүл мэндийн асуудал яригдаж байхад ямар аймаар хамгаалж яриад байна.

Энэ бол яагаад ийм нийтлэлийг сэтгүүлчид эрэн сурвалжлах маягтай бичээд байна вэ гэхээр ер нь индексийг хэмжсэн хэмжээгүй агаар бохирдоод байна гэдгийг л хөндсөн гэсэн үг шүү. Түүнээс тэр стандарт уу, хэн үнэн худал нь бас нөгөө талдаа чухал биш.

Би тэгээд Ж.Золжаргал инженертэй бас санал нэг байгаа.

Нөгөө талдаа саяын танилцуулгад чинь байгаад байна шүү дээ. Тавантолгойн асуудал. Түлшний асуудал. Энэ дээр ингэчихсэн байна шүү дээ. 8 нэр төрлийн химийн бодисыг тусгай зөвшөөрөлгүй ашиглаж байсан зөрчил илрүүлсэн ба химийн бодисуудыг Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийг агуулж байх тул гэгчихсэн ийм юм Та нарт танилцууллаа шүү дээ. Өөрсдөө. Би дандаа факт тоо баримт нотолгоон дээр тулгуурлаж иргэдийг төлөөлж яриад байна.

Тэгэхээр яагаад ийм хариуцлагагүй байна вэ? Энд хариулт хэн өгөх вэ? Энэ дээр ерөөсөө.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер хариулъя.

Д.Өлзийбат: Б.Мөнхсоёл гишүүний асуултад “Тавантолгой түлш” компанийн ерөнхий технологич Д.Өлзийбат хариулъя.

“Тавантолгой түлш” компани 2023 онд өөрийнхөө компанийн дэргэд химийн шинжилгээ туршилтын лабораторийг нээсэн.

Ер нь тухайн лаборатори итгэмжлэл авах итгэмжлэлийн хүрээний хувьд эхлээд заавал тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулж шинжилгээ хийж, аргын баталгаажуулалтаа баталгаажуулах, тухайн итгэмжлэлийн хүрээнд орж байгаа аргууд, стандартуудыг нутагшуулах, шинжээчдийг сайжруулах, чадавхжуулах заавал тийм заалттай байдаг.

Энэ хүрээнд бид итгэмжлэлийн хүрээндээ барьцалдуулагчдынхаа орц найрлагыг тодорхойлох зорилгоор бид химийн бодисыг ашигласан.

Яг энэ зөвшөөрөлгүй дээр холбогдох юм бол манай лаборатори баруун үйлдвэр дээр байдаг. Баруун үйлдвэр дээр байгаа байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гараагүй учраас бидний химийн бодисын зөвшөөрөл хараахан гараагүй байсан.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя.

Д.Өлзийбат: Тэгээд энэ химийн бодисыг бид бүтээгдэхүүндээ огт ашиглаагүй гэдгийг энэ дээр дурдах нь зөв байх. Энэ зөвхөн химийн шинжилгээ туршилтын лаборатори дотроо бид барьцалдуулагчдынхаа цардуулыг тодорхойлоход л ашиглачихсан.

Үүнийг хүмүүс иргэд ташаа ойлгоод байх шиг байна. Бүтээгдэхүүндээ ашигласан мэтээр ойлгож байх шиг байна. Энэ зөвхөн туршилтын лаборатори, манай өөрийн лабораторид ашиглагдсан байгаа. Тийм. Тийм тийм. Би яг тэр дээр нь тайлбар хэлж байна л даа, харин.

Бүтээгдэхүүнд огт химийн бодис ашиглаагүй гэдэг дээр.

Б.Бейсен: Гишүүд мэдээлэлтэй холбоотой асуулт асуулаа.

Ер нь энэ холбогдох яамд, байгууллагын улсууд тодорхой хариулах хэрэгтэй. Яах аргагүй энэ ийм байдалтай байх дээр тэрийг хамгаалаад байж болохгүй.

Сая Ж.Золжаргал гишүүний ярьдгаар 10 сарын сүүлээс эхлээд утаатай болж байгаа юм. Зун утаа байхгүй шүү дээ. Машин руугаа ч чихэж болохгүй байх. Цэвэр галлагаатай холбоотой асуудал байна. Тэр түлшний асуудал дээр чанаргүй тийм түлш яаж байна уу, аль эсвэл С.Ганбаатар гишүүний ярьдгаар өөр түлш хэрэглээд ийм үүсэж байна уу, хяналт сул байна уу. Ийм асуудлууд дээр ингээд ард иргэд маань эрүүл мэндээр хохирч байхад та бүгд ингэж зүгээр сууж болохгүй байх гэж бодож байна.

Дараа нь бид энэ асуудал дээр Шадар сайд, Хотын дарга ирэхээр ирэх долоо хоногт бид дахиж хуралдана. Тодорхой мэдээллээ яагаарай.

Тойруулаад тойрсон маягтай хариулт өгч болохгүй. Яг тодорхой. Утааны үед яах вэ гэдэг асуудал дээр тодорхой хариулт өгөхгүй бол болохгүй. Нөгөө талаар хяналтын асуудал.

Агаарын асуудлаар өнөөдөр Их Хурлын дарга бас ярьж байна лээ. Ер нь гаднын байгууллагаар шинжлүүл. Үүнийг. Хоруу чанарыг гээд тэгж байна.

Тэгэхээр ч үүнийг бас хийх байх бид. Энэ талаар бас анхаарч ажиллаарай гэж хэлье.

Гишүүд энэ нэгдүгээр асуудлаар асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хоёр дахь асуудал байгаа. Үг хэлэх гишүүд байна уу? С.Ганбаатар гишүүнээр тасаллаа. С.Замира гишүүнээр гишүүнээр тасаллаа. Б.Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Яах вэ, ер нь жилийн жилд л яригддаг асуудлууд л даа.

Гол нь цаашдын дунд хугацааны хөтөлбөрөө яаралтай ормоор байгаа. Үүнийгээ хэдүүлээ их сайн бодмоор байна.

Хоёрдугаарт, би түрүүн хэлсэн. Одоо энэ утааны асуудал үргэлжилнэ. Өвөл яг ид ес бол эхлээгүй байгаа шүү дээ. С.Одонтуяа сайдыг хамгаалаад байгаа юм биш.

Өнөөдөр байгаа нөхцөл байдал нь ийм байхгүй юу. Би бүр албаар зориуд хэлж байгаа юм. Яагаад гэхээр миний өмнөх сайд яг утаанаас болж огцорч байсан юм.

Одоо эрчим хүчтэй холбоотой асуудал энэ утаатай холбоотой дулаан үйлдвэрлэлтэй холбоотой асуудал бол Эрчим хүчний яамны асуудал шүү. Эрчим хүчний яамны асуудал. Үүнийгээ бид их сайн бодмоор байна.

Хоёрдугаарт, ер нь зүгээр ингээд баалуулж сууж байхаар та хэд маань. Дээр үед л бид бас яриад л явж байсан. Өдөөгчөө хийчихгүй дээ. Хаашдаа л мөнгө гарч байгаа. Наадах чинь асалт удаашралтай холбогдолтой гарч байгаа чийгшлийн хэмжээнээс шалтгаалалттай утаа чинь асахаасаа, бүрэн шаталт явагдахаасаа өмнө л их хэмжээний утаа гаргаад байгаа шүү дээ.

Тэгээд үүнийгээ зөв тайлбарлаад шаардлагатай тохиолдолд тэр өдөөгчийг нь хийгээд. Солонгосууд утаагүй байна л гээд л шахмал түлш ингэж байна гээд л. Гол нь л нэгдүгээрт тэр тухайн шахмал түлш чинь өөрөө хүчилтөрөгч нэвтрүүлэх чадвар өндөртэй.

Хоёрдугаарт, өдөөгчтэй л байхгүй юу.

Тэгээд тэр өдөөгчийнхөө асуудлуудыг ер нь нийслэл хаашдаа орж ирж байгаа бол хийгээд л явах нь зөв л. Бараг ийм асуудал үүсэхгүй түвшинд л очих болов уу л гэж харж байгаа юм.

Орон нутагтай холбоотой асуудлууд байгаа. Бид өнөөдөр Улаанбаатар хотын сайжруулсан шахмал түлшийн тэдэн хувь, эдэн хувь гээд орилоод байдаг. Орон нутаг бол бүр аймаар байгаа шүү дээ. Түүхий нүүрс түлдгээрээ л түлж байгаа. Нөгөө дэгдэмхий чинь 50 хэдэн хувьтайгаа байгаа. Хувцсанд үнэр шингэхээс авхуулаад энэ чинь яг Улаанбаатарын дээр үеийн процесс чинь тэр чигээрээ орон нутагт байгаа байхгүй юу.

Тэгээд энэ дээр бид бас тодорхой хэмжээнд асуудал авч үзэх нь зөв болов уу гэж бодож байгаа.

Яах вэ зүгээр бид шинжлэх ухааны үндэслэлтэй л хандмаар байна. Яг ний нуугүй хэлэхэд. Одоо сая Ж.Золжаргал гишүүн энд байсан гараад явчих шиг боллоо. Тэгвэл зун яагаад машинаас үүдэлтэй утаа байхгүй байгаа юм гээд л. Үгүй ээ, зун өвөл хоёр чинь өөр шүү дээ. Зун өвөл хоёр өөр.

Би бүр уншаад өгье. Зуны улиралд агаар илүү дулаан байдаг тул агаар мандлын босоо урсгал илүү идэвхтэй болдог. Энэ нь бохирдуулагч бодисыг доод агаарын давхаргаас дээш тараан хуваарилах боломжийг олгодог. Зуны улиралд салхи илүү тогтмол бөгөөд хүчтэй байдаг тул бохирдол хуримтлагдах боломж багасдаг. Мөн бороо хур ихтэй байснаар агаар дахь тоосонцрыг цэвэрлэдэг гээд ингээд шинжлэх ухааны дүгнэлтүүд нь байгаа байхгүй юу.

Бид өвөл зун хоёрыг харьцуулаад утаа ихтэй, багатай гээд яриад байж болохгүй шүү дээ. Тоосонцрын хувьд магадгүй зун илүү ч их байхыг үгүйсгэхгүй. Салхи ихтэй. Салхи ихтэй учраас тэр сул шороонууд чинь бүгдээрээ тоосонцор үүсгэж байгаа шүү дээ. Яг утаа тоосонцор хоёрыг харьцуулах юм бол аль нь илүү аюултай вэ гэвэл бүр тоосонцор чинь нарийн ширхэгцэртэй учраас тэр чинь илүү аюултай.

Тэгэхээр бид одоо жишээлбэл энэ Байнгын хорооны хурал гээд ингээд ажиллаад байдаг. Баахан шүүмжлэл хэлээд байдаг. Яг өнөөдөр өөрсдөө эхлээд нөхцөл байдлынхаа холбоотой асуудлуудаа судалдаг мэддэг байж байгаад тодорхой хэмжээнд бас энэ мэргэжлийн хүмүүстэй харьцмаар байна л даа. Миний санаа бол.

Дээрээс нь та нар маань миний өгөх зөвлөмж бол юу вэ гэхээр ерөөсөө л саяын хэлсэн асуудал шүү дээ. Болохгүй бол тэгээд л өдөөгчөө л хийчих. Жил болгон л бид энэ асуудал руу орж байна. Тэгвэл өдөөгчөө хийгээд тэр хурдан шаталт явуулах процессоо хийгээд, түүн дээрээ тодорхой тэр илүү баахан гарч байгаа эрүүл мэндтэй холбоотойгоос авхуулаад өчнөөн олон хохирлуудаа тооцож гаргаж ирж байгаад л хийчих ёстой.

Энэ бол тэгэхдээ богино хугацааны шийдэл. Нөгөө талдаа ёстой нөгөө хагас кокс руугаа л ор. Наад хийн түлш чинь амжилттай болох эсэхийг сайн мэдэхгүй байна. Болоосой гэхдээ хагас кокс.../минут дуусав/

Б.Бейсен: М.Ганхүлэг гишүүн үг хэлье.

М.Ганхүлэг: Ямар ч байсан энэ асуудлыг өнөөдөр Байнгын хороогоор хойшлуулан барина долоо хоногийн дараа хэлэлцэж байгаа нь зөв өө.

Асуудлыг ер нь яах вэ хэлж ярилж явсны буруу гэж байхгүй байх гэж бодож байна. Энэ дээр сүүлийн 20, 30 жилийн хугацаанд төр ер нь хийх гээд бас хийж чадахгүй байгаа гэдгээ хүлээн зөвшөөрөх ёстой.

Бүх асуудлыг нийслэл байдаг юм уу, бүх асуудлыг яг төр өөрөө шийдэх юм шиг ийм хувилбарууд гаргаад байгаа учраас л алдаа байгаад байна гэдэг ийм саналыг би хэлмээр байгаа юм.

Яг өнөөдрийн бидний танилцуулж байгаа энэ концепц маань өөрөө урт хугацааных юм уу, богино хугацааных юм уу, дунд хугацааных юм уу гэдгээрээ ялгасан ийм ойлголт байхгүйгээр нэгдсэн ийм. Ер нь л одоо ингээд бодсон бүх ажлуудаа ерөнхийд нь жагсаагаад л, тэр дотроо метрогоор ч оруулчихсан, тэр дотроо орон сууцынхаа хөтөлбөрийг ч оруулчихсан, ингээд бүх ажлуудаа ер нь бөөгнүүлээд ингээд л үндсэндээ маш системгүй. Хэн хэн нь юугаа хийх, хаанаа яаж хариуцах гэдэг юм нь тодорхойгүй ийм байдалтай л орж ирээд байгаа нөхцөл байдал бол бидний энэ нөхцөл байдлыг харуулж байна.

Тийм учраас яг энэ бидний зориод байгаа энэ үр дүнд хүрэхийн тулд энгийн иргэд нь юугаа хийх юм, төр нь өөрөө яг ямар зохицуулалт юмнуудаа хийх юм, хувийн хэвшлээ бид яг яаж дэмжих юм гэдэг энэ асуудлыг хамтдаа шийдэх энэ шийдэл рүүгээ бид бүхэн яг ингэж нээлттэйгээр сууж байгаад болно, болохгүй гэдгээ ярьж байгаад ингээд орохгүй бол ер нь болохгүй байна гэдгийг өнгөрсөн жилүүдэд харуулчихсан.

Үүнийг нь залуучууд, нийгмийн төлөөллүүд гарч ирж илэрхийлээд асуудлыг энэ түвшинд гаргаж ирсэн.

Тэгэхээр үүнийг янз бүрийн улс төр гэдэг талаас нь харахгүйгээр их тийм асуудлыг нээлттэй болгох тал руу нь явах энэ уулзалтуудыг цаашдаа хийх ёстой гэж бодож байна.

Ажлын хэсгийн энэ ажлууд бас цаашдаа үргэлжлээд явах ёстой. Хувьдаа ч гэсэндээ ажлын хэсэгт орж ажиллах хүсэл сонирхолтой байгаа гэдгээ илэрхийлье.

Миний түрүүчийн асуусан асуултуудад ерөнхийдөө хариулт бүрэн дүүрэн авч чадсангүй. Сая яриад байгаа энэ чинь байгалийн шинжлэх ухаантай холбогдолтой асуудлыг нийгмийн шинжлэх ухаан, улс төрч нар шийдээд байгаа болохоор тодорхой үр дүн нь сайн гарч ирж чадахгүй байна.

Тийм учраас яг ямар эрдэмтэд энэ зуух тараа гэдгийг зөвлөөд байгаа юм бэ? Яг ямар эрдэмтэд явж байгаа энэ төслүүдийг үндсэндээ санал болгоод байгаа юм бэ? Аль улсын туршлагаар бид бүхэн яваад байгаа юм бэ?

Тэгэхээр энэ мэргэжлийнхэн, олон улсын байгууллага, хувийн хэвшлийнхнийхээ дуу хоолойг сонсдог систем нийслэл дээр, Засгийн газар дээр яг аль түвшиндээ байгаа юм бэ гэдгийг би тодруулсан. Энэ дээрээ би хариулт авч чадаагүй.

Тэгээд цаашдаа энэ төрлийн оролцоогоо нэмэгдүүлэх тал дээрээ бид бүхэн анхаарах нь зүйтэй байна гэдгийг би цохож хэлмээр байна.

Ер нь хандлагын хувьд, өөрчлөлтийн хувьд бид бүхэн зуухаа нэмэгдүүлэх, нэмж олгох гэдэг энэ агуулгаасаа яндангаа бууруулж байгаа, багасгаж байгаа энэ иргэдээ, энэ хувийн хэвшлийн санаачилгуудаа дэмжих тал руу нь маш тодорхой саналуудыг цааш цаашдаа гаргаж ирээсэй гэж бодож байна.

Дээр хэлсэн би 10 янданг 1 яндан болгох хувийн хэвшлийн маш сайн төслүүд бол байна. Олон жил яриад үндсэндээ дэмжлэг авч чадахгүй байгаа асуудлууд байна.

Энэ төслүүдийг дэмжих хөшүүргийг нь л төр хийгээд өгчхөөч ээ. Иргэдийн хувьд өөрсдөө асуудлаа шийдээд явж байгаа ийм сайн туршлагууд байна. Эдгээр

иргэдээ үргэлжлүүлээд дэмжих энэ бодлогоо л илүү сайжруулаад өгчхөөч ээ. Ингэвэл бас урт хугацаандаа бодитой үр дүнгүүд гарна гэсэн энэ хандлагын өөрчлөлт рүүгээ ороосой гэдэг ийм бодол санаатай байна.

Б.Бейсен: Л.Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Бид шуудайны стандарт хүртэл баталсан шүү дээ. Утааг бууруулах гээд. Айлуудын янданг хөөсөн. Айлуудаар явж яаж зуухаа галлах вэ, зуухыг нь сольсон. Тийм ээ. Бид бүгдээрээ мэднэ.

Тэгээд одоо мидлингээр сайхан түлш хийсэн. Үнэхээр ямар ч хоргүй гэсэн. Утаагүй болно гэсэн. Утаа буураад байна. Бүх юм сайхан байна гээд энд байгаа мэдээлэл дээр байна. Утаа нь ихсээд байгааг бид бүгдээрээ хараад байгаа. Та бүхэн ч гэсэн адилхан хордож байгаа.

Та бүхэн зүгээр суугаагүй. Ажиллаад л байгаа. Түрүүн тэр нийслэлийн орлогч хэлж байна. 75 мянган айлаар явлаа гэж. Энэ ажил мөн үү. Мөн. Мөн байхгүй юу даа.

Гэхдээ ингээд бид утаанаас салахгүй. Яагаад гэвэл бидний энэ стандарт худлаа. Бидний энэ технологи худлаа байхгүй юу.

Сая Б.Мөнхсоёл гишүүний асуултад ямар их амбицалдаг юм. Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамнаас авчраад суурилуулсан тэр утаа хэмждэг багаж манай тэр Ус, цаг уур, орчны газраас тавиулсан багаж хоёрын хоорондын зөрүү 400 гаруйгаар их зөрүүтэй байгаа байхгүй юу. Хувь иргэн биш. Алдаа болгоноо иргэн рүүгээ чихдэг.

Иргэд угаартаад байна. Утаагаа хэмжиж чадахгүй байна. Сая тэгж ярилаа шүү дээ.

Та болохоор юу гэж ярив, сая. Иргэд буруу мэдээлэлтэй. Гар утсан дээрээсээ хэмжээд байна. Технологи нь зөв мөртөө иргэд мэдэхгүй байна гээд.

Одоо үүнийгээ болиод бүгдээрээ адилхан угаартаж үхэж байгаа байж энэ асуудлаа нэг тийш нь цэгцлэхийн тулд бид наад худлаа байгаа технологио, наад зөвшөөрөлгүй оруулж ирээд хэрэглэж байгаа химийн бодисуудаа, барьцалдуулагч дээр зарладаг тендерт өгдөг хахуулиа орхиж байж өнөөдөр бид энэ утаанаас сална.

Үүнээс салахын тулд энд байна шүү дээ. Сонирхлын зөрчилгүй, хэн нэгэн даргаас шууд захиргаа, захиргаадалт авдаггүй, үгээр нь явдаггүй өөрийнхөөрөө байдаг хүмүүс л үүнийг салгадаг байхгүй юу даа.

Ерөнхийлөгчийн хэлдэг үнэн шүү дээ. Энэ авлигалын утаа чинь энэ угаарын утаатайгаа нийлээд бүгдээрээ үхэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээ нэг санал нийлээд хэдүүлээ нэг зүтгээд амьд гаръя л даа ядаж. Тэгж болдоггүй юм уу. Нэг дарга тэгж хэлэхээр л гүйж ирээд тэгэх юм. Нэг дарга ингэхээр л ингэх юм. Тэгээд л айсан хүмүүс явах юм.

Албан тушаал, амь нас хоёр чинь өнөөдөр яг альныг нь вэ гэдэг дээр ирчихсэн. Үр хүүхдүүд чинь ч тийм байгаа шүү дээ.

Энэ цаана нь мөнгө өгөөд байгаа, сонирхлын зөрчилтэй, энэ юмаа шахаад байгаа хүмүүс чинь өвөл нь дулаан оронд очдог. Хүүхэд нь бид нартай энд амьдрахгүй. Хүүхэд нь гадаадад сурдаг тийм хүмүүс байдаг байхгүй юу.

Монголд тэд нарын хувьд бэлэн мөнгөний машин байхгүй юу. АТМ нь байхгүй юу даа. Тэгээд бид тэрний үгээр ингээд яваад байж болохгүй ээ.

Нэг удаа бие биедээ хайртай байгаад, нэг удаа ирээдүйгээ бодоод бид энд шийдэл гаргах ёстой. Саяын үүнийг бүр ингэж сонсох гэж та бүхнийг ямар хандлагатай байгааг, асуудалд юу байгааг харах гэж энд бид өчнөөн цаг барлаа. Харамсалтай байна. Нэг удаа хэдүүлээ хамтраад ухаалаг шийдэлд хүрэх хэрэгтэй шүү. Бодох хэрэгтэй. Тэгээд зоримог байх хэрэгтэй.

Б.Бейсен: С.Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Оройн мэнд хүргэе.

Хамгийн эхний асуудал бол энэ стандарт бус түлш гаргасан эзнээ л олгох хэрэгтэй. Тэр хүмүүст хариуцлага тооцох хэрэгтэй.

Тэгээд тэр нийслэлийн бүх хүн амыг хордуулж байгаа тэр түлшийг нь акт тогтоох хэрэгтэй. Дээр үед тийм байсан шүү дээ. Болохгүй. Хүмүүсийн хэрэгцээнд таарахгүй юм дээр акт тогтоодог байсан. Одоо яагаад тэгж болохгүй гэж.

Тэгээд алдагдлын хэн нэг нь хүлээнэ биз. Тэгж байж хариуцлага тооцож байж энэ юм чинь тэгээд дараа дараачийн хариуцлага өндөр болж таарна шүү дээ.

Одоо чи ч сайн, би ч сайн гээд яваад байх юм бол ингээд яваад байх нь байна шүү дээ.

Тэгээд та бүхэн хэдхэн хүн ажиллаж байгаа юм шиг нэг сэтгэгдэл төрүүлээд байна л даа. Уг нь баг, хороо гээд бүхэл бүтэн аппарат байгаа шүү дээ. Өрх бүрдээ тулж ажиллалдаа. Болохгүй бүтэхгүй байгаа, үнэхээр амьдрах чадвараа алдсан ажилгүй хүмүүс зөндөө байна. Яаж өвлөөс амьд гарах вэ гээд. Тэр хүмүүст тусалъя л даа.

Одоо ил гаргаад ир л дээ. Ийм айл байна. Ийм пийшэн байхгүй байна, түлшийг нь тавьж өгье гэсэн. Тийм одоо яг тулж ажиллаад тэр айлуудыг өвлөөс аль болох амьд мэнд гаргахыг бүгдээрээ хамтран ажиллая л даа.

Хэрэгтэй бол Их Хурлын 126 гишүүн ч яваг л даа. Бүгдээрээ хамтарч байгаад би өвлөөс юу ч гэсэн хүмүүсийг алдахгүйгээр, амь насыг нь алдуулахгүйгээр гарахыг бодъё.

Тэгээд одоо хамгийн гол асуудал бол эхний ээлжид түлж байгаа юм нь юу байна вэ. Үнэхээр машины дугуй түлж байна уу, түүхий нүүрс түлээд байна уу, юу түлээд байна? Эсвэл арьс шир борлогдохоо байсан тэрнийг түлээд байна уу. Тэр бүгдийг нь тогтоох хэрэгтэй шүү дээ. Энэ бүгдийг нь зогсоох хэрэгтэй. Одоо дуртай хүн болгон нь. Нийтийн эрх ашиг гэж бас баймаар юм.

Тийм учраас ингээд айл өрх болгонтой тулж ажиллаад энэ юмны учрыг нь яаралтай олохгүй бол. Тэгээд хамгийн гол нь одоо тэр утаа гаргаж байгаа гол эх үүсвэрийг нь зогсоож байж агаарын юу явах байх.

Хэдүүлээ ер нь хамтдаа ажиллая. Чадахгүй бол бид бүгд нэгдье. Харж суугаад бөөгнөрч хүрч ирээд хэдэн цаг хурал цуглаан хийгээд, нэг нь сонсгол тавьсан болоод, хэдүүлээ нэг сонссон болоод, саналаа яриад ямар ч үр дүн байхгүй л байна. Үр дүн гарахгүй л байна.

Тийм учраас та хэд дараачийн юун дээр одоо яах ёстой. Яг энэ өвөл утааг яаж гаргах ёстой гэдэг гол юугаа л нэг гаргаад ирээч л хүсэх байна.

Тэгээд тэр Тавантолгойн нүүрс шаардлага хангахгүй стандарт бус бол тэрийг таслан зогсоох хэрэгтэй. Хэн нэгэнд хариуцлага тооцох хэрэгтэй. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Хоёр. “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонсох

Хоёр дахь асуудал “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хувьцаат компанийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа, сайжруулсан түлшний нөөц, чанарын талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар захирагч мэдээлэл хийх ёстой.

Мэдээллийг сонсьё. Түрүүн бас давхар яригдлаа. Ажлын хэсэг нэг ижилхэн байгаа учраас дахиж танилцуулах шаардлагагүй байх гэж бодож байна.

Нийслэлийн Засаг даргын ямар ч байсан мэдээллийг нь сонсчихъё. Тийм ээ. Асуудлыг нь түрүүн асуусан юм чинь.

Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдол хариуцсан орлогч дарга А.Амартүвшин мэдээлэл хийе. Товчхон мэдээлэл хийчих.

А.Амартүвшин: “Тавантолгой түлш” ХХК-ийн хийж хэрэгжүүлж байгаа ажлуудын талаар товчхон танилцуулъя.

Нийслэлийн агаарын чанарын сайжруулах бохирдлыг бууруулж, гэр хорооллын 200 мянга гаруй айл өрх, аж ахуйн нэгжүүдийн стандартыг MNS56/79/2022 шаардлага...

Б.Бейсен: Ажлын хэсгийнхэн байж байгаарай. Асуух асуулт гарч магадгүй. 6 номер.

А.Амартүвшин: ...стандартын шаардлага хангасан шахмал түлшээ тасралтгүй найдвартай хангах зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Засгийн газрын 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 248 дугаар тогтоолоор компанийн удирдлагын түвшинд нийслэлийн оролцоог хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 27 дугаар тогтоолоор тус компанийн төрийн эзэмшлийн хувийг нийслэлийн өмчид шилжүүлэх тогтоол гарч, холбогдох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Цаг уур, орчин шинжилгээний газрын Орчин шинжилгээний хэлтсийн Агаарын чанарын хэлтсээс дүгнэхэд 2019 оны түвшнээс PM2.5 тоосонцрын үзүүлэлтийг 56 хувиар, PM10 тоосонцрын үзүүлэлтийг 43 хувиар тус тус бууруулсан гэсэн үзүүлэлт гарч байгаа.

Хүхэрлэг хийн агууламжийг бууруулах зорилгоор долобитийн барьцалдуулагчийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, шаталтаас ялгарах хүхэрлэг хийг 20 хувиар бууруулсан байна.

2023 онд лабораторийн туршилтын шугамын ашиглалтад оруулснаар түүхий эд, шахмал түлшний чанарыг хяналт болон бүтээгдэхүүнийг сайжруулалтын туршилтыг, мөн түүний судалгааг эрдэмтэн, судлаачтай хамтран тогтмол явуулж байгаа.

Үйл ажиллагаа явуулж эхэлснээс буюу 6 жилийн хугацаанд 2.7 сая тонн шахмал түлшийг 600 орчим борлуулалтын цэгээр, нэг шуудай түлшийг 950 төгрөгөөс 375 төгрөгөөр хэрэглэгчид нийлүүлж ажилласан.

Алдагдлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

-Үндсэн түүхий эд болох мидлингийг “Энержи Ресурс” ХХК Өмнөговь аймагт орших Ухаахудгийн үйлдвэрээс авто тээврээр тээвэрлэдэг байсныг 100 хувь төмөр замаар тээвэрлэлтэд шилжүүлэв.

-Үйлдвэрийн хүчин чадлыг 2.5 дахин, зүүн үйлдвэрийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, 20 шугамаар үйлдвэрлэл явуулж байсан бүтээмжийг нэмэгдүүлж 6 шугамаар ажилладаг болсон.

Бүтэц орон тоог оргил ачааллын үед 3800 хүнээс 1850 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар төлөвлөж, 1950 хүнээр бууруулан ажиллаж байна.

Тус компани нь 2024 оны 3 дугаар улиралд санхүүгийн байдлын тайлангаар нийт урт хугацаанд өр төлбөр буюу Эрдэнэс Тавантолгой ХХК-аас авсан санхүүжилт нь 1.3 тэрбум төгрөг, нийт хөрөнгө нь 521.0 тэрбум байгаагаас эрэлтийн хөрөнгө нь 223.5 тэрбум, эргэлтийн бус хөрөнгө нь 297.5 тэрбум төгрөгтэй 816.7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтайгаар тайлагнасан байна.

2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл үйлдвэрлэлийн өртөг нь 485.6 мянган төгрөгөөр тонн тутамд, бүрэн өртөг нь 598.8 мянган төгрөгөөр тонн тутамд буюу нэг шуудай шахмал түлшний өртөг нь 15 мянган төгрөг байна.

Нийслэлээс жилд тээвэрлэлт, агуулах, борлуулалтын урамшууллын зардалд 56 тэрбум төгрөгийг зарцуулж байгаа.

6 жилийн хугацаанд зарцуулсан томоохон зардлуудаас дурдахад 3 мянгаас 3500 хүнийг тогтмол ажлын байранд хангаж, цалин, урамшуулалд 354.5 тэрбум төгрөгийг зарцуулсан.

Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь “Энержи Ресурс” ХХК-ийн талбайгаас үйлдвэр хүртэл авто зам болон төмөр замаар мянган километр буюу 3.1 сая тонн мидлинг буюу түүхий эдийг татан авахад 250 тэрбум төгрөг, технологийн материал болон бусад зардалд 169.8 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ.

Өнөөгийн байдлаар тус компани нь 2024-2025 оны өвлийн бэлтгэл ажлын хүрээнд 93 мянган тонн шахмал түлшний нөөцийг бүрдүүлж, хоногт 2000-аас 2500 тонн шахмал түлш үйлдвэрлэсэн нь 12 сарын 15-ны байдлаар 472.6 мянган тонн, 92 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Нийслэлийн 7 дүүргийн 37 агуулахад болон үйлдвэрийн нөөцийн талбайд 71 мянга 487.3 тонн шахмал түлшний нөөцтэй. Үндсэн түүхий эд болох мидлинг нь 166.6 мянган тонн, барьцалдуулагч нь 7.2 тонн, шуудай 17.9 сая ширхэг нөөцтэй үйлдвэрийн хэвийн ажиллаж, ажиллагааг хангаж ажиллаж байна.

Мидлинг буюу угаасан эрчим хүчний нүүрс тээвэрлэлтийг 215 вагоноор сард 50 мянган тонноор тээвэрлэж байгаа.

2025 оны халаалтын улиралд 582 цэгээр хэрэглэгчдэд 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 477.3 мянган тонн шахмал түлшийг борлуулсан нь 99 хувийн гүйцэтгэлтэй байна.

Цаашид хэрэгжүүлэх ажлаас дурдвал компани нь технологийн сайжруулалт, өртөг, зардал бууруулах дараах ажлуудыг төлөвлөж байна.

Нэгд, технологийг сайжруулах судалгаа.

Тус компанийн шахмал түлшний технологи, бүтээгдэхүүн сайжруулах туршилт, судалгааны ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэх. Үүнд:

-шахмал түлшний үндсэн түүхий эдийн судалгаа, хагас коксжих баяжуулсан нүүрсний шахмал түлшний судалгааг хийх.

Хоёрт, шаталтыг дэмжих нэмэлт бодисын судалгааг хийж байгаа.

Өртөг зардал бууруулах тал дээр боловсруулж ангилсан нүүрсний түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх судалгааг мөн хийж байгаа.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлд сайжруулсан хатуу түлш техникийн шаардлага хангах MNS56/79/2019 стандартыг шинэчлэн боловсруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг даалгасан.

Тус ажлын хүрээнд Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022 оны 2 дугаар сарын 16-ны А/54 дүгээр дугаартай MNS56/79/2019 стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсэг нь 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын С/45 дугаарын тушаалаар сайжруулсан хатуу түлш, техникийн шаардлага MNS56/79/2022-ыг шинэчлэн баталсан.

Тус стандартад боловсруулж ангилсан нүүрс, нүүрсэн түлш гэсэн ангилалыг нэмж оруулсан байдаг.

Мидлингийг овоолгоос дээж авч 20 миллиметрийн шүүлтүүрээр гаргах 20-оос 50 миллиметрийн хэсэгчлэн бүхлийн гарцыг 40 хувь байдаг. Уг гарцын хуваарь эдийн засгийн тооцоолол хийхэд шахмал түлшний тонн тутамд 249.2 тонн төгрөгөөр бага тусгагдаж байгаа.

Компанийн засаглалыг сайжруулалтад компанийн зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгох, орон тооны зохистой харилцааг тодорхойлох зорилгоор төвийн үйлдвэрийг үе шаттайгаар зогсоох, зүүн үйлдвэрийн шугамын бүтээмжийг нэмэгдүүлэх замаар 2025 онд бүтэц, орон тоог 1099 болон 47.7 хувиар бууруулахаар ажлыг төлөвлөж ажиллаж байна.

Сайжруулсан хатуу түлш техник, шаардлага, MNS56/79/2022-ын талаарх мэдээллийг товч хүргэе.

Монголын Засгийн газраас 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоол гарч түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон тухай агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан Улаанбаатар хотын зарим дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэр гарсан байдаг.

Дээрх асуудлын хүрээнд Эрчим хүчний сайдын 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 112 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, 2014 онд шинэчлэн баталснаас хойш 5 жилийн хугацаа өнгөрсөн.

MNS56/79 сайжруулсан хатуу түлш техникийн шаардлага, стандартад үзлэг хийн зохих стандартчиллын ажлыг явуулж, шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн. Гэвч Засгийн газрын 2022 оны нэгдүгээр сарын 19-ний өдрийн 5 дугаар хуралдаанаар сайжруулсан хатуу түлшний техникийн шаардлага, MNS56/79/2019 стандартыг шинэчлэн боловсруулах даалгаврыг өгсөн.

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн В/146 дугаар стандартыг дахин шинэчлэх ажлын хэсэг байгуулах тухай алба албан бичиг ирсэн. Үүний дагуу Стандартчилал, хэмжил зүйн газраас Уулын уурхай, ашигт малтмалын стандартчилал технологийн хорооны нарийн бичгийн дарга н.Эрдэнэбилиг тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

2022 оны 8 дугаар сард холбогдох дүрэм, журмын дагуу стандартыг шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 8 байгууллагаас санал ирж, уул уурхайн ашигт малтмалын стандартчиллын техникийн хорооны хуралдаанаар 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн С/45 дугаар тушаалаар сайжруулсан хатуу түлшний техникийн шаардлага MNS56/79/2022 стандартыг баталсан байдаг.

Шинэчлэн баталсан стандартын дагуу 13-аас 50 миллиметрийн шигшилттэй түлшийг сайжруулсан шахмал түлшинд тооцож байна.

Харин 13 миллиметрээс бага хэмжээтэй байвал ширмийн завсраар унаж дутуу шаталт явах талтай тул түлшний үйрмэг гэж үздэг болсон.

Өөрөөр хэлбэл бүтээгдэхүүний анхны хэлбэр алдагдаж, бутарч 13 миллиметрээс бага хэмжээтэй болсон жижиг хэсгүүдийг түлшний үйрмэг гэж үзэх болсон.

Шахмал түлшний чийгшлийн хэмжээг 10 хувь байсныг шинэчилсэн стандартаар 6 хувь болгосон. Энэ нь түлшний шаталтаас ялгарах нүүрстөрөгчийн дутуу исэл буюу угаарын хийг бууруулахад ач холбогдолтой гэж үзсэн байдаг.

Өмнөх стандартаар үнслэгийн хувь нь 29 байсан бол шинэчилсэн стандартаа 27 хувь болгож бууруулсан.

Ингэснээр түлшний шаталтаас хаягдах үнсний хэмжээ 10 орчим хувиар буусан гэж тооцоололд орсон. Танилцуулж дууслаа.

Б.Бейсен: Мэдээлэл танилцуулсан А.Амартүвшин даргадаа баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрс өгнө үү. Байхгүй байна. М.Ганхүлэг гишүүн байгаа юм байна. Б.Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа.

М.Ганхүлэг: Жоохон дэлгэрүүлээд. Яах вэ, ерөнхий мэдээллийг нь харахаар их сайн л ажиллаж байгаа. Тодорхой хувиудаар бууруулаад ингээд яваад байгаа байдал танилцуулаад байна л даа. Тийм.

Тэгэхдээ яг ингээд харахаар яалт ч үгүй л 2, 3 жилийн өмнөх нөхцөл байдлаас өнөөдөр үнэхээр хүнд нөхцөл байдал үүсчээд байна л даа.

Тэгээд хаана алдаа гарчихсан юм? Яг үндсэн өмнө нь бэлдэж байсан түлш одоогийн түлш хоёрын хооронд ямар ялгаа гараад. Жоохон ойлгомжтойгоор, тэгээд өөрсдийнхөө ажлыг хамгаалах, энэ асуудлаас зугтах гэхээсээ илүүтэй яг тодорхой ийм ийм шийдлүүд тулгарлаа. Тодорхой алдаа юмнууд байгаа учраас л ийм нөхцөл байдал үүсчээд байна шүү дээ.

Тэгэхээр үүнтэй холбогдолтой яг тодорхой саналуудаа их тийм ойлгомжтойгоор ер нь зүгээр хэзээ, хаана бид ярих юм бэ. Энэ тухай бас нэг ийм. Зөвхөн болж байгаа талаасаа биш яг болохгүй байгаа асуудлууддаа яривал яасан юм бэ.

Миний өмнө харсан мэргэжлийн эрдэмтэд, энэ тодорхой найрлага юмнуудыг нь хийж байгаа химичид, тэнд ажиллаж байгаа хүмүүсийн боловсрол туршлагын хувьд дутагдалтай байгаа мэдээллийг би бас авч байсан.

Тэгэхээр яг ямар бүрэлдэхүүнтэй хүмүүс яг энэ найрлага, орц энэ зүйлүүдийг нь хийдэг юм бэ? Боловсролын хувьд ч тэр, нарийн деталь яривал зөндөө олон асуудлууд бас байна.

Тэгэхээр ерөнхийдөө “Тавантолгой түлш” компани нийслэл рүү очлоо. Өр авлагын асуудлаас авхуулаад зөндөө олон проблемтой асуудлууд зөндөө зүйлүүд байгаа.

Тэгэхээр та бол танилцуулга юмнууд дээрээ болж байгаа зүйлийн тухай ярилаа. Асуудлууд тэгэхдээ яг тэгвэл яг хаана байна вэ? Өнөөдрийн яг энэ үүсээд байгаа нөхцөл байдлын хувьд энэ түлш ямар ч асуудалгүй гэж Та бүхэн үзээд байгаа юм уу гэдэг энэ ерөнхий асуултад маш тодорхой хариулт өгөөч ээ.

Тэгээд дараагийн үе шат руугаа шилжих тухай өмнөх сайд нарын мэдээллийг авлаа.

Тэгэхээр энэ гурав, дөрвөн жилийн зорилт байгаад 2025 оны эхний нэгдүгээр улирлаас хагас коксжсон үйлдвэрээ бариад явах энэ асуудлууд яригдаж байсан байна. Үүнтэй холбогдолтой асуудлууд Нийслэл дээр болон бусад түвшинд яригдаж байна уу? Одоо бид дараагийн шатны энэ алхмууд нь яг юу юм бэ?

Одоо энэ сайжруулсан түлштэйгээ бид хэдэн жил явах юм бэ? Дараагийн алхмууд, зорилтууд яг юу гэж харж байгаа вэ гэдэг ийм асуултуудыг асууя.

Б.Бейсен: Өдрийн юутай мэдээлэлтэй холбоотой бид “Тавантолгой түлш” компанийн захирал Ц.Эрдэнэбаярыг урьсан. Ирээгүй.

Одоо энэ “Тавантолгой түлш” компанийн ерөнхий технологич Д.Өлзийбат энэ асуудалд хариул. Д.Өлзийбат байна уу? 4 номер.

Д.Өлзийбат: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

“Тавантолгой түлш” компани 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл үйлдвэрлэлийнхээ технологид ямар ч өөрчлөлт хийгээгүй байгаа. Түүхий эдээ солиогүй явж байгаа. Бидний мидлинг бол бид богино хугацааны зорилт байсан.

Ер нь мидлинг үүргээ гүйцэтгэсэн гэж хэлж болно. Одоо бид дараагийн шат руу орох зайлшгүй шаардлага үүссэн. Юу вэ гэхээр зэрэг түрүүний Б.Бат-Эрдэнэ гишүүний хэлдгээр тэр асалт дэмжигч нэмэлт бүтээгдэхүүнүүдийг бид шат шатандаа үйлдвэрийнхээ лабораторийн туршилтад туршчихсан байж байгаа. Маш сайн үр дүн гарсан. Тухайлбал, Солонгос Улсын “Грийн колл” технологи,

Тайванийн асралт дэмжигч катализатор гээд олон улсын сайн туршлагауудыг лабораторийнхоо түвшинд бид судалчихсан.

Үүнийгээ цааш нь мэргэжлийн байгууллагуудаар дахиж судлуулах тийм ажил хийгдэж байгаа.

Мөн шинжлэх ухааны байгууллагуудтай бид ажиллаж байгаа. Тухайлбал, Шинжлэх ухааны академийн Хими, хими технологийн хүрээлэн, МУИС, ШУТИС, Химийн нийгэмлэг гээд яг энэ нүүрс дээр мэргэшсэн мэргэжлийн байгууллагуудын эрдэмтэн, докторуудыг бүгдийг нь урьж оролцуулсан ажлын хэсэг бас манай дээр ажлын хэсэг гараад өөр өөрсдийнхөө хувьд туршилтуудыг хийгээд, туршилтын ажлын тайлангаа яг энэ 12 сард тайлагнахаар бэлэн болчихоод байж байгаа.

Дараагийн үе шат руу бид шилжих зайлшгүй шаардлага үүссэн гэж байгаа юм. Энэ дээр бид юу байх вэ гэхээр хамгийн түрүүн. Одоо ер нь энэ дээр шийдвэр шийдвэр гаргах түвшний улсууд юу байх вэ гэхээр зэрэг түрүүн Ж.Золжаргал гишүүн бас мэргэжлийн хүний хувьд бас их зөв хэлж байгаа. Бид ч бас яг энэ туршилтыг хийсэн.

Юу гэхээр зэрэг эрчим хүчний нүүрсийг өөрийг нь баяжуулаад баяжуулсан баяжмалаар нь шахмал түлш хийе гэж байгаа юм. Тэгэх юм бол үнслэг бага болно, дэгдэмхий бодисын гарц багасна, хүхэр багасна. Нийт хүхэр багасаж байгаа учраас хүхэрлэг хий дагаад багасах ийм сайн үзүүлэлтүүд гарч байгаа учраас одоо бидний мидлингийн дараагийн үе шат бол хагас кокс байхгүй учраас, хагас боловсруулах үйлдвэр одоохондоо байхгүй учраас эхний арга хэмжээ бол баяжуулсан баяжмалаараа шахмал түлш хийх. Нэг бол нэмэлт бодис ашиглаж шаталтыг дэмжиж бүтээгдэхүүнийг нь сайжруулах, дэгдэмхий бодисын гарцыг бууруулах, угаарын хийн эрсдэлээс сэргийлэх боломжтой гэж харж байгаа.

Энэ дээр маш хурдан шийдэл гаргавал манай үйлдвэрийн технологийг солихгүйгээр шууд үйлдвэрт нэвтрүүлээд явах боломжтой.

Б.Бейсен: 6 номер нэмж хариулъя.

А.Амартүвшин: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

“Тавантолгой түлш” компанийн асуудал хоёр долоо хоногийн өмнөөс манай манай нийслэл дээр орж ирж байгаа. Долоо хоногийн өмнө бид гүйцэтгэх захирлыг нь томилоод, одоо бүтцийн асуудлуудыг нь шийдвэрлээд явж байгаа.

Мөн манай Нийслэлийн иргэдийн хурлаас ажлын хэсэг гараад үйлдвэрийн үйл ажиллагаа, түүний менежмент болон үйлдвэрийнх нь гарч байгаа бүтээгдэхүүнүүд дээр нь мөн Их Хурлаас гарсан ажлын хэсэгтэй адилхан хамт гараад ажиллаж байгаа.

Нийслэлээс тухайн гарч байгаа бүтээгдэхүүнийг гадаадын лаборатори дээр шалгуулах, гадаадын лабораториуд дээр цагдаа болон тагнуулын албан байгууллагуудтай хамтраад дээжийг явуулах ажлыг ажил хэрэг болгоод явж байгаа.

Өмнөх жилүүдтэй, ялангуяа 2019-2020 онд шилжсэн жилүүдтэй агаарын бохирдол их байна гэдэг нь бид гол зүйлийг нь харж байгаа нь нэгд сайжруулсан түлшийг түлж байгаа. Зуухын элэгдэл, чанар муудсан байгаа.

Одоо жишээлбэл зуухны ширмэн тогоо нь 2-оос 3 жилийн хугацаанд ийм өндөр килокалори гаргах чадвартай, 3 мянгаас килокалориос дээш гаргах чадвартай энэхүү сайжруулсан түлшийг 3-аас 4 жил ачааллыг нь даах чадвартай байдаг. Түүнээс дээш болохоор цуурах, хэт халах хайлах энэ асуудлууд гарч ирдэг.

Тийм болохоор манай нийт нүүрс түлж байгаа өрхүүдийн зуухны асуудал асуудалд ороод явж байгаа.

Дээрээс нь мөн нүүрс түлж байгаа өрхийн тоо 2019 онд 380 мянган тонныг түлдэг байсан бол одоо ингээд 520 мянган тонныг түлэхээр төлөгдөөд нийлүүлэлт хийгдээд явж байгаа.

Мөн түлж байгаа нүүрснийх нь тоо нь нэмэгдсэнтэй холбогдуулаад агаарын бохирдол нэмэгдэж байгаа гэж үзэж байгаа. Ямар ч байсан нийслэлд менежментийн удирдлага нь ирснээр бүх асуудлыг шат шатан дээр нь шалгая. Шат шатан дээр нь гадаад дотоодын лаборатори, экспертүүдийг мөн оролцуулж энэхүү дүгнэлтүүдийг гаргуулахаар ажиллаж байгаа.

Б.Бейсен: М.Ганхүлэг гишүүн тодруулъя гэж байна.

М.Ганхүлэг: Тэгээд асуудлын яг шалтгаанаа бас хэдүүлээ аль нэг л бүрэн дүүрэн тодорхойлж чадахгүй байгаа л ийм л дүр зураг санагдаад байна л даа.

Тэгээд явж явж нөгөө зуухны маань л буруу болж хувирч байх шиг байна. Одоо тэгээд шинээр олгох гээд байгаа зуух маань хэдэн төгрөгийн үнэтэй, ямар газраас нэг доор тийм олон хэмжээгээр яаж оруулж ирэх гээд байгаа. Тэрийгээ нэгмөсөн дэлгэрүүлээд хэдүүлээ яримаар юм уу. Уг нь асуудлаа нэлээн тал талаас нь шинжлэх ухаанчаар хараад явмаар байна.

Тэгээд яах вэ шинэ зуух олгох юм байна.

Тэгэхээр шинэ зуух нь ямар үнэтэй байх юм? Ямар газраас яаж олгохоор Та бүхэн тооцож байгаа юм. Үүнийгээ дэлгэрүүлээд мэдээлэл өгөөч.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

А.Амартүвшин: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Зуухны техникийн тодорхойлолтыг нь манай нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газраас боловсруулж өгсөн байгаа. Энэ дээр давхар шаталттай. Давхар шаталттай гэхээр нүүрстөрөгчийн дутуу давхар ислийг давхар шаталттай зуухаар түлж, дээрээс нь “угартын хий” гэж ярьдаг юм шүү дээ. Угаартын хийг давхар шаталтаараа түлж багасгах, байхгүй болгох ийм техникийн үзүүлэлттэй зуухыг тендер зарлаад явж байгаа. Нийтдээ 32 мянган зуухыг авна гэж тендер зарласан байгаа.

Үүний зарласан тендер дээр нь аж ахуйн нэгжүүд өөрсдийнхөө тендерийн тухай хуулийнхаа дагуу орж ирээд оролцоод явж байгаа.

Намайг ажлаа авснаас хойш 3-аас 4 компани зуухны асуудлаар ирж уулзаж байсан.

Б.Бейсен: Гүйцээж хариулъя. Үнийг нь асууж байна.

А.Амартүвшин: Тухайн тэр компаниуд орж уулзаж байсан. Тухайн уулзаж байсан компаниудын гаргаж байгаа санал, санаачилга. Мэдээж манай дотоодын үйлдвэрүүдээс, дотоодын үйлдвэрлэгчүүдээс гаргаж байсан санал, санаачилгыг нь холбогдох хариуцах байгууллага буюу агаарын бохирдолтой тэмцэх газартай нь шилжүүлээд, энэ дээр нь агаарын бохирдолтой тэмцэх газар нь судалгаа, тооцоогоо дүүргүүдтэйгээ, хороодтойгоо хамтарч хийгээд тоогоо гаргаад эхний ээлжид зайлшгүй 32 мянган айл дээр олгоё шийдвэрийг гаргасан байгаа.

Үүнийхээ хүрээнд тухайн газар нь техникийн тодорхойлолтыг хийгээд тендерийг зарлаад явж байгаа.

Б.Бейсен: Б.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Нэг бүрийн үнийг асуусан. Хариулт өгөөгүй. Тийм ээ.

Б.Бат-Эрдэнэ: Одоо тэр хариултыг л авмаар байна. Нэг ширхэг зуухыг ямар үнэтэй худалдаж авах гээд байгаа юм? Тендер зарлагдсан бол үнэлгээ багцаа юм гарахад гарч байгаа байлгүй дээ. Тийм ээ.

Ер нь яах вэ, ийм шүү дээ. А.Ундраа гишүүн бас хэлчихсэн байна лээ. Тэрийг та хэд сайн аваасай гэж хүсээд байгаа юм.

Энэ дотор дулаалгаа сайн хийж байгаа айлууд гэж байгаа. Одоо манай “Пассив хаус” гээд л Бат-Эрдэнэ, нөгөө Түмэнбаяр гээд л баахан залуучууд дулаалга хийгээд л яваад байгаа. “Хашаандаа сайхан амьдрах нь”. Тийм ээ.

Уг нь наад нэг бүрийг чинь зуухны үнийг мэдчихвэл хэдэн төгрөгөөр зуух худалдан авалт хийгээд, хэдэн айлд өгөх гээд, тэр нь хэдэн төгрөг болоод байгаа юм. Нөгөө талдаа дотор дулаалгаа үнэхээр сайн хийж байгаа айл, өрхүүдийг. Тэр

чинь гал түлэлт нь хүртэл багасчхаж байгаа шүү дээ. Нөгөө талдаа. Тэр нэг тооцоо харьцуулсан судалгааны юмнууд байна уу, үгүй юу?

Хоёрдугаарт, хэвлэл мэдээллийн зардал гэж нэг зардлууд яваад байна. Одоо “Тавантолгой түлш” дээр хүн байхгүй л юм шиг байна. Одоо ямар инженерээс асуулттай биш.

Нийслэл дээр хэдэн төгрөг яг энэ хэвлэл мэдээлэл дээр төсөвлөгддөг юм. “Тавантолгой түлш” дээр хэдэн төгрөг төсөвлөгдөж байгаа юм. Энэ мөнгөнүүд чинь жишээлбэл та хэд хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр явуулж байхаас илүүтэй давхар тэр гэр дотор дулаалга сайн хийгээд байгаа айл, өрхүүдийг дэмжих хэлбэр дээрээ явуулбал хэдэн айсыг хамруулах боломж байна гэдгийг бас хармаар байгаа байхгүй юу.

Хий дэмий л баахан мөнгө үрэгдээд л байдаг, үрэгдээд л байдаг хэлбэр дээр яваад байгаа юм биш биз дээ.

Тэгэхээр нэг бүрийнх нь үнэлгээг л сонсчихмоор байна. Зуухны. Тэгээд зуух шийдлээ гээд нөгөө талдаа бас шийдэгдэх үү, үгүй юу? Түлш чинь солигдоогүй. Илчлэг нь яг хэвээрээ байгаа. Тэгж байснаас та нар бараг нөгөө талдаа саяын яриад байгаа тэр өдөөгчөө бараг технологийнх нь хэмжээгээр оруулж ирээд хийчихвэл бараг нөгөө талдаа томоохон хэмжээний асуудлуудыг бараг шийдвэрлэх юм шүү гэдгийг асуух гэж байгаа юм.

Б.Бейсен: 6 номер хариулья.

А.Амартүвшин: М.Ганхүлэг гишүүн болон Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Сая үнийн дүнг хэлээгүйд уучлаарай. Тулгамдаад асуултад хариулахаа мартсан байна.

Зуухны нэгжийн үнэ 870 мянган төгрөгөөр зарлагдаж байгаа. Тэгээд тендерээрээ тодорхой үнэ нь буураад орж ирэх байх. Техник үзүүлэлтээрээ 870 мянгаар тооцсон байгаа. 32 мянган зуух 870 мянган төгрөгөөр явж байгаа.

Дулаалгын асуудал гэх юм бол нийтдээ зуухны стандартын шаардлага хангахгүй, гар хийцийн, уламжлалт зуухтай айлууд нийтдээ 84 мянган тийм айлууд байна.

Эдгээр айлуудын зуухныг зайлшгүй солих, зуухыг нь сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байгаа. Юун дээрээ гэх юм бол нөгөө айл, өрхүүдийн хүүхдүүдийн нөгөө угаарталтаас хамгаалах, угаарталтаас урьдчилан сэргийлэх гол ажил нь энэ явж байгаа юм.

Б.Бейсен: Дутуу хариулсан байна. Хэн гүйцээж хариулах вэ? 5 номер хариулах юм байна.

А.Батзориг: Сайн байцгаана уу?

“Тавантолгой түлш” компанийн Санхүү эдийн Засгийн газрын дарга А.Батзориг. Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья.

Манайх угаарын хийн эрсдэл болон бусад үйл ажиллагаанд хэвлэл болон цаасан материал, дээрээс нь бичиг хэрэг төлж явдаг. Энэ дээр тодорхой хэмжээний мөнгө байдаг. Удирдлагын үйл ажиллагааны 3.5 хувиар төлөгдөөд явж байна.

Яг одоо бүрэн тоог нь юмнаас харж байж хариулья.

Б.Бейсен: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулья.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм.

Тэгэхээр 870 мянган төгрөгийг 32 мянган зуухаар үржүүлэхээр 27 тэрбум 840 сая төгрөг гарч байна л.

Уг нь үлдэцтэйгээ бодоод айл өрхийг өөрийг нь энэ утаатай холбоотой асуудал дээр эрдэмтэн, судлаач тодорхой хэмжээний юм хийгээд явж байгаа залуучуудаа дэмжээд гаргачихвал болохгүй юм уу?

27.8 тэрбум төгрөг гэдэг бол бас л их хэмжээний мөнгө. Нэг талдаа.

Тэгээд бид яах вэ, Зуух тараана гэдгийг ойлгож байна. Одоо үнэхээр муудчихсан байдаг байх, зарим нь. Гэхдээ хэдүүлээ дунд хугацааны, урт хугацааныхаа шийдэл рүү орохгүйгээр ийм их хэмжээний мөнгийг зүгээр нэг удаа, хоёр удаагийн хэрэглээнд гаргаад байхаар хэзээ ч бид энэ утаанаас салахгүй шүү дээ.

Түрүүн би буруу сонсоогүй бол.../минут дуусав/

Б.Бейсен: Харилт. 6 номер. 7 номер.

Ч.Батзориг: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад тодруулья.

Өнөөдөр Монгол Улс нийтдээ 60 мянган тонн хийн түлш оруулж ирж импортолж байгаа. Зуны улиралдаа нэг тонныг нь 420 ам.доллараар, өвлийн улиралдаа болохоор 650 ам.доллараар худалдаж авч байгаа.

Тэгээд манай улсын жилийн хийн түлшний борлуулалт ойролцоогоор 35 сая ам.доллар байдаг.

Хэрэв бид 100 мянган өрх рүүгээ шилжүүлэх юм бол 200 сая ам.доллар болж эдийн засгийн тоо нь ингэж нэмэгдэх юм. Хийн түлшний хэрэглээ нь.

Б.Бейсен: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: 200 сая ам.доллар. Та хэд тэр Эрдэнэс Тавантолгой компанийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам руу хүргүүлсэн хагас коксын үйлдвэрийн ТЭЗҮ-ийн дүнг мэдэж байна уу? 200 сая ам.доллар байдаг санагдаад байх юм. Надад.

Тэр бол 1.7-гоос 1.8 сая тонн хагас кокс үйлдвэрлэнэ. Нафта гарна. Би андуураагүй бол 20 мегаваттын эрчим хүч үйлдвэрлэнэ. Цаашдаа өнөөдрийн явж байгаа алдагдлууд “Тавантолгой түлш” компани дээр явж байгаа бүх алдагдлууд зогсоод ашигтай ажиллаж эхлэх ийм боломж байсан шүү дээ

1.7-гоос 1.8 сая тонн хагас кокс гэдэг бол өнөөдөр Улаанбаатар хотын хэмжээг та хэд түрүүн 520 мянган тонн гэж хэллээ шүү дээ. Тэгвэл 520 мянган тонноор Улаанбаатар хотоо хангаад 1.7 саяас үлдэж байгааг нь тэр Эрдэнэт, Дархан хотуудаа хангах.

Жишээлбэл, Солонгос, Япон улсууд чинь бүгд Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас хагас коксоо импортолж авч байгаа шүү дээ. Өнөөдөр ч Солонгос Улс эрчим хүч.../минут дуусав/

Б.Бейсен: 7 номер хариулъя.

Ч.Батзориг: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Ер нь бол ТЭЗҮ 380 сая ам.доллар. Тийм. Үнэн. 68 мянган тонн нафта гарахаар байгаа. Энэ бол одоо манай өнөөдрийн Монгол Улсын хэрэгцээ.

Хагас коксжсон үйлдвэр барих тал дээр Улаанбаатар хот Эрчим хүчний яаман дээр хийгдсэн энэ ТЭЗҮ-г дэмжиж байгаа. Ер нь ирээдүйд бид хагас коксжсон үйлдвэрийг барих тал дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэх энэ ажлыг бид 100 хувь дэмжиж ажиллана.

Өөрөөр хэлбэл энэ саяын хагас коксжсон үйлдвэрийг дагаад дайвар бүтээгдэхүүн хийн түлш гарна. Нафта. С5 буюу Н12. Энэ дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэх саяын энэ ажил дээр хотын зүгээс ТЭЗҮ-г үндэслэж ажил зохион байгуулахаар ер нь төлөвлөсөн байгаа.

Хотын даргын өчигдрийн ярилцлага дээр ч бас энэ тухай бас дурдсан байна лээ.

Б.Бейсен: Гишүүд мэдээлэлтэй холбоотой асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалд оръё.

Гурав.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх

Энэ ажлын хэсэг гарч байж болно. Тийм ээ.

Дараагийн асуудал Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцээд Байнгын хорооны хүрээнд ажлын хэсэг томилох ёстой.

Утааны асуудлаар хяналтын сонгол явуулах талаар цахим системд байршуулсан нийтийн өргөдөл.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д заасан тоонд хүрсэн тул Улсын Их Хурал авч хэлэлцэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд 70 мянган хүнээс дээш ирснийг дэмжсэн бол гээд юутай, хүрмэгц Улсын Их Хурлын даргын саналыг хэлэлцүүлж шийдвэрлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасны дагуу Улсын Их Хурлын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж, асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Мөн хуулийн 95.4-д холбогдох Байнгын хорооны саналыг чуулганы үеэр хүлээн авсан бол долоо хоногийн дотор хэлэлцэж эхэлнэ гэж заасны дагуу өнөөдөр хуралдаан авч хэлэлцэж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.4-д иргэдийн гаргасан хүсэлтийг холбогдох Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хяналтын сонгол явуулна гэж заасны дагуу Утааны асуудлаар ерөнхий хяналтын сонгол явуулахыг дэмжье гэдэг санал хураалт явуулна.

Санал хураалт явуулахын өмнө санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулахыг дэмжье гэдгээр санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

С.Ганбаатар гишүүн, М.Ганхүлэг гишүүн хоёрыг санал өгснөөр тооцож протоколд тусгая.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 76.8 хувиар дэмжсэн тул энэ санал хураалт дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3-д Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж болно гэж, 122 дугаар зүйлийн 122.1-д холбогдох Байнгын хорооны хуралдаанаар сонсгол даргалагчийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно гэж тус тус заасны дагуу сонсгол даргалагч бөгөөд ажлын хэсгийн ахлагчийг сонгоно.

Эхлээд хуралдаанд орсон ажлын хэсгийн өгсөн нэрээр нь танилцуулъя. Яагаад гэвэл Хууль зүйн байнгын хороотой хамтарч явуулна гэсэн учраас гишүүдийн эрхэнд алдахгүйгээр гишүүдийн тоог нэмж оруулсан байгаа.

Б.Бат-Эрдэнэ гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Х.Баасанжаргал гишүүн, Ц.Баатархүү гишүүн, П.Батчимэг гишүүн, Б.Баярбаатар гишүүн, Г.Ганбаатар гишүүн, Л.Мөнхбаясгалан гишүүн, М.Мандхай гишүүн, З.Мэндсайхан гишүүн, Б.Найдалаа гишүүн, Ж.Чинбүрэн гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, С.Лүндэг гишүүн, А.Ундраа гишүүн, Б.Уянга гишүүн, С.Эрдэнэболд гишүүн.

Ийм гишүүд нэрс өгсөн байна. М.Ганхүлэг гишүүн орьё гэж байна уу? Тийм ээ. М.Ганхүлэг гишүүн орьё гэж байна.

Уг нь байна шүү дээ энэ ажлын хэсэг дээр чинь бас заримдаа хэт олон болчихоор гишүүд цуглаж өгөхгүй, ирц бүрдэхгүй, хуралдаж чадахгүй тийм асуудал гардаг.

Тэгээд уг нь Их Хурлын даргын саналаар 9 юм уу, 11, 13 гэсэн. Одоо энэ бидний юугаар чинь 17 болчихоод байна.

Тэгэхээр энэ дээр чинь энэ ажлын хэсэгт орж байгаа гишүүд заавал энэ хуралдаан таслахгүй ирж байхгүй бол яг цаг үе тулгамдсан энэ утааны асуудалтай холбоотой учраас заавал хуралдах цагт нь ирж байх хэрэгтэй байна.

Тэгвэл 17 болсон уу? Тэгвэл 2 гишүүн орвол 19 болох юм байна шүү дээ, энэ чинь. 2 гишүүн нэмж орвол нийтдээ 19 гишүүн болгоё. С.Замира гишүүн, М.Ганхүлэг гишүүн хоёрыг.

19-ийн гишүүнээр батлах уу? Тэгээд. Тийм ээ.

Л.Мөнхбаясгалан санал хэл.

Л.Мөнхбаясгалан: Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр Д.Энхтуяа гишүүнээр ахлуулсан “Тавантолгой түлш” компанийг хянан шалгах ажлын хэсэг байгаа байхгүй юу.

Тэгэхээр Д.Энхтуяа гишүүнийг энэ ажлын хэсэгт оруулж болохгүй юу? Өөрөө орох сонирхолтой л байсан. Тийм ээ. Байсан.

Б.Бейсен: Тэр ажлын хэсэг дээрээ тэр тийм мэдээлэл солилцож мэдээлэл өгч болно шүү дээ. Тийм.

Энэ сонсголыг энэ Байнгын хороо зохион байгуулах юм чинь тэр дээр бас мэдээлэл хийж болно.

Сонсгол даргалагч бөгөөд ажлын хэсгийн ахлагчид нэр дэвшүүлэх гишүүд нэрсээ өгнө үү? 3 гишүүн нэр өгсөн байна. С.Эрдэнэболд гишүүнээр тасалъя.

Ж.Чинбүрэн гишүүн, Л.Мөнхбаясгалан гишүүн, С.Эрдэнэболд гишүүн гурав.

Тэгээд нэр өгсөн дарааллаар нь Ж.Чинбүрэн гишүүнд санал хураалгая. Дараа нь товоо зарлаад шинжээчээ бас томилно шүү дээ. Ажлын хэсэг дотроо даргаа томилсоны дараа.

Тийм. Ерөнхий хяналтын сонсгол. Тэгэхдээ Их Хурлын даргын ярьж байгаагаар шинжээч томилж болно гэсэн. Тийм.

Нэрс өгсөн дарааллаар Ж.Чинбүрэн гишүүнд санал хураалт явуулъя. /алх цохив/

64.7 хувийн саналаар Ж.Чинбүрэн гишүүн ажлын хэсгийн ахлагчаар томилогдлоо.

Тэгэхдээ нэг хэлэх асуудал байна. Одоо тогтоолоо батална.

Байнгын хорооны тогтоол. “Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар: Ж.Чинбүрэн гишүүн,

Гишүүдэд: Б.Бат-Эрдэнэ гишүүн
Ж.Бат-Эрдэнэ гишүүн,
Х.Баасанжаргал гишүүн,
Ц.Баатархүү гишүүн,
П.Батчимэг гишүүн,
Б.Баярбаатар гишүүн,
Г.Ганбаатар гишүүн,
Л.Мөнхбаясгалан гишүүн,
М.Мандхай гишүүн,
З.Мэндсайхан гишүүн,
Б.Найдалаа гишүүн,
Д.Цогтбаатар,
С.Лүндэг гишүүн,
А.Ундраа гишүүн,
Б.Уянгаа гишүүн,
С.Эрдэнэболд гишүүн

2. Ажлын хэсэг мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсенд даалгасугай.

Тогтоолын төслөө батлах уу?

Нэмээд С.Замираа гишүүн, М.Ганхүлэг гишүүн хоёрыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулж нэмсэн байгаа шүү.

Тогтоолын төслөө батлах уу? /алх цохив/

Ж.Батжаргал гишүүн, Б.Найдалаа гишүүн хоёрыг санал өгснөөр, С.Ганбаатар гишүүн гурвыг, Р.Сэддорж гишүүн дөрвийг нэмээд.

70.6 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Одоо нэг тогтоол байгаа. “Ерөнхий хяналтын сонголын даргалагчийг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13, 37 дугаар зүйлийн 37.1.6, 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5.5, 120 дугаар зүйлийн 120.1.1, 120.2, 121.1 дэх заалт, 121.13 дахь заалт дахь хэсэг, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 29.2.4 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Ерөнхий хяналтын сонсголын даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнг сонгосугай.

Тогтоолын төслөө батлах уу? Баталъя. /алх цохив/

15 гишүүн дэмжиж, тогтоолын төсөл 88.2 хувиар батлагдлаа.

Гишүүддээ баярлалаа. Хуралдааны ажил дууссаныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 4 цаг 37 минут үргэлжилж, 18 цаг 55 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД